

БОЛОВСРОЛЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ДЭЛХИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

2026

2030 ОН ХҮРТЭЛХ УРВУУ ТООЛОЛ

ХҮРТЭЭМЖ БА ШУДАРГА ТЭГШ БАЙДАЛ

2030 ОН ХҮРТЭЛХ УРВУУ ТООЛОЛ

unesco

Sustainable Development Goals

Global Education Monitoring Report

БОЛОВСРОЛЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ДЭЛХИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ



Хүртээмж ба шударга тэгш байдал

2030 ОН ХҮРТЭЛХ УРВУУ ТООЛОЛ

Энэхүү хэвлэлийг Attribution-ShareAlike 3.0 IGO (CC-BY-SA 3.0 IGO) лиценз (http://creativecommons.org/licenses/by-sa/3.0/igo/)-ийн дагуу Нээлттэй хандалтад байршуулсан болно. Хэрэглэгчид энэхүү хэвлэлийн агуулгыг ашиглахдаа ЮНЕСКО-ийн Нээлттэй хандалтын сан (https://www.unesco.org/en/open-access/cc-sa)-гийн ашиглалтын нөхцөлийг хүлээн зөвшөөрөх шаардлагатай.

Энэхүү лиценз нь гагцхүү хэвлэлийн эхэд хамаарна. Од (*) тэмдэглэгээтэй зургууд нь https://creativecommons.org/licenses/by-sa/3.0/igo/ CC BY-SA 3.0 IGO лицензэд хамрагдахгүй бөгөөд тухайн зохиогчийн эрх эзэмшигчийн урьдчилсан зөвшөөрөлгүйгээр ашиглах, хуулбарлах, дахин нийтлэхийг хориглоно.

ЮНЕСКО нь нээлттэй хандалтын хэвлэн нийтлэгч бөгөөд бүх хэвлэлийг тус байгууллагын баримтын цахим сангаас үнэ төлбөргүй авах боломжтой. ЮНЕСКО-ийн аливаа хэвлэлийн арилжааны борлуулалт нь цаас эсвэл CD дээр хэвлэх, хуулбарлах, түгээх зэрэгтэй холбоотой бодит зардлыг нөхөх зорилготой юм. Аливаа ашгийн зорилго байхгүй болно.

Энэхүү хэвлэлд хэрэглэсэн нэршил болон материалыг илэрхийлсэн хэлбэр нь аливаа улс, нутаг дэвсгэр, хот, бүс нутаг, тэдгээрийн эрх бүхий байгууллагын эрх зүйн статус, эсхүл улсын хил хязгаарыг тогтоох талаар ЮНЕСКО-ийн ямар нэгэн албан ёсны байр суурь, санал бодлыг илэрхийлээгүй болно.

Энэхүү хэвлэлийг дараах байдлаар эшлэн ашиглаж болно: UNESCO. (2026). *Global Education Monitoring Report Summary 2026 - Access and Equity:* Countdown to 2030. Paris: UNESCO.



Дэлгэрэнгүй мэдээллийг:
Боловсролын хяналт - шинжилгээний дэлхийн тайлангийн баг ЮНЕСКО, 7, Фонтенуа талбай,
75352 Парис хот 07 SP, Франц Улс
И-мэйл хаяг: gemreport@unesco.org
Утас: +33 1 45 68 07 41
www.unesco.org/gem-report

Хэвлэлийн дараа илэрсэн аливаа алдаа, дутагдлыг www.unesco.org/gemreport хаягт байрших цахим хувилбарт залруулгаар оруулна.

© ЮНЕСКО, 2026
Бүх эрх хуулиар хамгаалагдсан.
Анхны хэвлэл
Нэгдсэн Үндэстний Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (7, Фонтенуа талбай, 75352 Парис хот 07 SP, Франц Улс)-аас эрхлэн гаргав.

График дизайн, зохион байгуулалт: ЮНЕСКО

Орчуулсан: Ч.Нямгэрэл

Эх бэлтгэл: Мөнхийн Үсэг ХХК

Хавтасны зургийн тайлбар: Зургаан настай Годфред, найзынхаа хамт Гана улсын зүүн бүсийн орон нутгийн жижиг хотод сургууль руугаа явж байна.

Зургийг: UNESCO GEM Report / Rooftop

https://doi.org/10.54676/LCIO5650
ED/GEMR/MRT/2026/S1

Боловсролын хяналт - шинжилгээний дэлхийн тайлангийн цуврал

2026 Хүртээмж ба шударга тэгш байдал: 2030 он хүртэлх урвуу тоолол
2024/5 Боловсрол ба манлайлал: Суралцахуйд манлайлах нь
2023 Боловсролын салбар дахь технологи: Хэний талд үйлчлэх хэрэгсэл вэ?
2021/2 Боловсролын салбар дахь төрийн бус оролцогч талууд: Хэн сонгож, Хэн алдах вэ?
2020 Тэгш хамралт ба боловсрол: Бүх нийт гэсэн бол бүх нийт л байх ёстой
2019 Шилжилт хөдөлгөөн, дүрвэлт ба боловсрол: Хана хэрэм биш гүүр барих нь
2017/8 Боловсролд хариуцлагатай хандах нь: Бидний үүрэг амлалтын биелэлт
2016 Хүмүүс, гараг дэлхийн төлөөх боловсрол: Бүх нийтийн төлөө тогтвортой ирээдүйг бүтээх нь

Бүх нийтийн боловсрол (БНБ)-ын хяналт - шинжилгээний дэлхийн тайлангийн цуврал

2015 Бүх нийтийн боловсрол 2000-2015: Ололт амжилт ба сорилтууд
2013/4 Сургахуй ба суралцахуй: Бүх нийтийн төлөө чанарыг ахиулах нь
2012 Залуучууд ба ур чадвар: Хөдөлмөрт нийцсэн боловсрол
2011 Далд хамрал: Зэвсэгт мөргөлдөөн ба боловсрол
2010 Эмзэг бүлгийнхэнд хүрэхүй
2009 Тэгш бус байдлыг даван туулах нь: Засаглал яагаад чухал вэ?
2008 Бүх нийтийн боловсрол 2015 онд: Бид хийж амжих уу?
2007 Бат бөх суурь: Бага насны хүүхдийн асаргаа ба боловсрол
2006 Аж төрөхийн тулд бичиг үсэгт тайлагдахуй
2005 Бүх нийтийн боловсрол: Чанарыг чанд сахихуй
2003/4 Жендэр ба бүх нийтийн боловсрол: Тэгш байдалд хүрэх өөрчлөлт
2002 Бүх нийтийн боловсрол: Дэлхий зөв чиглэлд явж байна уу?

Энэхүү тайлан болон холбогдох материалыг http://bit.ly/2026gemreport холбоосоор татаж авах боломжтой.

Инчоны Боловсрол 2030 тунхаглал болон Үйл ажиллагааны хүрээ баримт бичигт Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайлангийн чиг үүргийг тодорхойлохдоо "ТХЗ-уудын ерөнхий хэрэгжилтийг хянан үзэх, тоймлон дүгнэх ажлын хүрээнд үүрэг хүлээсэн холбогдох талуудыг үндэсний болон олон улсын стратегийн хэрэгжилтийг тайлагнах" хариуцлагын хамт "ТХЗ 4 болон боловсролын асуудлыг тусгасан бусад ТХЗ-ын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, тайлагнах механизм болно" гэжээ. Тайланг ЮНЕСКО-ийн бие даасан баг боловсруулан гаргадаг.

Уг тайланд дурдсан баримт мэдээллийн сонголт, танилцуулсан байдал, түүнчлэн илэрхийлсэн үзэл бодол, байр суурийн хариуцлагыг Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайланг боловсруулсан баг хүлээх ба ЮНЕСКО болон түс тайланг санхүүжүүлэгч байгууллагуудын албан ёсны байр суурийг заавал илэрхийлэхгүй бөгөөд ЮНЕСКО байгууллагыг албан ёсны байр сууриа илэрхийлсэнд тооцохгүй. Энэхүү тайланд илэрхийлсэн үзэл бодол, байр суурийн ерөнхий хариуцлагыг тайлан боловсруулсан багийн захирал хүлээнэ.

Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайланг боловсруулсан баг

Захирал: Манос Антонинис

Даниел Апрель, Марсела Барриос Ривера, Мадлен Барри, Екатерина Баскакова, Майкл Кэрни, Аруем Чо, Анна Кристина Д'Аддио, Рафаэла Мария Да Силва Сантос, Дмитрий Давыдов, Франческа Эндризци, Туаманая Фоймапафиси, Жульетта Фонт, Пабло Фрейзер, Лара Гил Бенито, Эмили Голдштейн, Пьер Гуедард, Приядаршани Жоши, Мария-Рафаэла Калди, Жозефин Киенже, Жоди Клю, Камила Лима Де Мораес, Кейт Линкинс, Кассиани Литрангомитис, Aurélia Mazoyer, Анисса Мечтар, Юки Мураками, Жудит Рандрианатоавина, Кейт Редман, Мария Рожнов, Дивья Шарма, Лаура Стипанович, Азиа-Катиана Тан, Дороти Ванг, Шифэн Жоу

Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайлан нь жил тутмын хараат бус хэвлэл юм. Энэхүү тайланг боловсруулах ажлыг засгийн газрууд, олон талт хөгжлийн агентлагууд, хувийн сангуудын нэгдэл санхүүжүүлж, ЮНЕСКО-ийн зүгээс зохих дэмжлэг үзүүлж, зохицуулалт хийсэн болно.

ҮНДСЭН САНАА

2030 он гэхэд улс орнууд бүх нийтийн боловсролын хүртээмжийг хангаж чадахгүй боловч энэ нь дэлхийн боловсролын хөтөлбөр бүтэлгүйтсэн гэсэн үг биш.

- 1990 онд тунхагласан бага боловсролын нийтлэг хүртээмж, 2000 онд дэвшүүлсэн бага боловсролыг бүх нийтээр эзэмших, 2015 онд дэвшүүлсэн дунд боловсролыг бүх нийтээр эзэмших гэсэн дэлхийн боловсролын гурван томоохон хөтөлбөр нь боловсролын тогтолцооны өргөжилтөөс илүү хурдтайгаар зорилтын түвшинг ахиулснаар эдгээр хөтөлбөрийн итгэл даах чадварыг сулруулсан.
- Сургуульд хамрагдаагүй хүүхэд, өсвөр үеийнхний тоон үзүүлэлтийн цаана хамран сургалт эрчимтэй өссөн гэсэн илүү эерэг дүр зураг бий. 2024 онд сургуульд 1.4 тэрбум суралцагч хамрагдаж байсан бөгөөд 2000 оноос хойш бага, дунд боловсролын хамран сургалт 327 сая суралцагч буюу 30%-аар өссөн байна. Мөн сургуулийн өмнөх боловсролын хамрагдалт 45%, дунд боловсролын дараах боловсролын хамрагдалт 161%-аар өссөн байна.
- Улс орнууд боловсролын шударга тэгш байдал, тэгш хамруулалтын талаарх бодлогын арга барилаа мөн шинэчилсэн. Засгийн газрууд боломж тааруу бүс нутаг, бүлгийг дэмжиж, боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд технологи, тээвэр, эрчим хүч, эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтыг ашигласан байна.

2015 оноос сургуульд хамрагдаагүй хүүхэд, залуучуудын эзлэх хувийн бууралт бүх бүс нутагт удааширсан байна.

- Сургуульд хамрагдаагүй хүүхэд, залуучуудын тоо 2000-2015 оны хооронд 33%-аар буурсан боловч түүнээс хойш долоо дахь жилдээ дараалан өссөөр 2015 оныхоос 3%-аар нэмэгдэж, 2024 онд 273 саяд хүрчээ. Энэ нь хүүхэд, өсвөр үеийнхэн, залуусын зургаа тутмын нэг нь боловсролын гадна үлдэж байна гэсэн үг.
- Хүмүүнлэгийн эх сурвалжийн нэмэлт мэдээлэл ашиглан зөрчил мөргөлдөөнд хамгийн их өртсөн 10 улсын дутуу өгөгдлийг нөхөж тооцвол, энэхүү хүн амын тоо дор хаяж 13 саяар дутуу тооцогдсон байна.
- Ахиц гаргах боломжтой. Зарим улс 2000 оноос хойш сургуульд хамрагдаагүй хүмүүсийн эзлэх хувийг дор хаяж 80%-аар бууруулсан байна. Тухайлбал, Мадагаскар, Того хүүхдүүдийн дунд, Морокко, Вьетнам өсвөр үеийнхэн дунд, Гүрж, Түрк залуусын дунд ийм ахиц гаргажээ.

Өнөөгийн энэ хурдаар үргэлжилбэл хүн бүрийг дунд боловсрол төгсөхөд хүргэж хэзээ ч чадахгүй байж болзошгүй.

- Сургуульд хамрагдаагүй хүүхдийн эзлэх хувь зогсонги байгаа хэдий ч илүү олон хүүхэд тухайн түвшний боловсролоо төгсөж байна. 2000 оноос хойш төгсөлтийн хувь бага боловсролд 77%-аас 88%, суурь боловсролд 60%-аас 78%, бүрэн дунд боловсролд 37%-аас 61% болж түс түс өсжээ. Тухайлбал, 2000 оноос хойш бүрэн дунд боловсролын төгсөлтийн хувь жилд нэг хувийн пунктээр өссөн байна.
- Одоогийн өргөжилтийн хурдаар үргэлжилбэл дэлхийн хэмжээнд 2105 он гэхэд бүрэн дунд боловсролын төгсөлтийн хувь 95%-д хүрнэ.
- Анги улиран суралцаж буй хүүхдийн эзлэх хувь 2000 оноос хойш бага боловсролд 62%-аар, суурь боловсролд 38%-аар буурсан нь төгсөлтийн хувь нэмэгдэж байгаа ч сургуульд хамрагдаагүй хүүхдийн эзлэх хувь яагаад зогсонги хэвээр байж болдгийг тайлбарлаж байна.
- Бага болон дунджаас доогуур орлоготой улсуудад олон хүүхэд сургуульд хожуу элсэн орж, анги улиран суралцсаар байгаа тул тэдний олонх нь боловсролын шат бүрийг хэдэн жилээр хоцорч төгсөж байна. Суурь боловсролын түвшинд “хугацаанд нь” (албан ёсоор төгсөх наснаас хойш гурваас таван жилийн дотор) болон “хожуу” (үүнээс ч хожим) төгсөлтийн хоорондын зөрөө нь дэлхийн хэмжээнд дөрвөн хувийн пункт, харин бага орлоготой улсуудад есөн хувийн пункт байгаа бөгөөд энэхүү зөрөө 2005 оноос хойш өссөөр байна.

Ахиц дэвшлийг тодорхойлох арга замыг сайжруулах шаардлагатай.

- 2030 хөтөлбөрт засгийн газрууд өөрсдийн нөхцөл байдалд нийцүүлэн үндэсний зорилтоо тогтоох ёстойг хүлээн зөвшөөрсөн. Гэвч энэ зарчмыг хэрэгжүүлэх чиглэлээр төдийлөн ажил хийгдээгүй бөгөөд боловсролын салбар үүнд үл хамаарах онцлох нэг тохиолдол байв. 2022 оноос хойш улс орнуудын 80% нь 2030 он гэхэд хүрэх найман үзүүлэлтийн үндэсний товлосон зорилтоо мэдээлсэн бөгөөд ахицыг ЮНЕСКО-ийн Статистикийн хүрээлэн болон Дэлхийн боловсролын хяналт-шинжилгээний тайлан жил бүр хянаж байна.
- Ижил төстэй түвшнээс эхэлсэн улс орнуудыг харьцуулснаар ахиц дэвшил илүү зөв ойлгогддог. Жишээлбэл, 2000-2024 онд Мексик сургуульд хамрагдаагүй хүүхэд, залуусын эзлэх хувийг Эль Салвадороос 20 гаруй хувийн пунктээр илүү бууруулсан; Сьерра Леон бага боловсролын төгсөлтийн хувийг Либериас 22 хувийн пунктээр илүү нэмэгдүүлсэн; Ирак дунд боловсролын төгсөлтийн хувийг Алжираас 10 пунктээр илүү нэмэгдүүлсэн.
- Шударга тэгш байдлын ахицыг хянахад дэлхийн түвшний үзүүлэлт болох тэгш байдлын индекс нь төдийлөн тохиромжтой биш. Учир нь энэ индекс тэгш бус байдлын төлөвөөс илүүтэй бүлгээр задалж буй үндсэн үзүүлэлтийн ахицыг илэрхийлдэг. Дүгнэлт хийж болох боловч чиг хандлагыг тухайн нөхцөл байдалтай уялдуулан шинжлэх шаардлагатай.

Зарим хэмжилтийн арга хэрэгслийг илүү мэдээлэл өгөхүйц болгон боловсронгуй болгох шаардлагатай.

- Сургуулийн өмнөх боловсролын хувьд 5 настай хүүхдүүдийн 75% нь боловсролд хамрагдаж байна гэсэн дэлхийн түвшний үзүүлэлт нь бага сургуульд орохоосоо өмнө сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдүүдийн эзлэх хувийг хэтрүүлэн тооцож байна. Учир нь тэдгээр хүүхдүүдийн 27% нь аль хэдийнээ бага боловсролд хамрагдаж байсан. Энэхүү тайланд бага сургуульд суралцагчдын дөнгөж 60% нь дор хаяж нэг жил сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан гэж тооцоолжээ.
- Бага болон дунд боловсролын хувьд гурван улс тутмын нэг нь хот, хөдөөгийн байршлын зөрүүг, хоёр улс тутмын нэг нь чинээлэг байдлаарх зөрүүг тайлагнадаггүй. Ихэнх тохиолдолд үүний шалтгаан нь боловсролын яамд судалгааны өгөгдлийн ач холбогдлыг хангалттай үнэлж, ашигладаггүй, эсвэл өгөгдөл нь байсан ч зөрүүг ил болгохоос цааргалдагт оршино.
- Дунд боловсролын дараах боловсролын түвшинд хамран сургалтын бохир жин нь ахицыг бодит байдлаас дээгүүр харуулдаг. Учир нь хамрагдсан хүмүүсийн олонх эцэстээ төгсдөггүй. 25-34 насныхны дээд боловсрол эзэмшсэн хувь нь 10 жилийн өмнөх хамран сургалтын бохир жингийн ердөө 60 орчим хувьтай тогтмол дүйж байна. 25-29 насныхны дээд боловсрол эзэмшсэн хувийг хяналт-шинжилгээний суурь үзүүлэлт, харин 30-34 насныхны дээд боловсрол эзэмшсэн хувийг хожуу төгсөлтийн хэмжүүр болгох нь зүйтэй.

Хүртээмж ба шударга тэгш байдлын хувьд урт хугацаанд гарсан ахицад энгийн ганц тайлбар байхгүй.

- Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо нэмэгдэх, шилжилт суурьших боломж, зөрчил мөргөлдөөний дараа сэргэж буй улс орнууд дахь энх тайван, тогтвортой байдлын үр өгөөж зэрэг боловсролын бодлогоос гадуурх хүчин зүйлс боловсролын урт хугацааны өргөжилтийг олон тохиолдолд тайлбарлаж болно.
- Туршилт судалгаанд суурилсан үнэлгээнүүд, тухайлбал боловсролд эрүүл мэнд, хоол тэжээлийн арга хэмжээ чухал болох талаар бодлогын чухал сургамж өгсөн. Гэвч “юу үр дүнтэй вэ” гэдгийг харуулахыг зорьдог богино хугацааны нөлөөллийн судалгааны үр дүнд хэтэрхий их анхаарах хандлага бас байна. Тэдгээр судалгаа нь боловсролын өргөжилтийг тогтвортой үргэлжлүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй чадавхтай институцийн талаар төдийлөн авч үздэггүй.
- Ганц шийдэл дангаараа үр дүнд хүрэхгүй. Энэ тайлан дахь бодлогын тойм шинжилгээнүүд нь институцийг хөгжүүлэх, боловсролын эрэлтийг дэмжих, боловсролын үйлчилгээний нийлүүлэлтийг бэхжүүлэхэд чиглэсэн хоорондоо уялдаатай, тухайн нөхцөл байдалд нийцсэн, тэнцвэртэй бодлогын багцын ач холбогдлыг онцолж байна.

Хүртээмжийг сайжруулахад чиглэсэн бодлогын томоохон хүчин чармайлтууд гарсан.

- 2000 оноос хойш тэгш хамруулах боловсрол (inclusive education)-ын хуультай улс орны эзлэх хувь 1%-аас 24% болж өссөн бол хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулах боловсролын орчинд сургахаар хуульдаа заасан улс орнуудын эзлэх хувь 17%-аас 29% болж нэмэгджээ. Тэгш хамруулах боловсролын тодорхойлолтыг баталсан улс орнуудын эзлэх хувь 2020 онд 68% байсан бол 2025 онд 84% болж өссөн; тодорхойлолт баталсан улс орнуудын дунд тэгш хамруулах боловсролыг хөгжлийн бэрхшээлээс илүү өргөн хүрээнд тодорхойлсон улсуудын эзлэх хувь 51%-аас 69% болж нэмэгджээ.
- 1998-2023 оны хооронд 158 улсын дунд 12 жилийн заавал суралцах боловсролын тогтолцоотой улсын эзлэх хувь 8%-аас 26% болж өссөн бол 130 улсын дунд үнэ төлбөргүй боловсролын дундаж хугацаа 10 жилээс 10.8 жил болж уртассан.

Боловсрол дахь шударга тэгш байдлыг сайжруулахын тулд нөөцийг дахин хуваарилах бодлогод шилжих хандлага ажиглагдаж байна.

- Боловсролын шударга тэгш үр дүнг хангахад санхүүжилт нь бодлогын чухал чиглэл юм. Бага, дунд боловсролын түвшинд орон нутгийн засаг захиргаа, сургууль, сурагч, өрхөд санхүүгийн шилжүүлэг олгох дөрвөн механизмыг хэрэгжүүлж, боломж тааруу хүн амын бүлгүүдэд үр өгөөжийг хүргэх эдгээр механизмын боломжийг ашиглаж буй улс орнуудын эзлэх хувь өнгөрсөн 25 жилд 4-6 дахин нэмэгджээ. Анхны суурь түвшин нь харьцангуй өндөр байсан сургуулийн хоолны хөтөлбөрүүд хоёр дахин нэмэгджээ.
- Гэвч шударга тэгш байдлыг хангахад чиглэсэн бодлогын төлөвлөсөн хамрах хүрээ, цар хэмжээг хэмждэг шинэ индексээс харахад 10 улс тутмын нэг хүрэхгүй нь бодлогодоо шударга тэгш байдлыг хангах асуудалд хангалттай анхаарч байна.
- Сургуулийн өмнөх боловсролд улс орнуудын 54% нь боломж тааруу хүүхдүүдэд боловсролын үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудад нөөцийг шилжүүлдэг бол 26% нь боловсролын яамаар, 55% нь өөр яамаар дамжуулан гэр бүлүүдэд нөөцийг шилжүүлдэг.
- Дунд боловсролын дараах боловсролд улс орнуудын гуравны нэг нь улсын их сургуулиудад сургалтын төлбөр авдаггүй, бараг тал хувь нь суралцагчдын байрны зардалд татаас олгодог, 10 улс тутмын 4 нь тээврийн дэмжлэг үзүүлдэг, 10 улс тутмын 3 хүрэхгүй нь сурах бичгийн зардалд татаас олгодог.

Дэлхийн хөгжлийн хөтөлбөр болон түүний боловсролыг авч үзэх хандлага ч өөрчлөгдсөн. Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр болон Тогтвортой Хөгжлийн Зорилт (ТХЗ)-ууд нь хүмүүс ба эх дэлхий, баян ба ядуу улс орнуудыг бүх нийтийг хамарсан нэгдмэл нэг хүрээнд нэгтгэсэн. Боловсролд төвлөрч байсан, 1990 онд эхлүүлсэн Бүх Нийтийн Боловсрол хөтөлбөрөөс ялгаатай нь, ТХЗ-ууд боловсролын үүргийн талаарх илүү өргөн ойлголтыг тусгаж, боловсрол нь хөгжлийн бусад үр дүнд хүрэхэд гол үүрэгтэй болохыг хүлээн зөвшөөрсөн. Бага боловсролд төвлөрч байсан, 2000 онд эхлүүлсэн Мянганы Хөгжлийн Зорилго (МХЗ)-оос ялгаатай нь боловсролын зорилго болох ТХЗ 4 нь боловсролын бүх түвшнийг хамардаг.

Дэлхийн боловсролын гурван хөтөлбөрийн дэлхийн хэмжээний зорилтот түвшин боловсролын тогтолцооны өргөжилтийн хурднаас түрүүлсэн. 1990 онд БНБ хөтөлбөр бага боловсролыг бүх нийтэд хүртээмжтэй болгох; 2000 онд МХЗ-2 бага боловсролыг бүх нийтээр төгсөх; 2015 онд ТХЗ-4 (бүрэн) дунд боловсролыг бүх нийтээр төгсөх зорилтыг тус тус дэвшүүлсэн. Эдгээр нь бодит нөхцөлтэй харьцуулахад хэт өндөр зорилтууд байсан боловч XXI зуунд боловсрол эзэмших эрх гэж юуг ойлгох талаарх үзэл ойлголт өөрчлөгдөж байсныг илэрхийлсэн. Гэвч 2030 он хүртэлх хугацааны дунд үе болох 2023 он гэхэд дунд боловсролыг бүх нийтээр төгсөх зорилт төдийгүй ТХЗ-4-ийн бусад, илүү өндөр зорилтуудын аль нь ч төлөвлөсөн замналаараа урагшлахгүй байгаа нь тодорхой болсон. Жишээлбэл, энэ тайлангийн хамгийн сүүлийн мэдээллээс харахад сургуульд хамрагдаагүй хүүхэд, залуусын тоо сүүлийн долоон жил дараалан өсөж, 273 сая хүрсэн бол залуучуудын ердөө гуравны хоёр нь дунд боловсролоо төгсөж байна.

“2030 он хүртэлх урвуу тоолол” цуврал нь дэлхийн боловсролын хөтөлбөрүүдээс авсан сургамжийг эргэн харж, нэгтгэн дүгнэдэг. 2030 оны эцсийн хугацаа ойртож, олон талт хамтын ажиллагаа хүндрэлтэй тулгарч буй энэ үед ТХЗ-4-т хүрэх чиглэлд улс орнуудын туулсан олон янзын замналыг ойлгохын тулд өгөгдөл болон улс орнуудын туршлагыг ашиглах шаардлагатай байна. Дэлхийн боловсролын хяналт-шинжилгээний тайлангийн энэхүү дугаар нь гарсан ахицыг нэгтгэн дүгнэх, 2030 оноос хойших боловсролын хөтөлбөрийн талаарх хэлэлцүүлгийн хүрээг тодорхойлох зорилготой, гурван хэсгээс тогтох “2030 он хүртэлх урвуу тоолол” цуврал эхний хэсэг юм. Уг цуврал нь эхлээд сүүлийн 25 жилд боловсролын гол үзүүлэлтээр ижил төстэй улс орнуудаас илүү хурдтай ахисан улс орнуудыг тодорхойлж, дараа нь ийм гүйцэтгэлд холбоотой хүчин зүйл, бодлогыг кейс судалгаа болон судалгааны үр дүн, дүгнэлтэд тулгуурлан шинжилсэн өгөгдөл ба өгүүлэмжийг хослуулдаг.

“2030 он хүртэлх урвуу тоолол” гурван хэсэгт цуврал нь хүртээмж, чанар, нийцлийг харилцан уялдаатай гурван түлгуур чиглэл гэж үздэг. Гурван тайлан тус бүр хүртээмж ба шударга тэгш байдал (2026), чанар ба суралцахуй (2027), нийцэл (2028/9) гэсэн хөтөлбөрийн нэг нэг гол хэмжигдэхүүнд төвлөрнө. Эдгээр хэмжигдэхүүн тус бүрийг өөр өөр аргаар үнэлж болох боловч энэ гурван талбар нь харилцан уялдаатай. Бүтцийн тохируулгын хөтөлбөрүүдийн улмаас төрийн санхүүжилт олон жил танагдсаны дараа, 2000 оноос хойш харьцангуй ядуу улс орнуудад боловсрол хурдацтай өргөжсөн нь эерэг үзэгдэл мэт байсан ч чанар буурахтай олонтоо давхацжээ. Олон залуус бага зүйл сурч, эзэмшиж буй боловсрол нь ирээдүйн амьдралын боломжтой нь төдийлөн нийцэхгүй гэж үзсэний улмаас боловсролоос хөндийрч, сургуулиа эрт орхисон. Нийцэл бол чанарын суурь юм: боловсрол нь суралцагчийг амьдралд, ялангуяа технологийн нөлөө, авторитаризм, уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтол, нийгмийн бүтцийн өөрчлөлт зэрэг улам эрчимжиж буй дэлхий нийтийн сорилтуудын нөхцөлд бэлтгэх ёстой. Гурван тайлангийн түршид шударга тэгш байдал нь эдгээр хэмжигдэхүүнийг хооронд нь холбох гол шугам болно: хүртээмж нэмэгдэхийн хэрээр шударга тэгш байдлын талаарх анхаарал суралцахуй болон нийцэл, өөрөөр хэлбэл суралцагчдын хөгжүүлж буй чадавх болон тэдэнд нээлттэй боломж руу шилжинэ. Ингэснээр боловсрол тэгш бус байдлыг дахин бий болгож, хадгалахын оронд түүнийг бууруулахад хувь нэмэр оруулж чадна.

Хүртээмж ба шударга тэгш байдлыг ТХЗ-ын дэлхийн болон сэдэвчилсэн таван үзүүлэлтээр шинжилдэг. Үзүүлэлт 4.2.2 нь бага боловсролд элсэх наснаас нэг жилийн өмнөх (ихэвчлэн 5 нас) зохион байгуулалттай сургалтад хамрагдсан байдлыг хэмждэг боловч хүүхэд сургуулийн өмнөх боловсрол, эсвэл сургуулийн алинд хамрагдаж байгааг ялгадаггүй. Үзүүлэлт 4.1.4 нь бага сургуулийн насны хүүхэд, суурь боловсролын насны өсвөр үеийнхэн, бүрэн дунд боловсролын насны залуучуудын сургуульд хамрагдаагүй эзлэх хувь юм. Энэ үзүүлэлтийг захиргааны мэдээлэлд үндэслэн тооцож, загварчилсан тооцоо болон хожуу элсэлт, нас хэтэрсэн хамран сургалт, анги улиран суралцах түвшний шинжилгээгээр нөхөн баяжуулдаг. Үзүүлэлт 4.1.2 нь бага, суурь, бүрэн дунд боловсролын төгсөлтийн эзлэх хувь юм. Үүнийг өрхийн судалгаанд үндэслэн, хожуу төгсөгчдийг хамруулахын тулд тухайн түвшний албан ёсны төгсөх наснаас 3-5 насаар ах хүмүүсээр тооцдог. Үзүүлэлт 4.3.2 нь дээд боловсролын хамран сургалтын бохир жин бөгөөд олон янзын хөтөлбөрийн төрөл, насны бүлгийг нэгтгэн тооцдог. Сургууль завсардалт өндөр улс орнуудад энэ үзүүлэлт ахицыг бодитоос өндөр харагдуулж болох тул боловсрол эзэмшсэн түвшний үзүүлэлтийг нэмэлт хэмжүүр болгон авч үзэх шаардлагатайг харуулж байна. Үзүүлэлт 4.5.1 буюу тэгш байдлын индекс нь хүйс, байршил, хөрөнгө чинээ, хөгжлийн бэрхшээл зэрэг шинжээр тодорхойлсон боломж тааруу болон давуу нөхцөлтэй бүлгүүдийн үзүүлэлтийн утгыг харьцуулдаг.

Суурь болгож буй үзүүлэлтийн утга өсөхийн хэрээр тэгш байдлын индексүүд сайжрах хандлагатай байдаг тул улс орнуудыг хооронд нь энгийнээр харьцуулах нь шударга тэгш байдлын ахицыг зөв хянах боломжгүй байж болно.

Тайланд багтсан улс орны кейс судалгаануудыг эдгээр үзүүлэлтэд үндэслэн сонгосон. Эхний алхам нь 10 хүртэлх жилийн шилжих хугацааны цонх бүрээр улс орнуудын жилийн дундаж өсөлтийн хурдыг тооцоолж, эхлэлийн түвшнээр нь таван бүлэгт ангилах явдал байв. Учир нь ахицын хурд нь улс орон ямар түвшнээс эхэлснээс хамаардаг. Дараа нь тухайн хугацаан дахь жилийн дундаж өсөлтийн хурд нь 75-р процентилоос дээш (хурдан), 25-р процентилоос доош (удаан) байсан эсэхээр нь улс орнуудыг тодорхойлсон. Мөн сүүлийн үеийн өгөгдөл байгаа эсэх, тайлбарлагдаагүй хэлбэлзэл бүхий тохиолдлуудыг хасах эсэхийг нэмж шалгасан. Эцэст нь, бүс нутаг, орлогын түвшин, хүн амын хэмжээг төлөөлөх байдлыг харгалзан хурдан болон удаан ахицтай улс орнуудын бүлгээс кейс судалгаанд хамруулах улс орнуудыг сонгосон.


Цөөн тохиолдолд улс орны сонголт энэ арга зүйгээс бага зэрэг зөрсөн. Бага насны хүүхдийн боловсролд хамрагдалтын үзүүлэлт (4.2.2.)-ийн хувьд хамрагдалтын хувь нь ихэнхдээ 100%-д ойртсон өндөр орлоготой улс орнуудаас нэгийг сонгохын тулд уг үзүүлэлтийн оронд нь сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жинг ашигласан. Сургуульд хамрагдаагүй хүүхэд, залуучуудын эзлэх хувь (4.1.4) болон төгсөлтийн хувь (4.1.2) гэсэн хоёр үзүүлэлтийг боловсролын гурван түвшинд шинжилсэн бөгөөд өргөжилтийн хэв маягийн ялгаа хамгийн тод ажиглагддаг залуучууд/бүрэн дунд боловсролын түвшнээс ихэнх кейс судалгааг сонгосон (Зураг 1). Дээд боловсролын хамран сургалтын бохир жин (4.3.2)-г ашиглан улс орнуудыг сонгох нь харьцангуй хялбар байв. Эцэст нь, шударга тэгш байдлыг авч үзэхдээ хүйс, байршил, бүс нутаг, хөрөнгө чинээ гэсэн дөрвөн шинжээр төгсөлтийн хувийн тэгш байдлын индексийг шинжилсэн. Зөвхөн ахиц гаргасан улс орнуудыг хамруулсан. Хөгжлийн бэрхшээлийн хувьд чиг хандлагын өгөгдөл байхгүй тул НҮБ-ын Хүүхдийн сангийн бүс нутгийн мэдээллийн санг ашиглаж, улс орны сонголтыг хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг ердийн сургуульд хамруулах чиглэлд гарсан ахицад үндэслэн хийсэн.

Энэ тайланг ТХЗ-4-ийн жишиг тогтоох үйл явцын зарчимд түлгуурласан. Сүүлийн жилүүдэд улс орнуудын 80% орчим нь ТХЗ-4-ийн үндсэн багц үзүүлэлтээр 2025, 2030 онд хүрэх үндэсний товлосон зорилт буюу жишгээ тогтоосон. ЮНЕСКО-ийн Статистикийн хүрээлэн, Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайлангийн удирдан хэрэгжүүлдэг энэхүү үйл явц нь өндөр түвшин зорьсон дэлхийн зорилгуудыг улс орны нөхцөлд нийцсэн үндэсний товлосон зорилт болгон хөрвүүлж, төсөвтэй уялдуулахад тусалдаг. Улс орнууд өөрсдийн хүлээсэн үүрэг амлалтаа биелүүлэх төлөвийг жил бүрийн ТХЗ-4-ийн Үнэлгээний картаар хянадаг. Энэ үйл явц нь улс орнуудад бодитой атлаа өндөр түвшнийг зорьсон товлосон зорилт тогтооход дэмжлэг үзүүлэх механизм бүрдүүлж, боловсролын ахицын талаарх үндэсний болон олон улсын хэлэлцүүлэгт нийтлэг баримжаа бий болгохын зэрэгцээ хариуцлагыг бэхжүүлэхийг зорьдог.

ЗУРАГ 1.

ТХЗ-ын дэлхийн үзүүлэлт 4.1.2-ын жилийн дундаж өсөлтийн хурдны тархалт

Төгсөлт (бага, суурь, бүрэн дунд боловсрол)-ийн хувийн 10 жилийн шилжих хугацааны цонх бүр дэх жилийн дундаж өсөлтийн хурд (хувийн пункт), хугацаа бүрийн эхлэлийн утгаар бүлэглэсэн, 2000-24



Тэмдэглэл: Цайвар өнгийн цэгүүд нь интерполяц хийсэн өгөгдөл бүхий үеийг илэрхийлнэ. Эхлэлийн утгын квинтилиуд нь дараах мужуудыг хамарна: квинтиль 1 (0%–20%), квинтиль 2 (20%–42%), квинтиль 3 (42%–66%), квинтиль 4 (66%–84%), квинтиль 5 (84%–95%). Квинтиль тус бүрийн хоёр тасархай шугам нь өсөлтийн хурдын 25, 75-р процентилийг тус тус илэрхийлнэ. Сонгогдсон улс бүрийн хувьд ахицтай эсвэл зогсонги гэж тодорхойлсон хамгийн сүүлийн үеийг зураг онцлон харуулсан.

Эх сурвалж: VIEW мэдээллийн санд үндэслэсэн Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайлангийн багийн шинжилгээ.

Гурван багц нотолгоог ашиглан гурван асуултыг авч үзсэн. “2030 он хүртэлх үрвуу тоолол” цувралын логикийн дагуу тайлан дараах гурван асуултыг авч үзсэн: ижил төстэй түвшнээс эхэлсэн улс орнуудаас аль нь бусдаасаа илүү хурдацтай ахисан бэ; тэдний ахиц дэвшил, эсвэл ахиц гараагүй байдлыг ямар хүчин зүйлс тайлбарлаж байна вэ; эдгээр үр дүнгээс ирээдүйн дэлхийн хөтөлбөрийн боловсролын хүртээмж, шударга тэгш байдлын асуудлаар ямар дүгнэлт хийж болох вэ? Үүний тулд гурван багц нотолгоог ашигласан: 2000 оноос хойших олон улсын өгөгдөлд хийсэн чиг хандлагын шинжилгээ; дээр тайлбарласан арга зүйн дагуу сонгосон 35 улсын кейс судалгаа; зарим улсын ахицад юу түлхэц өгч, бусад зарим улсын ахицыг юу саатуулсныг тайлбарлахад чиглэсэн бодлогын тойм шинжилгээ. Мөн гурван үндсэн бүлэг хүчин зүйлийг тодорхойлсон: боловсролын дотоод хүчин зүйл (бодлого); боловсролын гадаад хүчин зүйл (тухайлбал, түүх, газарзүй, соёл, хүн ам зүй, улс төр); боловсролд нөлөөлөхийн зэрэгцээ өөрсдөө боловсролын нөлөөнд ордог завсрын хүчин зүйл (тухайлбал, эдийн засгийн өсөлт, хөдөлмөрийн зах зээл, ядуурал, хотжилт, зөрчил мөргөлдөөн).

Боловсролын өргөжилтийн урт хугацааны тодорхойлогч хүчин зүйлсийг судалсан судалгаа цөөн байдаг. “Нотолгоонд суурилсан бодлого” гэх нэрийн дор “юу үр дүнтэй вэ” гэсэн өгүүлэмж дээр төвлөрөх хандлага байдаг бөгөөд ийм өгүүлэмж нь ихэвчлэн тодорхой арга хэмжээний үр нөлөөг нарийн чанд туршилтаар үнэлсэн судалгаанд тулгуурладаг. Эдгээр судалгаа нь боловсролын өөрчлөлтийг хөдөлгөгч чухал хүчин зүйл, ялангуяа эрүүл мэнд, хоол тэжээл зэрэг боловсролын салбараас гадуурх хүчин зүйлийг тодруулахад чухал хувь нэмэр оруулсан. Гэвч ийм судалгааны ихэнх нь хяналттай нөхцөл дэх богино хугацааны үр нөлөөг судалсан байдаг. Тэдгээр нь үр дүнг хэдэн жилээс цааш дагаж судалсан нь ховор бөгөөд хэдэн арван жилийн турш хамрагдалтыг өргөн цар хүрээнд өргөжүүлж, тогтвортой үргэлжлүүлэх арга замыг бараг авч үздэггүй. Харин энэ тайлан чухам ийм хугацааны цар хүрээг авч үзэж байна. Тайлан уншигчдыг “түс түсдаа ямар арга хэмжээ статистикийн ач холбогдол бүхий нөлөө үзүүлж байна вэ гэж асуухаас илүүтэй, хамрагдалт болон шударга тэгш байдал улс орны хэмжээнд урт хугацаанд ахихад юу нөлөөлж байна вэ гэж асуух” руу шилжиж харах өнцгөө өөрчлөхийг уриалж байна. Өргөн цар хүрээний ахиц нь бараг хэзээ ч ганц хүчин зүйлээс бий болдоггүй, харин салбар дамнасан уялдаатай үйл ажиллагаа, улс төрийн тууштай дэмжлэг, хэрэгжүүлэх чадавх, орон нутгийн нөхцөлд нийцүүлэн зохицуулах үйл явцын үр дүнд бий болдог гэж дүгнэлээ.

Нөхцөл байдал чухал боловч улс орнуудад нийтлэг тодорхой зарчмууд ажиглагддаг байна. Хэнийг ч орхигдуулахгүй байх улс төрийн үүрэг амлалтыг илүү чанартай задаргаатай өгөгдлөөр дэмжихийн зэрэгцээ хууль эрх зүй, санхүүжилт, нийгмийн хамгааллын тогтолцоотой уялдуулах шаардлагатай. Олон улсын хөтөлбөрийн үүрэг нь бүхүлсад нэгэн адил шийдэлтулгах бус, харин хэлэлцүүлгийн талбараар хангахад оршино. Олон улсын хөтөлбөр нь өнгөрсөн 80 жилийн хугацаанд, зарчим болон механизмын

сууpь багцад тулгуурласан нийтлэг үүрэг амлалтыг улс орон бүр өөрөөр тодорхойлох зарчимтай тэнцвэртэй хослуулах ёстой. Өөрөөр хэлбэл, улс орнууд эдгээр зарчмыг өөрсдийн нөхцөл байдалд нийцүүлэн өөрчилж, механизмуудыг мөн тухайн нөхцөлдөө тохируулан хэрэгжүүлэх боломжтой байх ёстой.

Энэхүү тайланд шударга тэгш байдлыг хангахад чиглэсэн санхүүжилтэд онцгой анхаарал хандуулсан. Боловсролын тэгш бус байдалд нөлөөлдөг олон төрлийн бодлого байдгийг харгалзан үзэхийн зэрэгцээ энэхүү тайланд тэдгээрээс нэг багц бодлогыг, тухайлбал боловсролын боломжийг тэгшитгэхийн тулд төрийн санхүүжилтийг ашиглан боломж тааруу орон нутгийн засаг захиргаа, сургууль, суралцагчид (эсвэл тэдний өрх)-д нөөц чиглүүлэхтэй холбоотой бодлогуудыг сонгон авч үзсэн. Бүх улсын мэдээллийг PEER вэбсайтад зориулан танилцуулга хэлбэрээр боловсруулсан бөгөөд улс орнууд боловсрол дахь шударга тэгш байдлыг сайжруулахын тулд нөөцийг зориудаар дахин хуваарилж бүй түвшнийг үнэлэх индекс боловсруулсан. Мөн энэ чиглэлийн бодлого өнгөрсөн 25 жилийн хугацаанд улс орнуудад хэрхэн өөрчлөгдсөнийг шинжилсэн. Энэ нь PEER вэбсайтын шинэчлэлийн нэг хэсэг бөгөөд түс вэбсайт сонгосон хууль тогтоомж, бодлогууд 2000 оноос хойш хэрхэн хувьсан өөрчлөгдсөнийг, эхний ээлжид тэгш хамруулалтаас эхлэн судлах болно.

Энэхүү тайлан өмнөх хэвлэлүүдээсээ өөр бүтэцтэй. Сургуулийн өмнөх боловсрол, бага ба дунд боловсрол, дунд боловсролын дараах боловсрол, шударга тэгш байдал гэсэн дөрвөн үндсэн бүлэг ижил бүтэцтэй. Нэгдүгээрт, голлон авч үзэж бүй үзүүлэлтүүдийн чиг хандлагыг тоймлон шинжилж, үүний зэрэгцээ илүү анхаарал хандуулах шаардлагатай бөгөөд боловсролын ирээдүйн хөтөлбөрийн хэрэгжилтийг хянахдаа харгалзан үзэх ёстой гол асуудлуудыг тодорхойлсон. Хоёрдугаарт, голлон авч үзэж бүй таван үзүүлэлт (бага ба дунд боловсролын тухай бүлэгт сургуульд хамрагдаагүй хүүхэд, залуучуудын эзлэх хувь болон төгсөлтийн хувийн үзүүлэлтүүдийн кейс судалгааг нэгтгэн авч үзсэн) түс бүрээр улс орны долоон кейс судалгааг цагаан толгойн дарааллаар танилцуулсан. Гуравдугаарт, гаднын шинжээчдээр хийлгэсэн гурван тойм судалгаанаас авсан үр дүн, дүгнэлт, Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайлангийн багийн холбогдох судалгааны бүтээлүүдэд хийсэн шинжилгээ, мөн кейс судалгаанаас гарсан сургамжийг нэгтгэсэн боловсролын бодлогын шинжилгээг танилцуулсан.

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ

ГОЛ ЧИГ ХАНДЛАГА

Бага насны хүүхдийн боловсрол өнгөрсөн 25 жилийн хугацаанд өргөжин тэлсэн. Нас түс бүрээр гаргасан өгөгдлөөс үзэхэд дэлхийн хэмжээнд 3 настай хүүхдүүдийн 42%, 4 настай хүүхдүүдийн 59%, 5 настай хүүхдүүдийн 80% орчим нь боловсролд хамрагдаж байна. Нас ахихын хэрээр хамрагдалт хамгийн огцом нэмэгддэг үе нь 4–5 насны хооронд байдаг бол бага орлоготой орнуудад хамгийн их өсөлт 5–6 насны хооронд ажиглагддаг. Бага сургуульд элсэх нас улс орон бүрд ялгаатай бөгөөд уг наснаас нэг жилийн өмнөх хамрагдалтын хувь 2003 онд 64% байсан бол 2024 онд 75% болж өссөн.

Гэвч 2015 оноос хойш ахиц эрс удааширсан бөгөөд үүнд КОВИД-19 цар тахал тодорхой хэмжээгээр нөлөөлсөн. 2000–2015 оны үетэй харьцуулахад 2015 оноос хойш хамрагдалтын ахицын хурд гуравны хоёроор саарсан. КОВИД-19 цар тахлын улмаас сургуулийн өмнөх боловсролын насны хүүхдийн хамран сургалтын хувь түр хугацаанд 5%-аар буурч, зарим бүс нутагт энэ бууралт 10%-д хүрсэн. Бүс нутгуудын ялгаа их хэвээр байна: Европт сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 2000–2024 онд 73%-аас 90% болж өссөн бол Сахарын цөлөөс өмнөх Африкт сургуулийн өмнөх боловсролын насны хүүхдүүдийн 25 хүрэхгүй хувь нь боловсролд хамрагдаж байна.

Сургуулийн өмнөх боловсролын ахицыг үнэлэх нь гол үзүүлэлтүүдээс харагдаж байгаагаас илүү төвөгтэй. Хүүхдүүд албан ёсны наснаасаа эрт бага сургуульд элсдэг практик нь хэмжилтийг будлуулдаг. Учир нь уг хэмжилт тодорхой насны хүүхэд боловсролд хамрагдаж байгаа эсэхийг л үнэлэхээс бус, боловсролын аль түвшинд хамрагдаж байгааг нь ялгадаггүй. Дэлхийн хэмжээнд бага сургуульд элсэх наснаас нэг жилийн өмнөх насны хүүхдүүдийн 27% нь аль хэдийн бага сургуульд хамрагдсан байдаг. Энэ үзүүлэлтэд Энэтхэгийн нөхцөл байдал ихээхэн нөлөөлдөг бөгөөд түс улсад 5 настай хүүхдүүдийн 51% нь аль хэдийн бага сургуульд хамрагдсан байна. Руандад 5 настай хүүхдүүдийн хамрагдалт нэмэгдсэн боловч энэ нь тэдний дунд аль хэдийн бага сургуульд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь өссөнтэй холбоотой байв. Харин Камерунд 5 настай хүүхдүүдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан эзлэх хувь нэмэгдэж байсан ч нийт хамрагдалт буурсан байна. Эдгээр жишээ нь хүүхдүүд бага сургуульд эрт элсэж байгаагаас шалтгаалан хамрагдалтын гол үзүүлэлт өсөж болохын зэрэгцээ бага насны хүүхдийн боловсролын үйлчилгээ өргөжиж байсан ч уг үзүүлэлт өөрчлөлтгүй, бүр буурч байгаа мэт харагдаж болохыг харуулж байна.

Хэдэн хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байсныг тооцоолоход өөр арга хэрэгтэй. Эцсийн дүнд голлон сонирхож буй үзүүлэлт нь сургуульд орохоосоо өмнө хэдэн хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байсан бэ гэдэг юм. Үүнийг тооцоолох нэг арга нь бага сургуульд эрт элссэн хүүхдүүдийг тооцооноос хасах бөгөөд ингэснээр дэлхийн үзүүлэлт 75%-аас ойролцоогоор 55% болж буурна. Илүү нарийвчлалтай арга нь нас тус бүрээр, боловсролын түвшнээр ангилсан хамран сургалтын өгөгдлийг ашиглан одоо бага сургуульд элсэх насанд байгаа хүүхдүүд өмнө нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан эсэхийг тооцдог. Энэ аргаар хүүхдүүдийн 59% нь (бага орлоготой орнуудад 36%, өндөр орлоготой орнуудад 86%) сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байсан гэж тооцоолсон. Харин 30% нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаагүй ч аль хэдийн бага сургуульд элссэн, 11% нь хараахан боловсролд хамрагдаагүй байна (Зураг 2). Гэхдээ энэ арга нь насны бүлгүүдийн хүүхдийн тоо тогтвортой байх, мөн хамрагдалт богино хугацаанд огцом өргөжөөгүй байх гэсэн нөхцөлд тулгуурладаг. Эдгээр нөхцөл хангагдахгүй бол уг арга хамрагдалтыг бодит хэмжээнээс өндөр тооцоолдог.

ЗУРАГ 2.

Тооцоолсноор 10 хүүхэд тутмын 6 нь сургуулийн өмнөх боловсролд өмнө нь хамрагдсан байна

Бага боловсролд элсэх албан ёсны насны хүүхдүүдийн хамран сургалтын байдал болон сургуулийн өмнөх боловсролын хамрагдалтыг тооцоолсон тархалт, улс орны орлогын бүлгээр, 2024 он эсвэл мэдээлэл байгаа хамгийн сүүлийн он



Тэмдэглэл: Тооцооллыг нас тус бүр болон боловсролын түвшнээр ангилсан хамран сургалтын өгөгдөлд үндэслэн хийсэн бөгөөд насны бүлгийн хүүхдийн тоо тогтвортой, мөн хүүхдүүд сургуулийн өмнөх боловсролд нэгэнт хамрагдсан бол бага сургуулийн нэгдүгээр анги хүртэл дор хаяж үргэлжлүүлэн суралцдаг гэж үзсэн.

БХШ-ний статистик: https://bit.ly/GEM2026_Summary_fig2

Эх сурвалж: ЮНЕСКО-ийн Статистикийн хүрээлэнгийн мэдээллийн санд үндэслэсэн БХШ-ний тайлангийн багийн шинжилгээ.

3 нас хүрээгүй хүүхдүүдийн хамрагдалтыг хянах нь ихээхэн хүндрэлтэй. Бага насны хүүхдийн боловсрол гэдэгт юуг хамруулах талаарх ялгаатай ойлголт, мөн удирдлага, зохицуулалтын олон янзын арга барил нь бага насны хүүхдийн хамрагдалтыг хэмжихэд хүндрэл учруулдаг. Тухайлбал, боловсролын зэрэгцээ хүүхдийн асаргааг хамруулсан өргөн хүрээний тодорхойлолтыг хэрэглэвэл хамран сургалтын хувь Францад 5%-аас 59%, Европын хэмжээнд 20%-аас 39% болж өснө. Гэр бүлүүдийн сонголт харилцан адилгүй байдаг тул бүх нийтийн хамрагдалтыг бүх тохиолдолд илүүд үзэх үр дүн гэж үздэггүй. Европын Холбоо 2030 он гэхэд хамрагдалтын хувийг 45%-д хүргэх зорилт тавьсан.

УЛС ОРНЫ КЕЙС СУДАЛГАА

Улс орны кейс судалгаанууд нь 2000 оноос хойш дэлхийн улс орнуудад хуримтлагдсан олон янзын туршлагыг харуулж байна. **Азербайжанд** хууль эрх зүйн цогц тогтолцоог бүрдүүлж, одоо байгаа бага сургуулиудын дэргэд үнэ төлбөргүй, төрөөс бүрэн санхүүжүүлдэг сургуульд бэлтгэх сургалтыг нэвтрүүлэн, тэдгээрийг хариуцах чиг үүргийг боловсролын яаманд шилжүүлснээр таван жилийн дотор сургуулийн өмнөх боловсролын бараг бүх нийтийн хүртээмжийг бий болгож чадсан. Энэхүү тогтолцоог богино хугацаанд өргөн хүрээнд нэвтрүүлсэн нь багшлах боловсон хүчний чадавхыг нэмэгдүүлэх шаардлага зэрэг хэрэгжилтийн зарим сорилтыг дагуулсан. Мөн хөрөнгө чинээ болон хөгжлийн бэрхшээлээс шалтгаалсан хүртээмжийн зөрүүг арилгахын тулд цаашид ч тууштай анхаарах шаардлагатай байна. **Камерунд** 5 настай хүүхдүүдийн 41 орчим хувь нь боловсролд хамрагдаж байгаа бөгөөд энэ үзүүлэлт 2015 оноос хойш ерөнхийдөө тогтвортой байна. Нийт хамрагдалт нэмэгдээгүй боловч хамрагдсан хүүхдүүдийн бүрэлдэхүүн өөрчлөгдөж, бага сургуульд эрт элсэхийн оронд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй хүүхдийн эзлэх хувь нэмэгдэж байна. Ялангуяа Алс Хойд, Баруун Хойд болон Баруун Өмнөд бүс нутагт зэвсэгт мөргөлдөөн, аюулгүй бус байдал, албадан шилжилт хөдөлгөөнөөс шалтгаалан сургуулиуд хаагдсан нь ахицад ноцтой саад учруулжээ. Үүний зэрэгцээ төрийн хөрөнгө оруулалт бага төдийгүй буурч байгаа нь хувийн үйлчилгээ үзүүлэгчдээс хамаарах хамаарлыг нэмэгдүүлсэн бөгөөд тэдгээрийн үйлчилгээний өндөр өртөг нь орлого болон байршлаас шалтгаалсан зөрүүг улам нэмэгдүүлжээ.

Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад 5 настай хүүхдүүдийн хамран сургалтын хувь 2000 онд 10 орчим хувь байсан бол 2023 онд 67 хувь болж огцом өссөн. Үүнд Засгийн газар олон зуун цэцэрлэг нээж, бага сургуулийн дэргэдэх бэлтгэл хөтөлбөрүүдийг нэвтрүүлж, орон нутагт түшиглэсэн сургуулийн өмнөх боловсролын төвүүд бий болгохыг дэмжсэн нь голлон нөлөөлжээ. Засгийн газар

байршил, ядуурал, үндэстний цөөнхийн оршин суугаа байдлыг харгалзан сонгосон 40 дүүрэгт тэргүүлэх ач холбогдол өгдөг. Хөгжлийн түншүүд ч дэмжлэгээ эдгээр дүүрэгт чиглүүлсэн нь тэгш бус байдлыг бууруулахад хувь нэмэр оруулжээ. **Ливанд** 5 настай хүүхдүүдийн хамран сургалт 2000 он гэхэд аль хэдийн бараг бүх нийтийн түвшинд хүрсэн байсан боловч сүүлийн жилүүдэд зөрчил мөргөлдөөн, албадан шилжилт хөдөлгөөн, хямралууд, төрийн институцийн сул байдал нь боловсролын үйлчилгээг тогтвортой үзүүлэхэд хүндрэл учруулж байна. Цэцэрлэгийн гуравдугаар анги болон бага сургуулийн нэгдүгээр ангийн хамран сургалтыг харьцуулсан дүнгээс үзэхэд долоон хүүхэд тутмын нэг орчим нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаагүй байна. Хүүхдүүдийн ердөө 20% нь улсын сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдаж, боловсролд зарцуулах төрийн зардал ДНБ-ий 2%-аас доогуур байгаа тул боловсролын тогтолцоо хувийн хэвшлээс ихээхэн хамааралтай бөгөөд шударга тэгш бус хэвээр байна. Үүний улмаас тус тогтолцоо санхүүгийн хүнд хямралын дараах ядуурлын өсөлтөд эмзэг болж, хамрагдалт, ялангуяа хамгийн бага насны хүүхдүүдийн хамрагдалт буурчээ. Сирийн дүрвэгч хүүхдүүдийн ердөө 18% нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдах боломжтой байна.

Литвад 3–5 настай хүүхдүүдийн бага насны хүүхдийн боловсролын хамрагдалт 2013 онд 82 орчим хувь байсан бол 2023 онд 95 хувь болж өссөн бөгөөд 3 нас хүрээгүй хүүхдүүдийн хамрагдалт ч мөн огцом нэмэгджээ. Үүнд төрөөс зарцуулах хөрөнгийг үлэмж нэмэгдүүлж, хүүхэд тус бүрээр санхүүжүүлэх загварыг нэвтрүүлэхийн зэрэгцээ 2 наснаас эхлэн бага насны хүүхдийн боловсролд хамрагдах боломжийг үе шаттайгаар баталгаажуулсан бодлого голлон нөлөөлсөн. Шударга тэгш байдлын үр дүн мөн сайжирсан боловч хамрагдалтын хувьд орлогоос шалтгаалсан болон хөдөө, хотын хоорондын мэдэгдэхүйц зөрүү хэвээр байна. **Мадагаскарт** ядуурлын түвшин дэлхийд хамгийн өндөр орнуудын нэг хэдий ч 5 настай хүүхдүүдийн хамран сургалт 2000 онд 10% байсан бол 2024 онд 66% болж өсжээ. Сургуулийн өмнөх боловсролыг үндэсний боловсролын тогтолцоонд нэгтгэж, уг боловсролыг олгодог улсын сургуулийн тоо гурван жилийн дотор зургаа дахин нэмэгдсэн. Хөдөө орон нутагт хямд өртөгтэй, орон нутагт түшиглэсэн төвүүдэд өргөн хүрээний хөрөнгө оруулалт хийснээр ийм ахиц гаргах боломж бүрдсэн боловч өрхүүдийн үйлчилгээний зардлыг даах боломж хязгаарлагдмал хэвээр байна. Узбекистанд бага сургуульд элсэх наснаас нэг жилийн өмнөх насны хүүхдүүдийн хамрагдалтын хувь 2008 онд 38% байсан бол 2022 онд 82% болж өссөн. Энэхүү өсөлт нь Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд тулгуурласан бодлогын шинэчлэл, сургуулийн өмнөх боловсролыг түсгайлан хариуцсан яам байгуулсан явдал, төр-хувийн хэвшлийн өргөн хүрээний түншлэлийн үр дүн юм. Татаас, үйлчилгээний алтернатив загварууд болон тэгш хамруулахад чиглэсэн хүчин чармайлт нь хүртээмжийг цаашид сайжруулахад мөн хувь нэмэр оруулжээ

БОДЛОГЫН ШИНЖИЛГЭЭ

Бага насны хүүхдийн өндөр чанартай асаргаа халамж, боловсрол нэн чухал бөгөөд ялангуяа боломж тааруу хүүхдүүдэд онцгой ач холбогдолтой. Бага насны хүүхдийн суралцах үйл явц тархины хөгжилд нэн чухал үүрэгтэй боловч зардал, институцийн тогтолцоо сул, эрэлт хангалтгүй зэрэг шалтгааны улмаас олон улс бүх хүүхдэд сургуулийн өмнөх боловсролыг нэг жил ч хүргэхэд бэрхшээлтэй хэвээр байна. Иймээс улс төрийн манлайлал олон тохиолдолд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж иржээ. Тойм шинжилгээнд бодлогыг институцийг хөгжүүлэх, эрэлтийг дэмжих, боловсролын нийлүүлэлтийг бэхжүүлэх гэсэн гурван өргөн хүрээний ангиллаар авч үзсэн.

Өргөжилтөд зөвхөн бодлого төдийгүй нийгэм, эдийн засгийн өргөн хүрээний өөрчлөлтүүд ч нөлөөлдөг. Өндөр орлоготой орнуудад эхчүүдийн хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж, гэр бүлийн бүтэц өөрчлөгдсөн нь засгийн газруудыг бага насны хүүхдийн асаргаа халамж, боловсролын үйлчилгээг өргөжүүлэх, зохицуулах, мөн татаас нэвтрүүлэхэд түлхэц болжээ. Үүний зэрэгцээ бүх нийтийн эсвэл төрөөс ихээхэн татаас олгодог сургуулийн өмнөх боловсрол нь ээжүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшнийг хэд хэдэн хувийн пунктээр нэмэгдүүлэх боломжтой. Гэвч бага, дунд орлоготой олон оронд үйлчилгээний цаг богино, тээврийн зардал өндөр, зохицуулалт сул байгаа нь энэ үр нөлөөг бууруулдаг.

ТОГТОЛЦООНЫ ТҮВШНИЙ БОДЛОГО

Сургуулийн өмнөх боловсролыг заавал эзэмших болон/эсвэл үнэ төлбөргүй болгох нь түүнийг хүүхэд бүр эдлэх эрх болгон баталгаажуулдаг. Олон улсын түвшинд сургуулийн өмнөх боловсролыг дор хаяж нэг жил үнэ төлбөргүй, заавал эзэмшүүлэх уриалгыг олон улсын конвенц, мэдэгдлүүд дэмжиж байна. Үүний зэрэгцээ Хүүхдийн эрхийн тухай конвенцод санал болгож буй протокол батлагдвал үнэ төлбөргүй сургуулийн өмнөх боловсролыг төрөөс заавал хангах ёстой эрх болгон баталгаажуулж, уг боловсролын үйлчилгээг үзүүлэх төрийн хариуцлагыг нэмэгдүүлэхэд дэмжлэг болох юм. Өгөгдөл нь байгаа 182 улсын дунд 1998–2023 онд сургуулийн өмнөх боловсролыг дор хаяж нэг жил заавал эзэмшүүлэхээр тогтоосон улсын тоо 20-оос 44 болж нэмэгджээ. Хэд хэдэн улс заавал сургуульд суралцаж эхлэх насыг бууруулсан байна. Өгөгдөл нь байгаа 119 улсын дотор сургуулийн өмнөх боловсролыг дор хаяж нэг жил үнэ төлбөргүй эзэмших эрхийг баталгаажуулсан улсын тоо 46-аас 69 болж өссөн

бөгөөд тэдгээрийн олонх нь энэ хугацааг хоёр, гурван жил болгон сунгажээ. 73 улсыг харьцуулсан судалгаагаар 2003–2023 онд сургуулийн өмнөх боловсролыг үнэ төлбөргүй болгосон орнуудад хамран сургалтын цэвэр жин 28%-аар, заавал эзэмших болгосон орнуудад 30%-аар өссөн нь эдгээр арга хэмжээг аваагүй орнуудын 23%-ийн өсөлтөөс өндөр байжээ. Гэхдээ бүх нийтийн сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийн үр өгөөж бүрэн гарахын тулд чанар болон хэрэгжилтийг хангах шаардлагатай. Багамын арлууд, Белиз, Йордан, Мальтад ажиглагдсаны адил сургалтын төлбөрийг халах нь улсын сургуулийн өмнөх боловсролын тогтолцоог өргөжүүлэхэд дэмжлэг болох учиртай. Харин Чили, Казахстан, Турк, Англи (Их Британи)-д төлбөрийг бууруулахад сургуулийн өмнөх боловсролд хувийн хэвшлийн эзлэх хувь нэмэгджээ.

Нэгдсэн удирдлага, зохицуулалт шаардлагатай. Бага насны хүүхдийн боловсролыг боловсролын яаманд хариуцуулсан тохиолдолд боловсролын түвшин хоорондын шилжилтийг илүү жигд болгох, сургалтын хөтөлбөрийн уялдааг хангах, суралцахуйн үр дүнгийн өсөлтийг тогтвортой хадгалахад дэмжлэг болдог байна. Харин удирдлага, зохицуулалт салангид байх нь хувийн хэвшлийн болон орон нутагт түшиглэсэн хөтөлбөрүүдийн мэдээлэл бүртгэлд орохгүй үлдэхэд хүргэж мэдээллийн тогтолцоог сулруулах, түүнчлэн боловсролын шударга тэгш бус хүртээмжид хүргэж болзошгүй. Судалгаанд хамруулсан 181 улсын 76% нь бага насны хүүхдийн боловсролыг боловсролын яаманд хариуцуулдаг бол 21% нь бусад яамтай хариуцлагыг хуваалцдаг, 3% нь өөр байгууллагад хариуцуулдаг байна. Монгол Улсад бодлогын уялдааг хангаснаар боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлсэн бол Узбекистанд сургуулийн өмнөх боловсролыг түсгайлан хариуцсан яам байгуулсан нь хамрагдалтыг хурдацтай нэмэгдүүлсэн. Бангладеш, Энэтхэг, Пакистанд удирдлага, зохицуулалт салангид байгаа нь чанарын баталгаажуулалт, сургалтын хөтөлбөрийн уялдааг хангах боломжийг хязгаарлажээ. Сахарын цөлөөс өмнөх Африкт удирдлага, зохицуулалтын салангид байдал дунджаас өндөр бөгөөд 47 улсын 13-т нь хариуцах чиг үүрэг болон төсвийн санхүүжилтийг хэд хэдэн яаманд хуваарилсан байна. Харин Латин Америкт Бразил, Колумбын жишээтэй адил бага насны хүүхдэд чиглэсэн салбар хоорондын стратегиуд нь зохицуулалтыг бэхжүүлжээ.

Сургуулийн өмнөх боловсролын санхүүжилт хангалтгүй байдаг. Олон улс орны засгийн газар төрийн бус боловсролын үйлчилгээнд ихээхэн түшиглэдэг. Өгөгдөл нь байгаа улсуудаас ердөө 10 улс сургуулийн өмнөх боловсролд ДНБ-ийхээ дор хаяж 1%-ийг зарцуулдаг. Харьцуулах боломжтой өгөгдөл бүхий 61 улсын хувьд сургуулийн өмнөх боловсролд зарцуулсан зардлын медиан (голч) хорин жилийн хугацаанд ДНБ-ий 0.29%-аас 0.43% болж өсжээ. Төрийн зардал өндөр байх нь нийт хамран сургалттай хамааралгүй боловч төрийн боловсролын байгууллагад хамран сургалттай эерэг хамааралтай байна. Тухайлбал, сургуулийн өмнөх боловсролд зарцуулах төрийн зардлыг ДНБ-ий 0.25 орчим хувиас 0.5% болгон хоёр дахин нэмэгдүүлэх нь бага сургуульд элсэх наснаас нэг жилийн өмнөх насны хүүхдүүдийн улсын боловсролын байгууллагад хамрагдалт ойролцоогоор гурав дахин өндөр байхтай хамааралтай байна. Литва Улс сургуулийн өмнөх боловсрол болон бага насны хүүхдийн боловсролын бусад үйлчилгээнд зарцуулах зардлын ДНБ-д эзлэх хувийг аль алиныг нь нэмэгдүүлсэн бөгөөд хамрагдсан хүүхдийн тоо өссөн хэдий ч хүүхэд тутамд ногдох зардлыг мөн нэмэгдүүлжээ. Санхүүжилтийн загвар нь шударга тэгш байдалд мөн нөлөөлдөг. Дани Улс орон нутгийн засаг захиргааны хариуцлага, их хэмжээний татаас, нийт зардлын 25%-иас хэтрэхгүй байхаар тогтоосон эцэг эхийн төлбөр, боломж тааруу хүүхдүүдэд үйлчилгээ үзүүлдэг төвүүдэд олгох нэмэлт санхүүжилтийг хослуулснаар хүртээмжийг өндөр түвшинд, тэгш бус байдлыг бага түвшинд хадгалж байна.

ЭРЭЛТИЙГ ДЭМЖИХ БОДЛОГО

Сургуулийн өмнөх боловсролын хүртээмж дэх хөрөнгө чинээний зөрүү их хэвээр байна. 2005–2020 онд Африк, Ази, Номхон далайн бүс нутгийн 25 улсад бага сургуульд элсэхээс нэг жилийн өмнөх насны хүүхдүүдийн сургуулийн өмнөх боловсролын хамрагдалт 30 орчим хувийн пунктээр нэмэгдсэн бөгөөд Азербайжан, Киргизстан, Филиппинд өсөлт өндөр байв. Гэсэн хэдий ч эдгээр улсын чинээлэг болон ядуу өрхийн хүүхдүүдийн хамрагдалтын зөрүү 30 орчим хувийн пункт буюу өндөр хэвээр байжээ (Зураг 3). Харин үүний эсрэгээр, Латин Америкийн найман улсад 2000–2024 онд ядуу өрхийн хүүхдүүдийн хамрагдалт нэмэгдэж, чинээлэг өрхийн хүүхдүүдтэй байсан зөрүү арилжээ.

Улс орнууд нөөцийг хамгийн их хэрэгцээтэй хэсэгт чиглүүлэхийн тулд зорилтот дэмжлэгийн өөр өөр тогтолцоог ашигладаг. PEER-ийн улс орны танилцуулгуудаас үзэхэд сургуулийн өмнөх боловсролыг үнэ төлбөргүй болгохоос гадна зардлыг нь өрхүүд даах боломжийг нэмэгдүүлэхийн тулд улс орнууд өөр гурван механизм ашигладаг байна. Улс орнуудын 54% нь боломж тааруу хүүхдүүдэд үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудад санхүүжилт шилжүүлдэг; 26% нь боловсролын яамаар дамжуулан гэр бүлүүдэд санхүүгийн дэмжлэг олгодог; 55% нь бусад яам, ихэвчлэн нийгмийн хамгааллын асуудал хариуцсан яамаар дамжуулан гэр бүлүүдэд санхүүгийн дэмжлэг олгодог. Байгууллагуудад шилжүүлдэг санхүүжилт нь голчлон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд дэмжлэг үзүүлэхэд чиглэдэг (улс орнуудын 59%) бол суралцагчид болон өрхүүдэд олгодог санхүүгийн дэмжлэг нь гол төлөв ядуурлын асуудлыг бууруулахад

чиглэдэг (92%). Сургуулийн өмнөх боловсролын түвшинд сургуулийн хоолны хөтөлбөрийн хамралт бага бөгөөд бага орлоготой орнуудад 2%, өндөр орлоготой орнуудад 22% байна.

Боломж тааруу бүлгүүдэд чиглэсэн мөнгөн шилжүүлэг нь бага насны хүүхдийн боловсролын зардлыг даах боломж болон хүртээмжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг болдог. Карнатака мужийн хөдөө орон нутагт сургуулийн өмнөх боловсролын төлбөрийн тэтгэлэг олгосноор хамрагдалт 20 хувийн пунктээр нэмэгджээ. Хүүхдийн ирцийг нөхцөл болгон олгодог мөнгөн шилжүүлэг нь хэд хэдэн улсад хамран сургалтыг нэмэгдүүлсэн байна. Чили, Колумб, Эль Сальвадор, Мексик, Филиппинд ийм шилжүүлгийн үр дүнд сургуулийн өмнөх боловсролын хамрагдалт 6–15 хувийн пунктээр нэмэгдсэн бөгөөд өсөлт ялангуяа хөдөө орон нутаг болон орхигдож гадуурхагдсан бүс нутагт өндөр байжээ. Франц, Герман, Норвег, Америкийн Нэгдсэн Улс зэрэг өндөр орлоготой оронд орлогод суурилсан урамшуулал, татварын хөнгөлөлт, мөнгөн урамшуулал нь хүүхдүүдийг сургуулийн өмнөх боловсролд тогтмол хамрагдахад дэмжлэг болдог боловч захиргааны саад бэрхшээл болон нийгмийн сөрөг хандлага нь эдгээр арга хэмжээний үр нөлөөг бууруулж болзошгүй.

Гэрт-түшиглэсэн хөтөлбөрүүд нь бага насны хүүхдийн хөгжлийн зөрүүг арилгахад дэмжлэг болдог. Бага, дунд орлоготой 63 улсыг хамарсан судалгаанаас гарсан нотолгооноос үзэхэд ном уншиж өгөх, үлгэр түүх ярих, тоглох зэрэг 3–4 настай хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдах (72%) нь зохион байгуулалттай сургалтын хөтөлбөрт хамрагдах (34%)-аас хоёр дахин түгээмэл байна. Бразилын Крианса Фелиз (Criança Feliz) хөтөлбөр, Индонезийн Бага насны хүүхдийн боловсрол, хөгжлийн төсөл зэрэг орон нутагт хүрч ажиллах болон гэрээр очиж үйлчилгээ үзүүлэх хөтөлбөрүүд нь бага насны хүүхдийн суралцахуйн ач холбогдлын талаарх ойлголтыг нэмэгдүүлдэг. Индонезид энэ арга барил сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг 9 хүртэл хувийн пунктээр нэмэгдүүлэхэд дэмжлэг болжээ.


НИЙЛҮҮЛЭЛТИЙГ ДЭМЖИХ БОДЛОГО

Төрийн сургуулийн өмнөх боловсролын дэд бүтцээ хэд хэдэн улс өргөжүүлжээ. Колумб Улс De Cero a Siempre хөтөлбөрөөрөө, Мозамбик Улс 10 дүүрэгт хэрэгжүүлсэн хөдөөгийн сургуулийн өмнөх боловсролын санаачилгаар, Вьетнам Улс шинэ сургалтын байр, байгууламжид хөрөнгө оруулснаар хамрагдалтыг нэмэгдүүлэхэд тус тус хувь нэмэр оруулжээ. Этиоп, Гватемал, Өмнөд Африк зэрэг хэд хэдэн улс сургуулийн өмнөх боловсролын ангиудыг одоо байгаа бага сургуулиудын бүтцэд нэгтгэснээр зардлыг бууруулж, хамрагдах хүрээг тэлэн, хүртээмжийг нэмэгдүүлжээ.

ЗУРАГ 3.

Африк, Азид бага насны хүүхдийн боловсролын хамрагдалтын түвшин нэмэгдсэн боловч хамгийн ядуу болон хамгийн чинээлэг бүлгийн хамрагдалтын зөрүү хэвээр үлджээ

Бага сургуульд элсэх албан ёсны наснаас нэг жилийн өмнөх насны хүүхдүүдийн зохион байгуулалттай сургалтад хамрагдалтын хувь, хөрөнгө чинээний квинтилээр, Африк, Ази, Номхон далайн сонгосон улс орнууд, 2004–08 болон 2020–24



БХШ-ний статистик: https://bit.ly/GEM2026_Summary_fig3
Эх сурвалж: ЮНЕСКО-ийн Статистикийн хүрээлэнгийн мэдээллийн сан

Сүүлийн үеийн өгөгдөл нь байгаа орнуудын гуравны нэгд хувийн үйлчилгээ үзүүлэгчид нийт хамран сургалтын 50%-иас илүү хувийг эзэлж байна. Хувийн хэвшлээс үзүүлж буй боловсролын үйлчилгээний эзлэх хувь сүүлийн хорин жилийн хугацаанд ерөнхийдөө тогтвортой байсан бөгөөд зарим бүс нутагт гарсан өсөлтийг бусад бүс нутгийн бууралт нөхсөн байна. PEER вэбсайтад зориулсан зураглалын судалгаагаар улс орнуудын 81% нь төрийн бус үйлчилгээ үзүүлэгчдийн үйл ажиллагааг дэмжих урамшуулал олгодог байна. Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс, Мадагаскар, Тринидад ба Тобагогийн жишээнээс харахад боломж тааруу бүлгүүдийн хүртээмжийн зөрүүг бууруулахын тулд орон нутагт түшиглэсэн болон төрийн бус байгууллагын үйлчилгээ үзүүлэгчдэд засгийн газраас дэмжлэг үзүүлэх нь түгээмэл байна. Засгийн газрууд мөн гэрээгээр үйлчилгээ гүйцэтгүүлэх, татаас олгох, ваучерын тогтолцоо ашиглах замаар хувийн үйлчилгээ үзүүлэгчидтэй хамтран ажилладаг. Бразил, Филиппин, Самоа, Өмнөд Африк улс хувийн төвүүдийн үйл ажиллагааг үндэсний стандартад нийцүүлэхийн тулд гэрээгээр үйлчилгээ гүйцэтгүүлэх эсвэл буцалтгүй санхүүжилт олгох аргыг ашигладаг бол Багамын Арлууд, Бүгд Найрамдах Солонгос Улс, Саудын Араб ваучер ашиглан хувийн сургуулийн өмнөх боловсролын зардлыг өрхүүд даах боломжийг нэмэгдүүлдэг. Ихэнх улс ийм үйлчилгээ үзүүлэгчдэд тусгай зөвшөөрөл олгодог боловч зохицуулалт нь төлбөрийн дээд хязгаар тогтоох, тэгш хамруулах элсэлтийн журам хэрэгжүүлэх зэрэг шударга тэгш байдлыг сайжруулах арга хэмжээнээс илүүтэй захиргааны шаардлагыг хангаж буй эсэхэд төвлөрөх нь түгээмэл байна. Улс орнуудын ердөө 45% нь төлбөрийн хэмжээг, дөнгөж 15% нь ашиг олох үйл ажиллагааг зохицуулдаг.

Хөтөлбөр хүүхдэд нь бодитой, илэрхий үр өгөөжтэй гэж үзсэн тохиолдолд гэр бүлүүд хүүхдээ хамруулах магадлал өндөр байдаг. Багш, хүүхэд хоорондын эерэг харилцаа зэрэг шууд ажиглагдах хүчин зүйлс гэр бүлүүдийн шийдвэрт нөлөөлдөг. Багшийн мэргэжлийн хөгжил, мэргэжил арга зүйн чиглүүлэг (коучинг) зэрэг боловсролын тогтолцоог бэхжүүлэх арга хэмжээ нь сурган хүмүүжүүлэгчдийн ажиллах арга барилыг сайжруулж, эрэлтийг дэмжих боломжтой. Чилид багшийн мэргэжлийн хөгжлийн хоёр жилийн хөтөлбөр болох Un Buen Comienzo (“Сайн эхлэл”) нь суралцагчдын хичээл таслалтын түвшнийг 54%-аас 35% болгон бууруулахад хувь нэмэр оруулжээ. Ганад мэргэжлийн хөгжлийн сургалтад хамрагдсан

багштай сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад хүүхдийн ирц өндөр, эцэг эхийн оролцоо илүү идэвхтэй байжээ. Тоглох үйл ажиллагааг дэмжсэн эрэг орчин нь чанарын бас нэг чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Ийм орчныг бүрдүүлэхэд бага хэмжээний нөөц шаардагдах боловч хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг дэмжиж, эцэг эх, хүүхдийн дотно харилцааг бэхжүүлдэг.

Тэгш хамруулах орчин нь боломж тааруу хүүхдүүдийг боловсролд хамруулахад мөн дэмжлэг болдог. Өмнөд Австралид хэрэгжүүлдэг тэгш хамруулахад чиглэсэн боловсролын байгууллагын барилга, орчны стандарт, Бразилын олон зориулалттай сургалт, дэмжлэгийн өрөө, Европын хэд хэдэн улсын нэмэлт туслах ажилтан, сэргээн засах үйлчилгээний мэргэжилтнүүд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд хамран сургахад дэмжлэг үзүүлдэг. Камбожийн орон нутагт түшиглэсэн сургуулийн өмнөх боловсрол, Эквадорын хос хэл, соёл хоорондын хөтөлбөр, Шинэ Зеландын хоёр соёлд суурилсан сургалтын хөтөлбөр, Папуа Шинэ Гвинейд 400 гаруй уугуул хэлийг боловсролд ашиглаж буй зэрэг олон хэл, соёл хоорондын арга барил нь үгсаатны болон хэлний цөөнхийн хүүхдүүдийг тэгш хамруулахад дэмжлэг болдог. Колумбын хөдөө орон нутагт явуулын хэлбэрээр хэрэгжүүлдэг стратеги болон Монголын нүүдлийн гэр цэцэрлэгүүд нь алслагдсан бүс нутгийн хүүхдүүдэд боловсролын үйлчилгээ хүргэдэг. Харин дүрвэн шилжсэн хүүхдүүдийн хувьд бага насны хүүхдийн суралцах боломж тогтворгүй хэвээр бөгөөд богино хугацааны санхүүжилтээс ихээхэн хамааралтай байна.

БАГА, ДУНД БОЛОВСРОЛ

ГОЛ ЧИГ ХАНДЛАГА

2000-2024 онд сургуульд суралцагчдын тоо хурдацтай өсжээ. Бага боловсролын хамран сургалт 19%, суурь боловсролынх 28%, бүрэн дунд боловсролынх 73%-аар өссөнөөр нийт суралцагчдын тоо 327 саяар нэмэгджээ. 2000 оноос хойш Сахарын цөлөөс өмнөх Африкт бага боловсролын хамран сургалт хоёр дахинаас илүү, дунд боловсролын хамран сургалт гурав дахинаас илүү болсон бол бага орлоготой орнуудад дунд боловсролын хамран сургалт бараг дөрөв дахин болжээ. Мөн хугацаанд сургуулийн насны хүн ам дундаас дээгүүр болон өндөр орлоготой орнуудад 9%-аар буурч, дундаас доогуур орлоготой орнуудад 25%-аар өссөн бол бага орлоготой орнуудад хоёр дахин нэмэгджээ.

Бага болон дунд боловсролд суралцаж буй хүүхэд, өсвөр үеийнхэн, залуучуудын тоо ийнхүү 1.4 тэрбумд хүрсэн хэдий ч 2024 онд 273 сая хүүхэд, өсвөр үеийнхэн, залуучууд сургуульд хамрагдаагүй байв. Үүнээс 79 сая нь бага боловсролын насны хүүхэд, 64 сая нь суурь боловсролын насны өсвөр үеийнхэн, 130 сая нь бүрэн дунд боловсролын насны залуучууд байжээ. Сургуульд хамрагдаагүй хүүхэд, өсвөр үеийнхэн, залуучуудын тоо 2000–2015 онд 33%-аар буурсан боловч 2015 оноос 2024 он хүртэл 3%-аар өсжээ. Бага орлоготой орнуудад сургуульд хамрагдаагүй хүүхэд, өсвөр үеийнхэн, залуучуудын тоо 2015 оноос хойш 29%-аар өссөн бол бусад оронд ерөнхийдөө өөрчлөлтгүй хэвээр байна. Дэлхий даяарх сургуульд хамрагдаагүй хүүхэд, өсвөр үеийнхэн, залуучуудын дөрөвний гурав нь Сахарын цөлөөс өмнөх Африк, Төв ба Өмнөд Азид байна. Бага болон дунд боловсролын насны хүн амын сургуульд хамрагдаагүй эзлэх хувь дэлхийн хэмжээнд 2000 онд 27% байсан бол 2015 онд 17% болж буурсан ч түүнээс хойш ахиц гараагүй байна.


Зөрчил мөргөлдөөнд өртсөн орнуудад сургуульд хамрагдаагүй хүүхэд, өсвөр үеийнхэн, залуучуудын тоо бодит хэмжээнээсээ доогуур тооцогдож байна. Зөрчил мөргөлдөөн нь боловсролын болон өгөгдөл цуглуулах үйл ажиллагааг доголдуулдаг. 2024 онд зөрчил мөргөлдөөнд хамгийн их өртсөн Буркина Фасо, Хаити, Ливан, Мали, Мьянмар, Палестин Улс, Сомали, Өмнөд Судан, Судан, Арабын Бүгд Найрамдах Сири Улс гэсэн 10 улсын талаарх хүмүүнлэгийн байгууллагуудын болон бусад тайланд хийсэн шинжилгээнээс үзэхэд албан ёсны өгөгдөлд тулгуурласан тооцоогоор дэлхийн хэмжээнд сургуульд хамрагдаагүй хүүхэд, өсвөр үеийнхэн, залуучуудын тоог 13 сая орчмоор дутуу тооцсон байж болзошгүй байна.

Сургуульд хамрагдаагүй хүүхэд, залуучуудын эзлэх хувь зогсонги байгаа ч төгсөлтийн хувь бараг тогтмол хурдаар өссөөр байна. 2000 оноос хойш төгсөлтийн хувь бага боловсролын түвшинд 77%-аас 88% (маш хожуу төгсөгчдийг тооцвол 92%), суурь боловсролын түвшинд 60%-аас 78% (маш хожуу төгсөгчдийг тооцвол 82%), бүрэн дунд боловсролын түвшинд 37%-аас 61% (маш хожуу төгсөгчдийг тооцвол 64.5%) болж өсжээ. Өөрөөр хэлбэл, 2000 оноос хойш бүрэн дунд боловсролын төгсөлтийн хувь жилд дунджаар 0.8 хувийн пунктээр өсжээ. Өнгөрсөн хугацаанд ажиглагдсан ахицын хурдыг авч үзвэл дэлхийн хэмжээнд бүрэн дунд боловсролын төгсөлтийн хувь 95%-д дундаж хувилбараар 2105 онд, хурдацтай өргөжилт (75-р процентиль)-ийн хувилбараар 2081 онд, хамгийн хурдацтай өргөжилт (хамгийн өндөр үзүүлэлттэй 25%-ийн дундаж)-ийн хувилбараар 2062 онд хүрэхээр байна (Зураг 4).

ЗУРАГ 4:

Өнгөрсөн 25 жилд ажиглагдсан өргөжилтийн дундаж хурдаар үргэлжилбэл дэлхийн хэмжээнд бүрэн дунд боловсролын төгсөлтийн хувь 95%-д хүрэхэд 80 жил шаардагдана

Өргөжилтийн гурван хувилбараар бүрэн дунд боловсролын төгсөлтийн хувь 95%-д хүрэхээр тооцоолсон он



БХШ-ний статистик: https://bit.ly/GEM2026_Summary_fig4

Эх сурвалж: VIEW төгсөлтийн хувийн загварт үндэслэсэн Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайлангийн багийн тооцоо.

Сургууль завсардалт нь нэг удаагийн үйл явдал бус, харин үе шаттай өрнөдөг үйл явц юм. Өрхийн нөхцөлөөс үүдэлтэй хязгаарлалт, орон нутгийн/нийгмийн орчны түвшний хүндрэл бэрхшээл, сургуулийн үйл ажиллагаа цаг хугацааны явцад харилцан нөлөөлөхийн хэрээр хүүхдүүд ихэвчлэн тогтмол бус ирцтэй болох, суралцах үйл явцаас аажмаар хөндийрөх зэрэг үе шатыг дамжсаны эцэст боловсролын тогтолцооноос бүрмөсөн гардаг. Иймээс ирц, боловсролын түвшин хоорондын шилжилт, сургуульд үргэлжлүүлэн суралцахтай холбоотой бүтцийн саад бэрхшээлийг арилгахад анхаарах шаардлагатай.

Хичээл таслалт нь сургуулиас эрт гарах эрсдэлийг урьдчилан илтгэх дохио болдог. Хичээл таслалтыг ихэвчлэн сургуулийн түвшинд хэмждэг бөгөөд үндэсний түвшинд нэгтгэн тооцох буюу тайлагнах нь ховор. Судалгааны бүтээлүүдэд мэдээлсэн бага болон дундаас доогуур орлоготой орнуудын хичээл таслалтын хувь нь нас, нөхцөл байдал, ашигласан тодорхойлолтоос хамааран 10%-аас багаас 30 орчим хувь хүртэл хэлбэлздэг. Харин чинээлэг орнуудад суралцахуйн амжилтын судалгаанууд аар суралцагчдын өөрсдийн мэдээлсэн зарим тооцоог гаргадаг. Олон улсын суралцагчийн үнэлгээний хөтөлбөр (PISA) 15 настай суралцагчдаас өмнөх хоёр долоо хоногт бүтэн өдрийн хичээл тасалсан эсэхийг асуудаг. Итали, Румын, Саудын Арабт 10 суралцагч тутмын 7 орчим нь энэ хугацаанд дор хаяж нэг удаа бүтэн өдрийн хичээл тасалсан гэж мэдээлсэн бол 13%–16% нь энэ богино хугацаанд гурав ба түүнээс олон өдөр хичээл тасалсан гэж мэдээлжээ. Хичээл таслалтыг эрт илрүүлж, шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авах хэрэгтэй. Сургуулиас эрт гарах явдлыг бууруулах Европын Холбооны зорилтын хүрээнд гишүүн орнуудын ихэнх нь ирц, зан төлөв, сурлагын амжилтын өгөгдлийг суралцагчдад үзүүлэх дэмжлэгтэй уялдуулах бодлого хэрэгжүүлэх болсон.

Боловсролын түвшин хоорондын шилжилт нь суралцагчид боловсролын тогтолцооноос гарах нь элбэг өөр нэг чухал үе юм. Түүхэн өгөгдлөөс үзэхэд бага боловсролоос суурь боловсролд шилжин суралцах бодит хувь 1985 онд 78% байсан бол 2000 онд 88% болж өссөн бөгөөд түүнээс хойш өсөлт ихээхэн удааширч, 2015 он гэхэд 91%-д хүрчээ. Бага орлоготой орнуудад шилжин суралцах хувь 1982 онд 56% байсан бол 2007 онд 80% хүртэл тогтвортой өссөн ч дараагийн 10 жилийн хугацаанд уг түвшиндээ тогтворжсон байна. 2000–2017 онд Чад, Мали, Тогод шилжин суралцах хувь зогсонги байсан бол Бүгд Найрамдах Танзани Нэгдсэн Улсад уг үзүүлэлт 20 орчим хувиас 71% болж огцом өсжээ.

Анги улиран суралцах явдлыг бууруулахад гарсан ахиц нь төгсөлт болон сургуульд хамрагдаагүй хүүхэд, залуучуудын үзүүлэлтийн өөрчлөлтийг ихээхэн тайлбарлаж байна. 2000–04 болон 2020–24 оны хооронд анги улиран суралцах түвшин бага боловсролд гуравны хоёроор, суурь боловсролд 40%-аар буурчээ. Боловсролын тогтолцоо өргөжиж, чанар буурч байсан үед анги улиран суралцах явдал нэмэгдэж, ахицыг сааруулж байсан боловч цаг хугацааны явцад суралцагчдын анги, түвшин ахин суралцах байдал сайжирсан байна. Гэсэн хэдий ч энэхүү тайланд зориулан хийсэн шинэ шинжилгээнээс үзэхэд цөөн хэдэн улсад анги улиран суралцах тохиолдлыг дутуу тооцож байх магадлалтай.

Нас хэтэрсэн хүүхдийн хамран сургалт болон анги улиран суралцах явдал нь ядуу буурай орнуудад маш хожуу төгсөгчдийн хувь өндөр байдгийг тайлбарлаж байна. Бага орлоготой орнуудад 2000 оноос хойш хожуу хамран сургалт болон анги улиран суралцах явдал хавсран тохиолдох нь нэмэгдсэн бол дундаас доогуур орлоготой орнуудад энэ байдал бага боловсролын түвшинд буурсан ч дунд боловсролын түвшинд хараахан бууралагүй байна. Гэхдээ улс орнуудын хооронд мэдэгдэхүйц ялгаа бий. Бага боловсролын түвшинд Малавид хугацаанд нь төгсөлт болон хожуу төгсөлтийн хувийн хоорондын зөрүү 21 хувийн пункт байхад суурь боловсролын түвшинд Энэтхэгт энэ зөрүү бараг байхгүй байна.

КОВИД-19 цар тахал болгоомжлол төрүүлсэн ч хамрагдалтын түвшинд нөлөөлөөгүй бололтой. КОВИД-19 цар тахлын өмнөх, үеийн, дараах хугацаанд 29 улсын суурь боловсролын хүртээмжид гарсан чиг хандлагыг авч үзэхэд хамран сургалтын бохир жин өндөр, ерөнхийдөө тогтвортой хэвээр байсан бөгөөд олон улс оронд нас хэтэрсэн хамран сургалтын хувь буурчээ. Харин цөөн тооны улсад нас хэтэрсэн хамран сургалт нэмэгдсэн нь хамран сургалтын үзүүлэлтүүд суралцагчдын анги, түвшин ахин суралцах явц дахь зарим саатлыг далдалж байж болох бөгөөд цаашдаа төгсөлтөд хязгаарлагдмал боловч урт хугацааны зарим нөлөө илэрч болзошгүйг харуулж байна. Гол анхаарах асуудал нь цар тахлын суралцахуйд үзүүлсэн нөлөө хэвээр байна.

УЛС ОРНЫ КЕЙС СУДАЛГАА

Улс орны кейс судалгаанууд нь 2000 оноос хойш дэлхийн улс орнуудад хуримтлагдсан олон янзын туршлагыг харуулж байна. **Албани** 20 жилийн хугацаанд бүрэн дунд боловсролын төгсөлтийн хувийг хоёр дахин нэмэгдүүлжээ. Үүнд зардлыг нэмэгдүүлэх, сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, боловсролоо үргэлжлүүлэх хоёр дахь боломж олгох хөтөлбөрүүдийг нэвтрүүлэх, заавал эзэмших боловсролын хугацааг сунгах, зорилтот тэтгэлэг олгох зэрэг арга хэмжээ нөлөөлсөн байна. Гэхдээ цагаачлалын түвшин маш өндөр байсан нөхцөлд дотоод, гадаадад дээд боловсрол эзэмших эрэлт нэмэгдсэн нь шийдвэрлэх хүчин зүйл байсан байж болох юм. **Бангладешт** дунд боловсролын суралцагчдад олгох амьжиргааны тэтгэлэг зэрэг зорилтот

санаачилгууд нь охидын боловсролыг ахиулж, төрөлтийн түвшнийг бууруулахын зэрэгцээ эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоог дэмжжээ. Мэргэжлийн боловсролын сонголтыг өргөжүүлж, суурь боловсролын шалгалтад үндэслэн дараагийн шатанд дэвшин суралцах жүрмын зарим шаардлагыг зөөлрүүлсэн нь хөвгүүдийн боловсролын хүртээмжийг сайжруулахад дэмжлэг болсон байна. Камбож 2000–2020 онд бага боловсролын төгсөлтийн хувийг 34%-аас 82% болгож нэмэгдүүлжээ. Үүнд бага боловсролын сургалтын төлбөрийг халах, сургуулиудад үйл ажиллагааны санхүүжилтийг шууд олгох, хөдөө орон нутагт сургууль барих, багш ажилд авах, сургуулийн хоолны хөтөлбөр хэрэгжүүлэх, боломж тааруу суралцагчдад тэтгэлэг олгох зэрэг санхүүгийн болон газар зүйн саад бэрхшээлийг арилгахад чиглэсэн бодлогууд голлон нөлөөлжээ.

Коста Рикад сургуульд хамрагдаагүй залуучуудын эзлэх хувь 2002 онд 28% байсан бол 2023 онд 4% болж буурч, бүрэн дунд боловсролын төгсөлтийн хувь 36%-аас 78% болж өсжээ. Бүрэн дунд боловсролыг заавал эзэмших болгосон байна. Үнэ төлбөргүй сургуулийн хоол, тээврийн зардлын татаас, нөхцөлт мөнгөн шилжүүлгийн хөтөлбөр, эрт сэрэмжлүүлэх механизм, анги дэвшүүлэх уян хатан тогтолцоо, мэргэжлийн боловсролын боломжийг өргөжүүлсний үр дүнд ялангуяа боломж тааруу бүлгүүдийн дунд ахиц өндөр байжээ. **Кот-д'Ивуарт** суурь боловсролын төгсөлтийн хувь 15 жилийн хугацаанд хоёр дахин нэмэгджээ. Үүнд дунд сургуулийн тоо дөрөв дахин нэмэгдсэн, сургууль завсардсан суралцагчдад зориулсан нөхөн сургалтын ангиуд нээсэн, охидын боловсролыг дэмжих эхчүүдийн клубүүд байгуулсан, мөн 16 нас хүртэлх боловсролыг үнэ төлбөргүй, заавал эзэмших болгосон зэрэг нь дэмжлэг болжээ. Гэсэн хэдий ч суурь боловсролын түвшинд анги улиран суралцах явдал өндөр хэвээр байгаа тул бүрэн дунд боловсролын насны олон залуус суурь боловсролд суралцсан хэвээр байна. **Доминика** 2000-аад оны эхээр дунд боловсролын бүх нийтийн хамрагдалтад хүрсэн боловч хүндрэл бэрхшээлүүд хэвээр байна. Хамрагдалтыг өргөжүүлснээр суралцах бэлтгэл хангалтгүй суралцагчид олноор хамрагдах болж, анги улиран суралцах түвшин 10%-иас давсан бөгөөд энэ асуудал хөвгүүдэд харьцангуй илүү нөлөөлжээ.

Германд сүүлийн жилүүдэд бүрэн дунд боловсролын төгсөлтийн хувь Европын дунджаас хоцорч байна. Суралцагчдыг 10 настайд нь боловсролын өөр өөр чиглэлд хуваарилдаг нь ихэнх орныхоос хавьгүй эрт бөгөөд энэ шийдвэрт нийгэм, эдийн засгийн байдал хүчтэй нөлөөлдөг. Чинээлэг өрхийн хүүхдүүдийн тав тутмын бараг дөрөв нь, харин боломж тааруу өрхийн хүүхдүүдийн гурав тутмын нэг хүрэхгүй хувь нь академик чиглэлийн дунд сургуульд суралцах зөвлөмж авдаг байна. Цагаач гаралтай суралцагчид мэргэжлийн боловсролын чиглэлд харьцангуй өндөр хувийг эзэлдэг боловч сүүлийн үеийн шинэчлэлүүд боловсролын үйлчилгээнд хангалттай хамрагдаж чадахгүй байгаа бүлгүүдэд үзүүлэх дэмжлэгийг бэхжүүлэхэд чиглэж байна. **Ирак** олон хямралтай тулгарсан хэдий ч бүрэн дунд боловсролын төгсөлтийн хувь 2000 оны 20% гэсэн доогуур эхлэлийн түвшнээс хоёр дахинаас илүү нэмэгджээ. Хориг арга хэмжээг цуцалж, газрын тосны үнэ өссөн нь төрийн зардлыг нэмэгдүүлэх, өрхийн ядуурлыг бууруулахад дэмжлэг болж, сургуулиудыг сэргээн босгоход дахин хөрөнгө оруулах боломж бүрдүүлжээ. Сургуулиудыг олон ээлжээр ажиллуулах нь дотооддоо албадан шилжсэн хүн амд боловсролоо үргэлжлүүлэх боломж олгосон бол аюулгүй байдал сайжирснаар суралцах үйл явцдаа эргэн орох боломж нэмэгджээ.

Марокко 2000–2023 онд сургуульд хамрагдаагүй өсвөр үеийнхэн, залуучуудын тоог 72%-аар бууруулжээ. Мэдээлэл, ойлголт нэмэгдүүлэх кампанит ажил, гэр бүлийн оролцоо, нийгмийн үйлчилгээ зэрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээг мөнгөн шилжүүлгийн хөтөлбөр, тээврийн хөрөнгө оруулалт, хөдөө орон нутгийн дотуур байртай хослуулан хэрэгжүүлсэн нь боловсролын хүртээмжийг сайжруулж, суралцагчдыг сургуульд үргэлжлүүлэн суралцахад дэмжлэг болжээ. Шинээр нэвтрүүлсэн эрт сэрэмжлүүлэх тогтолцоо нь эрсдэлтэй байгаа суралцагчдыг илрүүлэхэд дэмжлэг болж байна. **Мозамбикт** бага боловсролын хамран сургалт 2000 оноос хойш гурав дахинаас илүү нэмэгджээ. Дайны дараа сургуулиудыг өргөн хүрээнд барьж байгуулсан, мөн 2004 онд бага боловсролын сургалтын төлбөрийг халсан нь үүнд гол үүрэг гүйцэтгэсэн байна. Сүүлийн үеийн санаачилгууд охидын боловсролыг дэмжиж, анги улиран суралцах явдлыг бууруулснаар суралцагчдын анги, түвшин ахин суралцах явцыг сайжруулахад чиглэжээ. Гэвч өрхийн судалгааны сүүлийн үеийн өгөгдлөөс үзэхэд бүтцийн саад бэрхшээлүүд арилаагүй хэвээр байгаа тул ахиц зогсонги байдалд оржээ. Ядуурал, хүүхдийн хөдөлмөр, сургуулийн хоолны хөтөлбөрийн хамралт бага, дэд бүтэц сул, зөрчил мөргөлдөөн, уур амьсгалтай холбоотой цочрол, хэлний бэрхшээл зэрэг нь хичээлд тогтмол хамрагдах боломжийг хязгаарласан хэвээр байна.

Румын залуучууд боловсролын гадна үлдэх (exclusion) түвшнээр Европт хамгийн өндөр орнуудын нэг хэвээр байгаа бөгөөд 2023 онд сургуульд хамрагдаагүй залуучуудын эзлэх хувь 27% байжээ. 2015 онд Сургуулиас эрт гарах явдлыг бууруулах үндэсний стратегийг баталсан хэдий ч яам хоорондын зохицуулалт сул, орон нутгийн хэрэгжилт жигд бус, дэмжлэгийн хөтөлбөрүүд салангид байгаагаас ахиц хязгаарлагдмал байна. Ром үндэстнийг тэгш хамруулах үндэсний стратеги, сургуулиуд дахь түсгаарлалтыг арилгах арга хэмжээ, Ром суралцагчдад зориулсан бүрэн дунд боловсролд элсэх зорилтот боломж

олгох арга хэмжээ зэрэг сүүлийн үеийн санаачилгууд нь тэгш хамруулах чиглэлээр институцийн түвшинд хүлээх үүрэг амлалт нэмэгдэж байгааг харуулж байна. Руандад бага боловсролын төгсөлтийн хувь 2001 онд 20%-аас доогуур байсан бол 2024 онд 70 орчим хувьд хүрч өссөн нь 1994 оны геноцидоос хойш боловсролын салбарт улс төрийн тууштай зорилт баримталж ирснийг харуулж байна. Үнэ төлбөргүй суурь (basic) боловсрол, Есөн жилийн суурь (basic) боловсролын хөтөлбөр зэрэг шинэчлэл нь хүртээмжийг өргөжүүлж, хүйсийн зөрүүг арилгахад хувь нэмэр оруулсан бөгөөд Алсын хараа 2020, Алсын хараа 2050-ийн хүрээнд сургалтын анги танхимыг олноор барьж байгуулсан болон сургалтын хөтөлбөрийн шинэчлэл эдгээр арга хэмжээг дэмжжээ. Гэсэн хэдий ч анги улиран суралцах түвшин өндөр хэвээр байгаа нь цаашдын ахицад саад болж байна.

Тринидад ба Тобаго 1990-ээд оны сүүл үеэс Америк хоорондын хөгжлийн банкны хоёр томоохон төслийн дэмжлэгийг авч, хөдөө орон нутагт шинэ сургууль барих, мөн дунд боловсролыг хоёр үе шаттай тогтолцоонд шилжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн бөгөөд 2010–2020 онд дунд боловсролын төгсөлтийн хувийг 10 хувийн пунктээр нэмэгдүүлжээ. Гэвч сургуулиуд төрлөөрөө шатлан ялгарсан хэвээр байгаа бөгөөд бага боловсролын төгсгөлд авдаг Дунд сургуульд элсэх үнэлгээ нь тэгш бус байдлыг улам гүнзгийрүүлсээр байна. Уганда 1997 онд Бүх нийтийн бага боловсролын хөтөлбөрөө хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд эхний үед боловсролын хүртээмжийг эрс нэмэгдүүлсэн ч төгсөлтийн ахиц зогсонги байдалд оржээ. Боловсролын зардал буурч, боловсролын үйлчилгээнд хувийн хэвшлийн оролцоо өндөр байгаа нөхцөлд өрхүүд боловсролын нийт зардлын ихээхэн хувийг өөрсдөө хариуцаж байна. Багшийн хомсдол, анги дүүргэлт өндөр байгаа нь боловсролын чанар, үр ашгийг сулруулжээ. Бүс нутгийн болон хүйсийн зөрүү хэвээр байгаа бөгөөд ялангуяа хойд бүс нутагт ядуурал, эрт гэрлэлт нь сургууль завсардалтыг нэмэгдүүлэхэд нөлөөлж байна.

БОДЛОГЫН ШИНЖИЛГЭЭ

2000 оноос хойших үе үндсэн хоёр үе шатаар тодорхойлогдож байна. 1990-ээд оны сүүлээр бага болон дунд орлоготой орнуудад төрийн зардалд тавьж байсан хязгаарлалт суларснаар бага болон дунд боловсролын хүртээмж хурдацтай нэмэгджээ. Энэ өргөжилт 2010 он гэхэд ихээхэн өөдрөг хүлээлт бий болгож, улмаар Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөрт 12 жилийн боловсрол эзэмшиж, бүрэн дунд боловсролыг бүх нийтээр төгсөх зорилтыг тусгахад хүргэсэн байна. Гэвч хурдацтай өргөжилтийн үед гарч болох анги улиран суралцах явдал нэмэгдэх, нас хэтэрсэн хамран сургалт өсөх, сургууль завсардалт нэмэгдэх, боловсролын чанарт санаа зовних зэрэг сөрөг үр дагаврыг төдийлөн анхаараагүй бөгөөд улс орнууд 2015 оноос хойш эдгээр асуудлыг шийдвэрлэхэд анхаарч иржээ.

ТОГТОЛЦООНЫ ТҮВШНИЙ БОДЛОГО

Хууль тогтоомж бүх нийтийн боловсролын хамрах хүрээг өргөжүүлсэн. Дэлхийн хэмжээнд 1998–2023 онд заавал эзэмших боловсролын дундаж үргэлжлэх хугацаа 1.2 жилээр, үнэ төлбөргүй боловсролын дундаж үргэлжлэх хугацаа 0.8 жилээр нэмэгджээ. Бага, дунд орлоготой 49 оронд заавал эзэмших боловсролыг бага боловсролоос цааш сунгаснаар дунд боловсролд шилжин суралцах хувь 7.3 хувийн пунктээр нэмэгдсэн байна. Сахарын цөлөөс өмнөх Африкийн орнуудад 1990-ээд болон 2000-аад онд сургалтын төлбөрийг халснаар бага боловсролын хамран сургалт болон боловсрол эзэмшсэн түвшин нэмэгдсэн бөгөөд энэ өсөлт ялангуяа охидын дунд өндөр байв. Хамран сургалт эхэн үед огцом нэмэгдсэн ч төгсөлтөд үзүүлсэн урт хугацааны нөлөө нь төсөөлж байснаас сул байсан. Гэсэн хэдий ч 14 улсыг хамарсан нэгэн судалгаагаар суурь боловсролыг зөвхөн үнэ төлбөргүй болгосон тохиолдолтой харьцуулахад заавал эзэмших бөгөөд үнэ төлбөргүй болгосон тохиолдолд охидын боловсрол эзэмшсэн хугацаа 1.6 жилээр, хөвгүүдийнх 1.4 жилээр илүү нэмэгдсэн байна. Хүүхдийн хөдөлмөрийн зохицуулалт нь заавал эзэмших боловсролын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг мөн дэмжжээ.

Сайтар боловсруулсан төвлөрлийг сааруулах бодлого нь ирц болон сургуульд үргэлжлүүлэн суралцах байдлыг сайжруулдаг. 65 улсыг хамарсан шинжилгээнээс үзэхэд тухайн орон нутгийн онцлогтой холбоотой асуудлыг шийдвэрлэх чадавхыг орон нутгийн эрх бүхий байгууллагуудад олгох нь боловсролын эерэг үр дүнд хүргэдэг байна. Индонезид төвлөрлийг сааруулснаар боломж тааруу суралцагчдад чиглэсэн нөөц, сурах бичгийн хангамж, боловсролын хамран сургалт нэмэгджээ. Мексикт сургуульд суурилсан удирдлага болон олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхдээ бодитой хэрэгжих нөхцөлөөр хангагдсан хариуцлагын механизмыг бүрдүүлсний үр дүнд сургууль завсардалт буурчээ.

Төрийн зардлыг нэмэгдүүлэх нь сургууль завсардалтыг бууруулдаг, ялангуяа нөөцийг зорилтот бүлэгт чиглүүлсэн тохиолдолд илүү үр дүнтэй байдаг. Коста Рика, Кот-д'Ивуар, Мозамбикт боловсролын хамран сургалт болон төгсөлт сайжрахын зэрэгцээ төрийн нийт зардалд боловсролын зардлын эзлэх хувь тогтвортой өндөр түвшинд хадгалагджээ. Харин бусад улс сургууль барих зэрэг тодорхой арга хэмжээнд зориулан зардлаа богино хугацаанд огцом нэмэгдүүлэх арга барилд тулгуурласан байна. Гэсэн хэдий ч Бангладеш, Камбож зэрэг зарим улс зардлын түвшин маш бага байсан ч боловсролын

хамрагдалтаа өргөжүүлжээ. Ялангуяа АНУ-ын микро түвшний нотолгооноос үзэхэд тогтвортой, зорилтот санхүүжилт нь боловсрол эзэмшсэн түвшин болон бүрэн дүнд боловсролын төгсөлтийг нэмэгдүүлдэг бөгөөд энэ нөлөө бага орлоготой суралцагчдын хувьд илүү өндөр байна.

Анги улиран суралцахтай холбоотой бодлого нь суралцагчдын боловсролын замналд хүчтэй нөлөөлдөг. Суралцахад хүндрэлтэй байгаа суралцагчдыг тухайн ангид нь улираан суралцуулах нь нас хэтэрсэн хамран сургалтад хүргэдэг бөгөөд энэ нь Бангладеш, Панам, Руанда зэрэг харилцан адилгүй нөхцөлтэй орнуудад ч сургууль завсардах эрсдэлийг урьдчилан илтгэх хүчтэй үзүүлэлт болдог. Энэ нь нэг талаас, нас ахисан өсвөр үеийнхэнд ажил хөдөлмөр эрхлэх, гэрлэх дарамт нэмэгддэг бол нөгөө талаас, анги улиран суралцах нь тэдний суралцах сэдэлд нөлөөлдөгтэй холбоотой. Тухайлбал, Бразил, Египет, Өмнөд Африкт боломж тааруу суралцагчид анги улиран суралцах магадлал илүү өндөр байдаг. ЭЗХАХБ-ын орнуудад нийгэм, эдийн засгийн нөхцөл доогуур өрхийн суралцагчид сурлагын амжилт ойролцоо үе тэнгийнхнээсээ анги улиран суралцах магадлал ойролцоогоор 50%-аар өндөр байна. Үүний зэрэгцээ бага ангид суралцагчдыг автоматаар анги дэвшүүлэх бодлогыг хоцрогдлыг нөхөх дэмжлэгтэй хослуулах шаардлагатай бөгөөд эс бөгөөс сургууль завсардалт буурах бус, зөвхөн хожуу ангид шилжин хойшлогдоно.

Улс орнууд суралцагчдыг академик эсвэл мэргэжлийн боловсролын чиглэлд хэр эрт, хэр хатуу хуваарилдгаараа ялгаатай. Европын хэд хэдэн оронд суралцагчдыг эрт хуваарилах нь төгсөх магадлалыг бууруулдаг бол хуваарилалтыг хойшлуулах нь төгсөлтийг нэмэгдүүлж, тэгш бус байдлыг бууруулах хандлагатай байна. ЭЗХАХБ-ын олон орон төгсөхөд хүрэх замналыг төрөлжүүлж, хөдөлмөрийн зах зээлтэй уялдааг бэхжүүлэхийн тулд сургуульд суурилсан болон ажлын байранд суурилсан сургалтуудыг хослуулсан хэлбэрийг өргөжүүлж, сүүлийн арван жилд ийм хосолсон хөтөлбөрт хамрагдах суралцагчдын эзлэх хувийг нэмэгдүүлжээ.

Шалгалт болон гэрчилгээ авахад тавигдах шаардлага нь боловсролын дараагийн түвшинд шилжин суралцахад саад болж болно. Угандад дунд боловсролд шилжин суралцаагүй хүүхдүүдийн гуравны нэг нь бага сургууль төгсөх шалгалтад тэнцээгүй байжээ. АНУ-д үр дүн нь төгсөлтийг шийдвэрлэх шалгалт суурь боловсролын төгсөлтийн хувийг 2–4 хувийн пунктээр бууруулсан бөгөөд энэ нөлөө боломж тааруу бүлгүүдэд илүү хүчтэй байжээ. Өмнөд Африкт хэрэгжүүлсэн шинэчлэлүүдээс үзэхэд гэрчилгээ авахад тавигдах шаардлагыг өөрчлөн зохицуулах нь тэгш бус байдлыг бууруулахыг зорихын зэрэгцээ төгсөлтийг нэмэгдүүлэх боломжтой байна.

Хамран сургах тойрог болон бүсчлэлийн журмыг шударга тэгш байдлыг сайжруулах зорилгоор нэвтрүүлэх нь түгээмэл боловч төлөвлөөгүй үр дагаварт хүргэх тохиолдол бий. Францад нэмэлт санхүүжилт олгохоор тэргүүлэх чиглэлд хамруулсан боловсролын бүсүүдийг байгуулсан боловч чинээлэг өрхүүд ийнхүү хамааруулсныг сөрөг дохио гэж үзэн тухайн бүсийн сургуулиас зайлсхийх болсон нь сургуулиуд дахь тусгаарлалтыг улам бэхжүүлжээ. Индонезид нэр хүндтэй улсын дунд сургуулиудад элсэх суралцагчдын бүрэлдэхүүнийг илүү тэгш болгох зорилготой эхлүүлсэн бүсчлэлийн шинэчлэлийн анхны зохицуулалтыг хожим нь сулруулжээ. Үүний эсрэгээр зарим боловсролын тогтолцоо суралцагчдыг зориудаар тусгаарлан сургах хэлбэрийг, тухайлбал БНСУ болон Тринидад ба Тобагод хүйсээр тусгаарлан сургах хэлбэрийг туршиж ирсэн бөгөөд энэ нь боловсрол эзэмшсэн түвшин эсвэл төгсөлт нэмэгдэхтэй тодорхой хэмжээнд холбоотой байсан ч шударга тэгш байдал болон боловсролын бодлогын хувьд нарийн төвөгтэй асуудлуудыг хөндөж байна.

Төгсөлтийг дэмжих бодлогын багцад уян хатан боловсролын замнал зайлшгүй шаардлагатай. Боломж тааруу залуучууд заавал эзэмших болон бүрэн дүнд боловсролоо төгсөхөд саад бэрхшээлтэй тулгардаг учраас олон улс орон сургалтын хэлбэр, гэрчилгээжүүлэлт, зорилтот бүлгээрээ ялгаатай уян хатан болон хоёр дахь боломжолгоххөтөлбөрүүдийгболовсруулан хэрэгжүүлжээ. Индонезийн Paket C, Лаосын бага боловсролын дүйцүүлэх хөтөлбөр зэрэг өргөн хүрээний дүйцүүлэх хөтөлбөрүүд нь хүлээн зөвшөөрөгдсөн боловсролын батламж авах боломжтой модульчилсан эсвэл бүтэн бус цагаар суралцах хэлбэрийг санал болгодог. Аргентин, Бангладеш, Энэтхэг, Тунист хэрэгжүүлж буй санаачилгууд нийгмээс гадуурхагдсан эмэгтэйчүүд, сургуульд хамрагдаагүй өсвөр үеийнхэн зэрэг бүлэгт зориулан хоцрогдол нөхөх сургалтыг мэргэжлийн боловсролын бүрэлдэхүүн хэсэгтэй хослуулдаг. Сахарын цөлөөс өмнөх Африкт түргэвчилсэн боловсролын хөтөлбөрүүд, ялангуяа зөрчил мөргөлдөөнд өртсөн бүс нутагт сургуульд суралцах явц нь тасалдсан хүмүүст боловсролоо үргэлжлүүлэхэд дэмжлэг үзүүлжээ. Гэвч албан ёсны боловсролын тогтолцоонд эргэн шилжин суралцах хувь ихээхэн ялгаатай хэвээр байгаа бөгөөд 40 хөтөлбөрийн тооцоогоор уг хувь 3%-аас 90%-ийн хооронд хэлбэлзэж байна. Суралцагчид албан ёсны боловсролын тогтолцоонд эргэн шилжин суралцахдаа өмнөхтэй адил саад бэрхшээлтэй дахин тулгардаг бололтой бөгөөд энэ нь сургууль завсардах эсвэл анги улиран суралцахад хүргэж байна. Уян хатан боловсролын замналыг албан ёсны боловсролын тогтолцооноос тусдаа зэрэгцээ чиглэл болж үлдэх бус, төгсөлтөд бодитоор хүргэх замнал болгохын тулд боловсролын өөр өөр хэлбэрийн хооронд шилжих институцийн уялдааг бэхжүүлэх шаардлагатай.

ЭРЭЛТИЙГ ДЭМЖИХ БОДЛОГО

Төрөл бүрийн бодлого нь боловсролын зардлыг даах боломжийг нэмэгдүүлж, суралцах сонирхлыг татахуйц болгох замаар боловсролын эрэлтийг дэмжихэд чиглэдэг. Хамгийн их нөлөөтэй бодлогууд нь шударга тэгш байдлыг хангахад тодорхой чиглэсэн байдлаар орон нутгийн засаг захиргаа, сургууль, суралцагчдад санхүүжилт шилжүүлэх механизмыг хамардаг бөгөөд энэ талаар тайлангийн шударга тэгш байдлын тухай бүлэгт дэлгэрэнгүй авч үзсэн.

Сурах бичгийг үнэ төлбөргүй олгох нь боловсролын хамран сургалт болон ирцийг нэмэгдүүлдэг болохыг судалгааны нотолгоо харуулж байна. Мөнгөн дэмжлэгээс гадна мөнгөн бус хэлбэрээр олгох дэмжлэг нь өрхийн нөхцөлөөс үүдэлтэй хязгаарлалтыг бууруулах боломжтой. Кавказ болон Төв Азийн орнуудад сурах бичиг түрээслүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж иржээ. Хятадад “Хоёр төлбөрийн чөлөөлөлт, нэг татаас” хөтөлбөрийн хүрээнд сурах бичгийн төлбөрөөс чөлөөлөх арга хэмжээг ядуу, хөдөө орон нутгийн өрхүүдэд олгох мөнгөн татаастай хослуулснаар суурь боловсролын хамран сургалтыг 12 хувийн пунктээр нэмэгдүүлжээ. Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улсад сурах бичгийн хүртээмж нэмэгдсэнээр суралцагчдын бага боловсрол төгсөх шалгалтад тэнцэх магадлал 7 хувийн пунктээр нэмэгджээ. Сурагчийн дүрэмт хувцасны зардал мөн өрхүүдэд ихээхэн дарамт учруулж болох боловч дүрэмт хувцас худалдан авахад дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийг боловсролтой холбоотой бусад зардлыг төлөхөөс чөлөөлөх арга хэмжээтэй хослуулан багц хэлбэрээр хэрэгжүүлэх шаардлагатай.

Сургуульд суурилсан эрүүл мэнд болон эрүүл мэндийг дэмжигч сургууль нь боловсролын хамрагдалт, анги түвшин ахин суралцах байдалд нөлөөлдөг. Туршилтын судалгаануудаас үзэхэд шимэгч хорхойн эсрэг эмчилгээ нь сургуулийн ирцийг сайжруулж, дүнд боловсролд шилжин суралцах болон боловсрол эзэмшсэн түвшнийг нэмэгдүүлдэг байна. Үүний үр дүнд эмчилгээний өргөн хүрээний кампанит ажлууд хэрэгжүүлэх болсон бөгөөд тэдгээр нь ихэнхдээ эерэг нөлөө үзүүлсэн ч туршилтын судалгаанд ажиглагдсантай ижил хэмжээнд хүрээгүй байна. Энэ нь ариун цэврийн нөхцөлийг сайжруулахад мөн хөрөнгө оруулах шаардлагатайг харуулж байна. Хумхаа өвчний эмчилгээ болон урьдчилан сэргийлэх эмийн хэрэглээ нь Гамби, Мозамбик, Шри Ланка зэрэг олон янзын нөхцөлд сургуулийн ирц болон боловсрол эзэмшсэн түвшнийг нэмэгдүүлжээ.

Арга хэмжээнүүд нь мөн сургуулиас эрт гарах эрсдэлтэй суралцагчид, тэдний эцэг эх, сургууль болон мэргэжилтнүүдийн хоорондын харилцаа холбоог бэхжүүлэхэд чиглэдэг. Боловсролын үр өгөөж эсвэл суралцагчдын хүлээх үүргийн талаар үнэн зөв мэдээлэл өгөх нь ирц болон төгсөлтийн хувьд тодорхой үр өгөөжтэй холбоотой байсан боловч үүнийг нотолсон баримт гол төлөв туршилтын судалгаанаас гарсан байна. Эцэг эх, олон нийтийн оролцоог идэвхжүүлэх хүчин чармайлт нь зарчмын хувьд ирцийг сайжруулах учиртай боловч шалтгаан-үрдагаврын нөлөөг судалсан судалгаа ховор бөгөөд судалгааны үр дүн нь боломж тааруу болон давуу нөхцөлтэй гэр бүлүүдийн нийгмийн капиталын ялгаа нөлөөлж болохыг олонтоо онцолдог. Сургуулиас эрт гарах эрсдэлтэй өсвөр үеийнхэнд өндөр хүлээлт тавих, тэдэнтэй тогтмол холбоотой байж явцыг нь анхаарах, эерэг харилцаа тогтооход нь дэмжлэг үзүүлэх, зөвлөн чиглүүлэх үйлчилгээ үзүүлэх замаар хүндрэлтэй нөхцөлд зөв арга замаа олоход нь тусалж чадах итгэл хүлээсэн насанд хүрэгчдийн дэмжлэг үр өгөөжтэй байдаг.

НИЙЛҮҮЛЭЛТИЙГ ДЭМЖИХ БОДЛОГО

Дэд бүтцэд оруулах хөрөнгө оруулалт нь боловсролын хамрагдалтыг нэмэгдүүлэхэд нэн чухал. Индонез болон Туркэд орон нутагт ойр сургууль барьсан нь боловсролын хамрагдалтыг нэмэгдүүлэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн бол Сахарын цөлөөс өмнөх Африкийн ихэнх хэсэгт 2010–2020 онд шинэ сургууль барих ажил зогсонги байдалд орсон эсвэл буурсан бөгөөд үүний онцгой тохиолдол нь арван жилийн сүүл үед Руандад ажиглагдсан өсөлт байв. Египет, Гондурас зэрэг улсад орон нутагт түшиглэсэн сургуулиудыг байгуулах нь өөр нэг арга зам байжээ. Хятад болон Ганад дотуур байр чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Энэтхэгт охид, хөвгүүдэд зориулсан тусдаа ариун цэврийн байгууламж барих төрийн хөтөлбөр охидын боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлжээ. Хөдөө орон нутгийн айл өрх, сургуулиудыг цахилгаан эрчим хүчээр хангах нь Бразил, Камбож, Кенид боловсрол эзэмшсэн түвшнийг нэмэгдүүлэхэд дэмжлэг болжээ. Күүкийн арлууд, Шинэ Зеланд, Ниуэ, Токелауд хэрэгжүүлсэн зайн сургалт, мөн Папуа Шинэ Гвинейд 10–12 дугаар ангийн суралцагчдад зориулсан зайн сургалт нь хөдөө орон нутаг, алслагдсан бүс нутгийн болон бусад боломж тааруу залуучуудад боловсрол эзэмших шинэ боломж нээжээ. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байр, байгууламжид оруулсан хөрөнгө оруулалтын үр нөлөө нь Австри, Гватемал, Уругвай зэрэг улсад дээд боловсрол эзэмшсэн түвшинд хүртэл илэрчээ.

Хувийн сургуулиуд өргөжсөн ч энэ нь нийт хамран сургалтыг нэмэгдүүлэхээс илүүтэйгээр суралцагчдын төрийн болон хувийн сургуулийн хоорондох хуваарилалтыг өөрчилжээ. 42 улсын хэмжээнд хамгийн чинээлэг өрхийн хүүхдүүд хамгийн ядуу өрхийн хүүхдүүдтэй харьцуулахад хувийн сургуульд суралцах магадлал 10 дахин өндөр байжээ. Олон судалгаа хувийн сургуулиуд төрийн сургуулиас илүү үр ашигтай, илүү үр дүнтэй ажилласнаар боловсролын хамран сургалтыг


шууд бусаар нэмэгдүүлсэн байж болох эсэхэд төвлөрдөг. Хувийн үйлчилгээ үзүүлэгчтэй гэрээлэн боловсролын үйлчилгээ үзүүлэх зохицуулалтын талаарх системчилсэн тойм судалгаануудаас үзэхэд гэрээ байгуулах журам, хэрэгжилтэд тавих хяналт, зохицуулалтын чадавхаас шалтгаалан үр дүн ихээхэн ялгаатай байсан боловч ерөнхийдөө тэр бүү хэл Либери, Пакистаны олны анхааралд өргөн хүрсэн жишээнүүдэд ч иймэрхүү зохицуулалт нь хамран сургалтыг нэмэгдүүлээгүй байна.

Улс орнууд тэгш хамруулах боловсролыг хэрэгжүүлэхэд улам бүр тууштай хандаж байна. Боломж тааруу суралцагчдыг сургуульд хамрагдах, анги, түвшин ахин суралцах, төгсөхөд нь дэмждэг тэгш хамруулах орчныг дараах гурван чиглэлээр улам бүр дэмжих болжээ. Нэгдүгээрт, тэгш хамруулах боловсролын тодорхойлолтыг хөгжлийн бэрхшээлээс гадна боломж тааруу байдлын бусад хэлбэрийг хамруулахаар өргөжүүлсэн орнуудын эзлэх хувь 2020 онд 75% байсан бол 2025 онд 82% болж өсжээ. Хоёрдугаарт, суралцагчдыг сургуульд хуваарилах бодлогын хувьд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг ердийн сургуульд суралцуулахыг хууль тогтоомжоороо дэмждэг орнуудын эзлэх хувь 17%-аас 29% болж нэмэгджээ (Зураг 5). Гуравдугаарт, зарим хүүхдээс одоо байгаа боловсролын орчинд дасан зохицохыг шаарддаг хандлагаас тэгш хамруулах хандлага руу шилжиж буй үзэл хандлагын өөрчлөлт мөн ажиглагдаж байна.

ЗУРАГ 5:

Тэгш хамруулах боловсролын талаарх хууль тогтоомжийг улс орнууд өргөнөөр батлан хэрэгжүүлж байна

Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын суралцах сургуулийн зохион байгуулалтаар улс орнуудын тархалт, 2025 он



БХШ-ний статистик: https://bit.ly/GEM2026_Summary_fig5

Эх сурвалж: PEER улс орны танилцуулгад үндэслэн Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайлангийн багийн хийсэн шинжилгээ

Суралцах аюулгүй орчин улам бүр чухал болж байна. Сургуулийн аюулгүй байдалд хүчирхийлэл, халдлага, байгалийн гамшиг сөргөөр нөлөөлдөг бөгөөд эдгээр нь бүгд сургуулийн ирцийг бууруулж, улмаар сургууль завсардалтад хүргэж болзошгүй. Хүчирхийллийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн арга хэмжээнд нийгэм-сэтгэл хөдлөлийн хөгжлийг дэмжих сургуулийн болон орон нутгийн түвшний арга хэмжээ; хатуу чанд боловч шударга, хүндэтгэлд суурилсан сургуулийн дүрэм нэвтрүүлэх; хүчирхийллийг эсэргүүцэх нийгмийн хариуцлагатай зан үйлийг төлөвшүүлэх; суралцагчдыг хооронд нь холбосон харилцааг бэхжүүлэх зэрэг багтана. Зөрчил мөргөлдөөний улмаас боловсролын тогтолцоо нуран унадагтай бол зөрчил мөргөлдөөний дараа нөхцөл байдлыг урьдчилан таамаглах боломж, төрийн байгууллагуудын хүлээн зөвшөөрөгдсөн байдал болон тэдгээрт итгэх итгэл сэргэсэн тохиолдолд боловсролын тогтолцоо дараа нь ихэвчлэн эргэн сэргэдэг бөгөөд Камбож үүний нэг жишээ юм. Гамшгийн эрсдэлийг бууруулахад бүтцийн арга хэмжээ (жишээлбэл, аюулт үзэгдэлд тэсвэртэй сургуулийн барилгын зураг төсөл)-г бүтцийн бус арга хэмжээ (жишээлбэл, болзошгүй нөхцөл байдлын төлөвлөлт, багшийн сургалт, сургуульд суурилсан бэлэн байдлын журам)-тэй хослуулан хэрэгжүүлдэг.

ДУНД БОЛОВСРОЛЫН ДАРААХ БОЛОВСРОЛ

ГОЛ ЧИГ ХАНДЛАГА

Дээд боловсролын хамрагдалт хурдацтай өргөжсөн боловч төгсөлт ижил хурдаар нэмэгдсэнгүй. Өнгөрсөн 25 жилийн хугацаанд боловсролын хүртээмж болон төгсөлтийн хоорондын зөрүү улам нэмэгджээ. Дээд боловсролын хамран сургалтын бохир жин 2000-2024 онд 19%-аас 44% болж хоёр дахинаас илүү нэмэгдсэн буюу жилд нэг хувийн пунктээр өсжээ. Харин мөн хугацаанд төгсөлтийн хувь үүний хагасаас ч бага хурдаар өсөж, 17%-аас 27% болж нэмэгдсэн байна.


Дээд боловсролын ахицыг зөвхөн хамран сургалтын үзүүлэлтээр хэмжих нь хангалтгүй. Хамран сургалтын үзүүлэлтүүд нь суралцагчдын насны бүтэц, сургалтын хөтөлбөрийн үргэлжлэх хугацаа, бүтэн бус цагаар суралцах хэлбэрийн ихээхэн ялгааг харгалзан үздэггүй. Сургалтын хугацаа урт боловсролын тогтолцоо нь бодитоор илүү олон суралцагчийг хамруулаагүй ч хамрагдалт өндөр мэт харагдаж болно. Ийм төрлийн хэмжилт нь хэд хэдэн хөтөлбөрт элсэн суралцаж буй эсвэл нэмэлт зэрэг эзэмшихээр эргэн суралцаж буй хүмүүсийг давхар тоолоход хүргэж болно. ЭЗХАХБ-ын хэд хэдэн оронд бакалаврын зэрэг эзэмшсэн төгсөгчдийн 25 орчим хувь нь дээд боловсролын өөр нэг мэргэшлийг аль хэдийн эзэмшсэн байдаг. Түүнчлэн гадаадын оюутан олноор хүлээн авдаг боловсролын тогтолцоонд хамран сургалтын харьцаа бодит хэмжээнээс өндөр гардаг бөгөөд 40-өөс доошгүй улсад дээд боловсролын суралцагчдын 10 гаруй хувийг боловсрол эзэмшихээр улс хооронд шилжсэн суралцагчид эзэлж байна.

Боловсрол эзэмшсэн түвшин нь зэрэг эзэмшсэн хүн амын эзлэх хувийг харуулдаг. 2024 онд дэлхийн хэмжээнд дээд боловсрол эзэмшсэн түвшин 45–54 насныхны дунд 15% байсан бол 25–34 насныхны дунд 24% байв (Зураг 6). 25–34 насныхны боловсрол эзэмшсэн түвшинд төвлөрөхөд хамгийн сүүлийн үеийн залуучуудын ахиц уг үзүүлэлтэд тодорхой хугацааны хоцрогдолтойгоор л тусна. Гэсэн хэдий ч энэ нь илүү ойлгомжтой, улс орнуудын хооронд харьцуулах боломжтой хэмжүүр юм. Улс орнуудын хэмжээнд 25–34 насныхны дээд боловсрол эзэмшсэн түвшин нь 10 жилийн өмнө ажиглагдсан дээд боловсролын хамран сургалтын бохир жингийн ердөө 60 орчим хувьтай тогтмол тэнцэж байгаа нь хамран сургалтын харьцаагаар зэрэг эзэмших хүмүүсийн бодит хэмжээг нэлээд хэтрүүлэн тооцдог болохыг баталж байна. Дундаас дээш болон өндөр орлоготой хэд хэдэн оронд бакалаврын хөтөлбөрийн нэгдүгээр курсийн суралцагчдын сургууль завсардалт 15–20%, түүнээс дээш байна. Европын Холбоо 25–34 насныхны дунд дээд боловсролын мэргэшил эзэмшсэн хүмүүсийн эзлэх хувь 2020 онд 40% байсныг 2030 он гэхэд 45%-аас доошгүй болгох зорилт тавьсан. Дэлхийн хэмжээнд 25–29 насны бүлгийг сонгох нь хамгийн үндэслэлтэй хувилбар байж болох бол 30–34 насныхны боловсрол эзэмшсэн түвшнийг бага болон дунд боловсролын төгсөлтийг хэмжихэд ашигладаг аргачлалтай адилтган “хожуу” төгсөлтийн хувийг хэмжихэд ашиглаж болох юм. Хугацаандаа төгсөх хувь Чилид 13% байгаа бол Ирланд болон Их Британид 65%-аас давж байна. Боловсрол эзэмшсэн түвшний үзүүлэлтийг насны бүтэц, сургалтын хөтөлбөрийн төрлийн талаарх мэдээлэлтэй хамтатган авч үзэх шаардлагатай.

ЗУРАГ 6:

Дээд боловсрол эзэмшсэн түвшин үе хооронд нэмэгджээ

Дээд боловсрол эзэмшсэн 25–34 болон 45–54 насныхны эзлэх хувь, 2024 он эсвэл түүнээс хойших хамгийн сүүлийн жил



БХШ-ний статистик: https://bit.ly/GEM2026_Summary_fig6

Эх сурвалж: ОУХБ-ын мэдээллийн сан

УЛС ОРНЫ КЕЙС СУДАЛГАА

Улс орны кейс судалгаанууд нь 2000 оноос хойш дэлхийн улс орнуудад хуримтлагдсан олон янзын туршлагыг харуулж байна. **Беларуст** дээд боловсролын хамран сургалтын бохир жин 1991 онд 48% байсан бол 2013 онд 96% болж өсөөд, 2024 он гэхэд 70% болж буурсан, үүний зэрэгцээ дээд боловсролд хамрагдсан суралцагчдын тоо огцом буурсан нь хүн ам зүйн өөрчлөлттэй давхцаж байна. Сүүлийн үеийн энэхүү бууралт нь боловсролын байгууллагууд болон хөдөлмөрийн зах зээлд гарч буй өөрчлөлтийг илэрхийлж байна. Гэсэн хэдий ч Беларусь дундаас дээгүүр орлоготой бусад оронтой харьцуулахад дээд боловсролын хамрагдалтын түвшин харьцангуй өндөр хэвээр байгаа нь түүхэн уламжлалтай, хүн амын өргөн хүрээг хамарсан дээд боловсролын тогтолцооны өвтэй холбоотой. **Чилид** дээд боловсролын хамрагдалт 2000 онд 40%-аас доогуур байсан бол 2022 он гэхэд 100%-аас давж, бүс нутгийн болон өндөр орлоготой орнуудын бүлгийн дунджаас дээгүүр гарчээ. Зах зээлийн зарчимд тулгуурласан боловсролын хүртээмжийн загвар нь дээд боловсролын байгууллагуудыг төрөлжүүлж, нэр хүндтэй их сургуулиудын сонгон шалгаруулалт бүхий элсэлтийг их сургуулийн бус дээд боловсролын чиглэлүүдийн илүү нээлттэй элсэлттэй хослуулсан нь хамрагдалтыг өргөжүүлсэн боловч ялгарал, давхраажсан бүтцийг улам бэхжүүлжээ. Сүүлийн үед сургалтын төлбөргүй хөтөлбөрийн хүрээнд магадлан итгэмжлэлд тавигдах шаардлагын хамрах хүрээг өргөжүүлсэн бол зорилтот санаачилгууд нь шударга тэгш байдлыг сайжруулахын тулд төрийн дэмжлэгийг нэмэгдүүлэх чиглэлд шилжиж буйг харуулж байна.

Хятад улс дээд боловсролын хүртээмжийг урьд өмнө байгаагүй хурдаар өргөжүүлж, хамран сургалт 1999 онд 7% байсан бол 2024 онд 77%-д хүрчээ. Энэ өсөлтийн эхлэл нь дээд боловсролын хамран сургалтын боломжийг өргөжүүлснээр дээд боловсролын хөтөлбөр болон байгууллагын тоо өссөн 1998 онтой холбогдоно. Мужийн засаг захиргаанд боловсролын байгууллага байгуулах эрх мэдлийг бие даан хэрэгжүүлэх боломж олгосноор олон шинэ байгууллага байгуулагдаж, тэдгээрийн олонх нь богино хугацааны болон мэргэжлийн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлж байсан бол төв засгийн газар цөөн тооны тэргүүлэх их сургуульд санхүүжилтээ төвлөрүүлжээ. Дээд боловсролын хүртээмж шатлан ялгарсан хэв шинжтэй боловч суралцагчдад үзүүлэх санхүүгийн дэмжлэгийн сайн тогтолцоог хөгжүүлсэн байна. **Фижид** өнгөрсөн 18 жилийн хугацаанд дээд боловсролын хамран сургалт 46 хувийн пунктээр нэмэгдэж, Жижиг арлын хөгжиж буй орнуудад боловсролын үйлчилгээг өргөн цар хүрээнд хүргэхэд тулгардаг хязгаарлалтыг үл харгалзан Номхон далайн бүсэд хамгийн өргөн хүрээтэйд тооцогдох дээд боловсролын тогтолцооны нэгийг бүрдүүлжээ. Фижи нь бүс нутгийн хамтын ажиллагааны төв байсны зэрэгцээ КОВИД-19 цар тахлын үед онцгой ач холбогдолтой байсан цахим болон зайн сургалтыг өргөжүүлсэн нь бүс нутгийн бусад орноос суралцагчид татах, өөрийн хүн амын дээд боловсрол эзэмших боломжийг өргөжүүлэхэд хувь нэмэр оруулжээ. Энэхүү өсөлтийг тэтгэлэг, орлогоос хамааран эргэн төлөх зээл, дээд боловсролын үйлчилгээ үзүүлэгчдэд олгох татаас зэрэг төрийн санхүүжилтээр дэмжсэн байна.

Саудын Араб газрын тосонд суурилсан эдийн засгаас мэдлэгт суурилсан эдийн засагт шилжих явцдаа дээд боловсролын тогтолцоогоо өргөжүүлжээ. Төрийн хөрөнгө оруулалтаар дээд боловсролыг үнэ төлбөргүй эсвэл бага төлбөртэй эзэмших боломжийг нэмэгдүүлснээр 2009–2019 онд хамран сургалтын бохир жин жилд таван хувийн пунктээр өссөн байна. Үндэсний “Алсын хараа 2030” төлөвлөгөөтэй боловсролын уялдааг хангахад бодлогын түвшинд түлхүү анхаарч, инженерчлэл, мэдээлэл харилцаа холбооны технологи, бизнесийн удирдлагын чиглэлээр зэрэг эзэмшүүлэхэд онцгой ач холбогдол өгч байна. **Тайландад** дээд боловсролын хамран сургалтын бохир жин 2001-2011 онд 39%-аас 53% болж өссөн ч түүнээс хойш буурч, өмнөх түвшиндээ эргэн хүрээгүй байна. Үндэсний хэмжээнд мөрддөг элсэлтийн тогтолцооны хязгаарлагч хүчин зүйл болон төрийн зардлын бууралт нь дээд боловсролын өргөжилтийг хязгаарлажээ. Харин эерэг тал нь техник, мэргэжлийн боловсролын тогтолцоо бэхжиж, хөдөлмөрийн зах зээл дээр боловсролын өгөөж өөрчлөгдсөнөөр суралцагчид дээд боловсролын уламжлалт замналаас өөр чиглэлийг сонгох болсон байна. **Тогод** дээд боловсролын хамран сургалт 2006-2020 онд 5%-аас 15% болж өсөж, Сахарын цөлөөс өмнөх Африкийн дунджаас давжээ. Дүнд боловсролын түвшинд суралцагчдын ахиц сайжирсан нь дээд боловсролын эрэлтийг нэмэгдүүлсэн бөгөөд өргөн хүрээнд олгодог тэтгэлэг энэ өсөлтийг дэмжжээ. Хурдацтай өргөжилт нь хөрөнгө чинээ болон хүйсийн зөрүү, боловсролын чанар, нийцтэй байдал, төгсөлттэй холбоотой хүндрэлүүдийг ил болгож, улмаар засгийн газраас сургалтын хөтөлбөрүүдийг хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээтэй уялдуулах, тэтгэлэг хуваарилахад ашиглах өгөгдлийг сайжруулах чиглэлээр арга хэмжээ авахад хүргэжээ.

БОДЛОГЫН ШИНЖИЛГЭЭ

Дүнд боловсролын дараах боловсрол нь цөөнхийн давуу боломж байснаас өргөн хүрээг хамарсан боловсрол болон өөрчлөгджээ. Бодлого нь санхүүгийн хязгаарлалтыг бууруулах, боловсролын үйлчилгээний хэлбэрийг төрөлжүүлэхийн зэрэгцээ тогтолцоог шууд хянахаас илүүтэй чиглүүлэн удирдахад төвлөрч, боловсролын байгууллагуудын бие даасан байдлыг нэмэгдүүлэх, чанарын баталгаажуулалтыг бэхжүүлэх, зардлыг хуваалцахад түлхүү анхаарч иржээ. Гэсэн хэдий

ч шударга тэгш байдлыг хангахад босоо буюу хувь хүний онцлог шинжээс үүдэлтэй, мөн хэвтээ буюу боловсролын байгууллагуудын шатлал нь суралцагчид ямар хөтөлбөрт хамрагдах, тухайн хөтөлбөрөөс ямар үр өгөөж хүртэхийг тодорхойлдогтой холбоотой бэрхшээлүүд хэвээр байна. Боловсролын байгууллага болон өрхийн түвшинд ч хүндрэлүүд тулгардаг бөгөөд санхүүгийн дарамт, бусдыг асран халамжлах үүрэг, сэтгэцийн эрүүл мэнд, боловсролын байгууллагын соёл, сургалтын хэл зэрэг хүчин зүйл нь хэн суралцах явцаа үргэлжлүүлэх, хэн суралцсанаасаа бүрэн үр өгөөж хүртэхэд нөлөөлдөг. Ерөнхийд нь авч үзвэл, шударга тэгш өргөжилт нь аль нэг бодлогын арга хэмжээнээс илүүтэй чанарын баталгаажуулалт, уян хатан боловсролын замнал, үр өгөөжийг хэн хүртэж байгааг үнэлэх үйл явцыг суурь болгосон эрэлт болон нийлүүлэлтийн талын арга хэмжээг харилцан уялдаатай хослуулан хэрэгжүүлэхээс хамаардаг.

ЭРЭЛТИЙГ ДЭМЖИХ БОДЛОГО

Дээд боловсролын эрэлт нь зардлыг даах боломжоор хязгаарлагддаг. Улс орнууд санхүүгийн саад бэрхшээлийг бууруулахын тулд сургалтын төлбөрөөс чөлөөлөх, тэтгэлэг, буцалтгүй санхүүжилт, зээл зэрэг дэмжлэгийг хослуулан ашигладаг. Таван улс тутмын дөрөв орчим нь ядуурал, газар зүйн хувьд боломж тааруу байдал, хөгжлийн бэрхшээлийг харгалзан суралцагчдад санхүүгийн дэмжлэг олгодог. Гол төлөв өндөр орлоготой орнуудын судалгааны нотолгооноос үзэхэд зардлыг бууруулах нь хамран сургалтыг нэмэгдүүлэх боломжтой боловч үр нөлөө нь тухайн үеийн хамрагдалтын түвшин болон хөтөлбөрийг хэрхэн зохион байгуулснаас хамаардаг.

Сургалтын төлбөрийн бодлого улс орнуудад ихээхэн ялгаатай. Улс орнуудын гуравны нэг орчим нь, Латин Америкт 52% нь улсын их сургуулиудаа сургалтын төлбөргүй гэж зарласан байна. Гэвч зөвхөн сургалтын төлбөргүй болгох нь тэгш бус байдлыг арилгадаггүй. Бразил, Чилид бага орлоготой суралцагчдад чиглэсэн сургалтын төлбөрийн татаас хамран сургалтыг нэмэгдүүлжээ. Колумбид саяхан гаргасан бага орлоготой залуучуудыг сургалтын төлбөрөөс чөлөөлөх тухай тогтоол нь улсын их сургуулийн хүртээмжийг өргөжүүлсэн боловч суралцагчдын бараг тал хувь нь төгсөж чадаагүй байна. Гана, Филиппин зэрэг дунд орлоготой бусад орон ч тодорхой бүлгүүдийг сургалтын төлбөрөөс чөлөөлснөөр ядуу иргэдийн хамрагдалтыг нэмэгдүүлсэн боловч тогтмол өндөр хэвээр байгаа сургууль завсардалтын түвшнийг бууруулж чадаагүй байна. Германд сургалтын төлбөр харьцангуй бага байсан ч хамран сургалт буурахад хүргэсэн бол Англид (Их Британи) сургалтын төлбөр огцом нэмэгдсэн ч голчлон орлогоос хамааран эргэн төлөх зээл, амьжиргааны зардлын дэмжлэгийн үр дүнд хамран сургалт буураагүй, тэгш бус байдал ч нэмэгдээгүй байна. Түүнчлэн засгийн газрууд хэт өндөр төлбөрийг хязгаарлахын тулд сургалтын төлбөрийг зохицуулж, хувийн хэвшилд ч төлбөрийн жишиг хэмжээг тогтоодог.

Таван улс тутмын гурав орчим нь тэтгэлэг олгодог. Индонезийн Bidikmisi, түүнийг залгамжилсан KIP тэтгэлэг, мөн Япон, Шри Ланкад хэрэгжүүлсэн тэтгэлгийн шинэчлэл нь боломж тааруу суралцагчдын дээд боловсролын хүртээмжийг өргөжүүлсэн боловч хамран сургалтад гарсан ахиц нь төгсөлтийн үзүүлэлтэд тэр бүр тусдаггүй. Боливийн Олон Үндэстний Улс, Эквадор, Мексик, Вьетнам зэрэг орон боловсролын байгууллагуудаас орлогынхоо тодорхой хувийг тэтгэлэгт зарцуулах эсвэл суралцах орон тооныхоо тодорхой хувийг тэтгэлэг хүртэгчдэд хуваарилахыг шаарддаг бол Бразил, Камбож, Энэтхэг, Пакистаны судалгааны нотолгоо төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг өргөжүүлснээр боломж тааруу бүлгүүдийн хамрагдалт нэмэгдсэнийг харуулж байна.

Суралцагчдад олгох татаас нь олон төрлийн зардлыг хамардаг. Франц, Ирланд, Итали, Португалд хийсэн үнэлгээнүүдээс үзэхэд хэрэгцээнд суурилсан буцалтгүй санхүүжилт нь сургууль завсардалтыг бууруулж, хүгацаандаа төгсөх боломжийг нэмэгдүүлдэг бөгөөд ялангуяа түүний хэмжээ амьжиргааны зардлын өсөлттэй уялдан нэмэгдэж, оюутны байрны бодлого зэрэг арга хэмжээтэй хослон хэрэгжих үед үр нөлөө нь илүү байдаг. Олон улс оронд тодорхой бүлгүүдэд чиглэсэн зорилтот санхүүгийн дэмжлэг хэрэгжүүлдэг. Канад, Колумби, Өмнөд Африк нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг оролцуулан боломж тааруу суралцагчдад тэргүүн ээлжид чиглэсэн буцалтгүй санхүүжилт эсвэл амьжиргааны зардлын дэмжлэг олгодог. Мөн мөнгөн бус хэлбэрийн татаас түгээмэл бөгөөд 10 улс тутмын бараг 5 нь суралцагчдын байрны зардалд, 10 улс тутмын 4 нь тээврийн зардалд, 10 улс тутмын 3 хүрэхгүй нь сурах бичгийн зардалд татаас олгодог.

Суралцагчийн зээл үндсэндээ гурван загвартай. Үүнд төрөөс санхүүжүүлдэг зээл, хувийн зээлдүүлэгчидтэй эрсдэлийг хуваалцах тогтолцоо, татвар эсвэл нийгмийн даатгалын тогтолцоогоор дамжуулан орлогоос хамааран эргэн төлөх зээл багтана. Ямайка, Гана, Малайз, Вьетнам зэрэг дунд орлоготой орнууд зээлийн төрөл бүрийн хувилбарыг туршиж ирсэн боловч өндөр хүү, батлан даагч шаардах зэрэг зээлийн загварын дутагдал нь хамгийн ядуу иргэдийн хүртээмжийг ихэвчлэн хязгаарладаг. Харин Шинэ Зеланд, Япон, Өмнөд Африкийн жишээнээс харахад зээлийг оновчтой загварчилсан нөхцөлд хамран сургалтыг нэмэгдүүлж, суралцагчдыг үргэлжлүүлэн суралцахад дэмжлэг үзүүлэх боломжтой. Гэвч өрийн дарамт нь дээд боловсролд хамрагдахаас татгалзахад хүргэх томоохон хүчин зүйл болдог. Өрийн хэмжээ 1,000 ам.доллар тутмаар нэмэгдэхэд сургууль завсардалтын хувь 3%-аар өсдөг

гэж тооцоолсон бөгөөд 1,000 ам.долларoос давсан өр нь төгсөлтийн хувь доогуур байхтай хүчтэй хамааралтай байна. Англид (Их Британи) төгсөгчдийн өрийн дундаж хэмжээ дэлхийд хамгийн өндөрт тооцогддог бөгөөд амьжиргааны зардлын зээл нь амьжиргааны нийт зардлыг нөхөхөд хүрэлцэхгүй байх нь түгээмэл. Мэдээллээр хангах бодлого нь элсэлт болон санхүүгийн дэмжлэгийн талаар хангалттай ойлголтгүй байх нь түгээмэл байдаг бага орлоготой өрхийн болон гэр бүлээсээ анх удаа дээд боловсрол эзэмшиж буй суралцагчдыг дэмждэг. Чилид сургалтын хөтөлбөр тус бүрийн төгсөгчдийн орлогын мэдээллийг нийтэлж, зөвлөн чиглүүлэх үйлчилгээ үзүүлснээр элсэгчид өгөөж багатай хөтөлбөрөөс өөр сонголт хийх болсон. Английн Uni Connect болон Австралийн ижил төстэй хөтөлбөр зэрэг суралцагчдад хүрч ажиллах санаачилгууд нь дээд боловсрол эзэмших хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлдэг боловч нэг удаа мэдээлэл өгөхөөс илүү үргэлжилсэн зөвлөн чиглүүлэх үйлчилгээ үр нөлөөтэй болохыг үнэлгээнүүд харуулжээ.

Өндөр орлоготой зарим орон тэгш хамруулах бодлогын зорилтыг хэрэгжүүлэхэд нь зориулж боловсролын байгууллагуудад санхүүжилт олгодог. Улс орнуудын 18 орчим хувь нь боловсролын байгууллагуудад нөхцөлт буцалтгүй санхүүжилт олгодог бөгөөд энэ үзүүлэлт бага орлоготой орнуудад 4%, дунд орлоготой орнуудад 18%, өндөр орлоготой орнуудад 27% байна. Эдгээр буцалтгүй санхүүжилтийн 64% нь ядуурал, 49% нь газар зүйн хувьд боломж тааруу байдал, 46% нь хөгжлийн бэрхшээл эсвэл боловсролын түгсгай хэрэгцээ, 34% нь уугуул иргэд болон үндэстний цөөнх, 26% нь хүйс, 14% нь дүрвэгсдэд чиглэдэг.

Академик түвшин нөхөх сургалт, зөвлөн чиглүүлэх дэмжлэг, үе тэнгийнхний дэмжлэг зэрэг нөхөх арга хэмжээ нь суралцагчдыг төгсөхөд нэн чухал. Үүнийг Африкийн өмнөд хэсгийн суурь бэлтгэл хөтөлбөрүүд, Колумбийн их сургуулиудын дэмжлэгийн нэгдсэн загварууд, Энэтхэгийн зөвлөн чиглүүлэх хөтөлбөрүүдийн туршлага харуулж байна. Сургалтын хэл нь саад бэрхшээл хэвээр байгаа бөгөөд англи хэлээр сургалт явуулдаг хөтөлбөрүүд боломж олгохын зэрэгцээ боломж тааруу суралцагчдын төгсөлтийн хувьд сөргөөр нөлөөлж байна.

НИЙЛҮҮЛЭЛТИЙГ ДЭМЖИХ БОДЛОГО

Засгийн газрууд төрийн болон хувийн хэвшлийн оролцооны зохистой харьцааг хангаж, боловсролын ялгарал, давхраажилтыг бэхжүүлэхгүйгээр боловсролын үйлчилгээний хэлбэрийг төрөлжүүлэх шаардлагатай. Аргентин, Хятад, Саудын Араб зэрэг орон төрийн санхүүжилтийг ашиглах, боловсролын үйлчилгээ хангалтгүй бүс нутагт шинэ их сургууль байгуулах замаар хүртээмжийг өргөжүүлэхийн зэрэгцээ төрийн боловсролын үйлчилгээний эзлэх хувийг өндөр түвшинд хадгалж, хамран сургалтыг нэмэгдүүлжээ. Этиоп төрийн их сургуулиуд болон магадлан итгэмжлэгдсэн хувийн боловсролын байгууллагуудыг аль алиныг нь хурдацтай өргөжүүлсэн холимог загварыг хэрэгжүүлжээ. 2015 оноос хойш дээд боловсролд зарцуулах төрийн зардлаа нэмэгдүүлсэн орнуудаас бууруулсан орны тоо гурав дахин олон байна.

Зарим оронд дээд боловсрол хувийн боловсролын байгууллагуудаар дамжин өргөжсөн. Дэлхийн хэмжээнд дээд боловсролын хамран сургалтын гуравны нэг орчим хувийг хувийн дээд боловсролын байгууллагууд эзэлдэг бөгөөд энэ хувь 2000 оноос хойш тогтвортой хэвээр байгаа бололтой. Дунд боловсролын төгсөлт болон хотжилтын түвшин өндөр орнуудад, тухайлбал Төв болон Зүүн Европын орнуудад хувийн дээд боловсролын байгууллагуудын өсөлт нь нийт хамран сургалтын өсөлттэй хамааралтай байна. Чилид мөн 1980-аад онд хувийн их сургуулиудад дээд боловсролын салбарт үйл ажиллагаа явуулах боломжийг нээснээр төрийн баталгаатай зээл болон сургалтын төлбөрийн зорилтот чөлөөлөлтийн дэмжлэгтэйгээр хамран сургалт 8%-аас 50 гаруй хувь болж өсжээ. 2024 он гэхэд улс орнуудын 87% нь хувийн дээд боловсролын өргөжилтийг зохицуулах үндэсний чанарын баталгаажуулалтын байгууллагатай болсон байна. Индонез, Ливи, Тогод хууран мэхлэх үйл ажиллагаа явуулдаг боловсролын байгууллагуудыг хязгаарлахын тулд түсгай зөвшөөрлийн шаардлагыг чангатгажээ. Харин Ботсвана, Энэтхэг, Мексикт чадавх хязгаарлагдмал эсвэл магадлан итгэмжлэл сайн дурын үндсэн дээр явагддаг тул хяналт сул байж ирсэн, боломж тааруу суралцагчид чанар доогуур зэрэг олгох хөтөлбөрт хамрагдах эрсдэлтэй байна.

Нээлттэй болон зайн боловсрол нь хүртээмжийг өргөжүүлэхэд хувь нэмэр оруулсан. Хятад, Энэтхэг, Индонез, Нигери, Пакистан, Турк дэх дэлхийн хамгийн том нээлттэй их сургуулиуд дээд боловсролын нийт хамран сургалтын 4%-ийг бүрдүүлдэг. Бразилд дээд боловсролын суралцагчдын тал хувь нь зайн сургалтын хэлбэрээр, гол төлөв хувийн боловсролын байгууллагад суралцдаг. Этиоп, Кени, Нигерид төрийн бус боловсролын үйлчилгээ үзүүлэгчид уян хатан, богино хугацааны мэргэжлийн хөтөлбөрийн хангагдаагүй хэрэгцээг нөхөж иржээ. Цахим технологи нь боловсролын хүртээмжийг өргөжүүлэх боломж олгож байгаа хэдий ч цахим хуваагдал саад бэрхшээл хэвээр байгаа тул интернетийн хүртээмжийг татаасаар дэмжих, дэд бүтцэд хөрөнгө оруулах шаардлагатай байна.

Дээд боловсролын богино хугацааны хөтөлбөрүүд зарим оронд дээд боловсролын өргөжилтийн хувь нэмэр оруулсан. Дэлхийн хэмжээнд дээд боловсролын хамран сургалтын 15 орчим хувь нь богино хугацааны хөтөлбөр хэрэгжүүлдэг байгууллагуудад ногддог гэж тооцоолсон

бөгөөд энэ үзүүлэлт бага зэрэг буурах хандлагатай байна. Гэвч ийм байгууллагууд Хятад, Кот-д'Ивуар, Колумби, Испани, Турк, АНУ-д чухал үүрэг гүйцэтгэж, хэрэглээний, ихэвчлэн хөдөлмөрийн зах зээлд чиглэсэн сургалтын өөр хувилбаруудыг санал болгодог. Сайтар боловсруулсан тохиолдолд эдгээр хөтөлбөр нь дараагийн түвшний зэрэгт шилжин суралцах боломж олгодог.

Дунд боловсролын дараах мэргэжлийн боловсрол нь төлөөлөл багатай бүлгүүдийн хувьд дээд боловсролд хүрэх үр нөлөө ихтэй байж болох шууд бус зам юм. Дунд боловсролын дараах мэргэжлийн боловсролын үр нөлөө нь сургалтын чанар, нийцтэй байдал, мэргэжлийн болон академик чиглэлийг холбосон уян хатан боловсролын замнал, мөн хүлээн зөвшөөрөх зохицуулалтаас хамаардаг. Австри, Нидерланд, Швейцарт мэргэжлийн дунд боловсролын мэргэшлээс хэрэглээний шинжлэх ухааны их сургуульд шилжин суралцах замыг модульд суурилсан сургалтын хөтөлбөр, сургалтын хөтөлбөрийн уялдааны гэрээ, өмнөх сургалтын үр дүнг хүлээн зөвшөөрөх зохицуулалтаар дэмжин бүрдүүлжээ. Аргентин, Австрали, Канадад шилжүүлэн тооцох кредит, хамтарсан хөтөлбөр, элсэлтийн уян хатан нөхцөл нь коллеж болон их сургуулийн бус байгууллагыг боловсролын мухардмал зам бус, дараагийн шатанд шилжих дамжлага болгодог.

Олон улсын шинжтэй болох үйл явц нь хамрагдалтыг өргөжүүлэхэд багахан үүрэг гүйцэтгэдэг. Гадаад оюутнуудын эзлэх хувь нэмэгдэж байгаа нь Канад, Катар, Турк, Их Британи зэрэг орны дээд боловсролын стратегийн нэг хэсэг юм. Энэ нь хамран сургалтын газар зүйн хуваарилалтыг өөрчилж байгаа төдий байж болох ч гадаадад суралцах нь зарим оронд дотооддоо олдохгүй байж болох боломжийг бүрдүүлж байгаа бөгөөд ийм жишээ Албаниас Номхон далайн арлын орнууд хүртэл бий.

Боловсролын хэлбэрийг төрөлжүүлэх нь зарим нөхцөлд шударга тэгш байдлыг дэмжих боломжтой. Бутан, Хятад, Малайз зэрэг оронд хэрэгжүүлж буй үндэсний мэргэшлийн хүрээ болон кредит шилжүүлэн тооцох тогтолцоо нь мэргэшлийн түвшнийг стандартчилах, мэргэжлийн боловсролын чиглэлээс академик чиглэлд үргэлжлүүлэн суралцах боломж бүрдүүлэх, албан бус болон амьдрах орчноос суралцахуйг үнэлж баталгаажуулах зорилготой. Гэвч эдгээр үйл явц нь ихэвчлэн нарийн төвөгтэй бөгөөд төдийлөн өргөн ашиглагддаггүй. Европт ч суралцагчдын ердөө 10 орчим хувь нь их сургуульд стандарт бус замаар элсэн ордог. Бичил мэргэшил/итгэмжлэл нь уян хатан, модульд суурилсан суралцах боломж олгодог боловч мэргэшлийн хүрээнд нэгтгэгдэж, хүлээн зөвшөөрөгдсөн зэрэг эзэмшихэд тодорхой хувь нэмэр оруулдаг тохиолдолд л дээд боловсролын хамрагдалтыг өргөжүүлнэ.

Элсэлтийн үйл явц болон тусгай арга хэмжээний бодлого нь боловсролын өргөжилт хэр тэгш хамруулсан байхыг тодорхойлдог. Улс орнуудын гуравны нэг орчим нь элсэлтэд зорилтот квот зэрэг тусгай арга хэмжээний ямар нэг хэлбэрийг хэрэгжүүлдэг. Боловсрол зэрэг төрөл бүрийн салбарт 27 оронд хэрэгжүүлсэн тусгай арга хэмжээний бодлогыг тоймлон судлахад нийт тохиолдлын гуравны хоёрт зорилтот бүлгүүдэд эерэг үр дүн гарсан байна. Зорилтот арга хэмжээний үр дүнд төлөөлөл багатай бүлгүүдийн хамран сургалт мэдэгдэхүйц нэмэгдсэн Бразил, Хятад, Энэтхэг, Израил, Шри Ланка зэрэг орны туршлага мөн үүнийг нотолж байгаа боловч зорилтот бус бүлгүүдэд үзүүлэх нөлөө болон боловсролын ялгарал, давхраажилтад үзүүлэх урт хугацааны үр нөлөөг анхааралтай хянах шаардлагатай байна.

ШУДАРГА ТЭГШ БАЙДАЛ

ГОЛ ЧИГ ХАНДЛАГА

Боловсрол дахь шударга тэгш байдалд хяналт-шинжилгээ хийх нь тийм ч хялбар биш. 1990-ээд онд Амьжиргааны түвшний хэмжилтийн судалгаа (LSMS), Хүн ам зүй, эрүүл мэндийн судалгаа (DHS), Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа (HYTC/MICS) зэрэг стандартчилсан, олон зориулалттай өрхийн судалгаа өргөжсөнөөр хөгжлийн гол үр дүнгийн үзүүлэлтүүдийг хувь хүний шинжээр задлан гаргах боломж бүрдэж, эдгээр судалгаа нь Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөрийн "хэнийг ч орхигдуулахгүй байх" зарчмын хэрэгжилтийг хянахад тусална гэсэн өөдрөг хүлээлтийг бий болгосон. Эдгээр судалгаа нь боловсролын салбарт Боловсрол дахь тэгш бус байдлын дэлхийн мэдээллийн санг (WIDE) бий болгоход дэмжлэг үзүүлсэн бөгөөд уг мэдээллийн сан нь олон шинж тус бүрээр болон тэдгээр шинж давхацсан байдлаар илрэх тэгш бус байдлыг дүрслэн харуулдаг. Гэвч өнгөрсөн 25 жилийн туршлагаас харахад дэлхийн түвшний хяналт-шинжилгээ нь шударга тэгш байдлын чиг хандлагын талаар тодорхой ойлголт өгнө гэсэн анхны өөдрөг хүлээлт дэлхийн үзүүлэлтийн нийцтэй байдал, өгөгдлийн бэлэн байдал, гол шинжүүдийн харьцуулагдах боломж гэсэн гурван асуудлын улмаас саарсан байна. Дэлхийн түвшний хяналт-шинжилгээ чухал хэвээр байгаа боловч шударга тэгш байдлын хяналт-шинжилгээг үндэсний тогтолцоонд нэвтрүүлэн бэхжүүлэхтэй харьцуулахад түүнд хэт их ач холбогдол өгч ирсэн байж болох юм.


Боловсролын тэгш бус байдлын дэлхийн түвшний хяналт-шинжилгээ нь тэгш байдлын индексэд төвлөрдөг. Тэгш байдлын индекс нь боломж тааруу бүлгийн боловсролын үзүүлэлтийн утгыг давуу нөхцөлтэй бүлгийнхтэй харьцуулдаг. Энэ индексийн давуу тал нь

мэдээллийг нэг тоон утгаар хураангуйлан илэрхийлдэгт оршино. Гэвч сургуульд хамрагдаагүй хүүхдийн хувь, төгсөлтийн хувь зэрэг 0–100%-ийн хооронд хязгаарлагддаг ТХЗ 4-ийн ихэнх гол үзүүлэлтийн хувьд тогтолцооны шударга тэгш байдал заавал сайжирснаас бус, тухайн үзүүлэлтийн ерөнхий түвшин нэмэгдсэнээс шалтгаалан тэгш байдлын индекс сайжирсан мэт харагдах хандлагатай байдаг. Энэ хязгаарлалтыг үл харгалзан тэгш байдлын индексийг хоёр чиглэлээр үр ашигтай ашиглах боломжтой хэвээр байна. Нэгдүгээрт, үг индексийг тухайн үзүүлэлтийн түвшин ойролцоо улс орнуудын тэгш бус байдлыг харьцуулахад ашиглаж болно. Тухайлбал, бүрэн дунд боловсролын төгсөлтийн хувь 52% байсан үед хөрөнгө чинээний тэгш байдлын индекс Боливид 0.15 (2001), Эль Сальвадорт 0.29 (2012), Доминиканы Бүгд Найрамдах Улсад 0.38 (2008) байсан нь бүтцийн мэдэгдэхүйц ялгаа байгааг харуулж байна. Хоёрдугаарт, үг индексийг тухайн улс дахь тэгш бус байдал цаг хугацааны явцад дэлхийн дундаж чиг хандлагатай харьцуулахад хэрхэн өөрчлөгдөж байгааг хянахад ашиглаж болно. Тухайлбал, Боливийн хөрөнгө чинээний тэгш байдлын индекс 2001 онд дэлхийн дунджаас доогуур байсан боловч хурдацтай сайжирч, 2011 он гэхэд дэлхийн дунджаас давсан байна (Зураг 7).

ЗУРАГ 7:

Тэгш байдлын индексээс улс орнуудын боловсролын тэгш бус байдлын түвшин, чиг хандлагын талаар дүгнэлт хийх боломж нь нөхцөл байдлын шинжилгээгүйгээр хязгаарлагдмал

Өгөгдөл нь байгаа бүх улсын бүрэн дунд боловсролын төгсөлтийн хувийн хөрөнгө чинээний тэгш байдлын индекс, 2000–2024 он



Тэмдэглэл: Хөрөнгө чинээний тэгш байдлын индекс нь хамгийн ядуу 20%-ийн залуучуудын үзүүлэлтийн утгыг (энэ тохиолдолд бүрэн дунд боловсролын төгсөлтийн хувь) хамгийн чинээлэг 20%-ийн залуучуудын тухайн үзүүлэлтийн утгатай харьцуулсан харьцаа юм. Цэг бүр тухайн улсын тухайн оны нэг ажиглалтыг илэрхийлнэ. Улаан шугам нь регрессийн аргаар тооцсон төгсөлт болон хөрөнгө чинээний тэгш байдлын хоорондын хүлээгдэж буй хамаарлыг харуулна. Сүүдэрлэсэн хэсэг нь тэгш байдлын хүлээгдэж буй түвшний орчим дахь ±1 стандарт хазайлтыг илэрхийлнэ.

БХШ-ний статистик: https://bit.ly/GEM2026_Summary_fig7

Эх сурвалж: ЮНЕСКО-гийн Статистикийн хүрээлэнгийн мэдээллийн санд Боловсролын хяналт-шинжилгээний тайлангийн багийн хийсэн шинжилгээ

Өгөгдлийн бэлэн байдал хүссэн түвшнээс доогуур байгаа боловч үүний шалтгаан нь олон талтай. Хамгийн ядуу, зөрчил мөргөлдөөнд өртсөн орнууд, жижиг арлын хөгжиж буй орнуудаас бусад ихэнх улс боловсролын салбарт ашиглах боломжтой өрхийн судалгаатай хэдий ч боловсролын яамд заримдаа эдгээр судалгааг ашиглах боломжийг бүрэн үнэлдэггүй, эсвэл тэгш бус байдлыг харуулснаар үүсэж болзошгүй улс төрийн үр дагавраас болгоомжлон өгөгдлийг хуваалцдаггүй. Өгөгдлийн бэлэн байдал гэдэг нь улс орнууд үндэсний хэрэгцээнд зориулан өгөгдлөө тайлагнаж байгаа эсэхийг авч үзэхэд нэг асуудал, харин олон улсын тайлагналын хувьд авч үзэхэд өөр асуудал юм. Эдгээр статистик мэдээллийг дэлхийн түвшинд нэгтгэн боловсруулах нь илүү үр ашигтай. ЮНЕСКО-ийн Статистикийн хүрээлэн болон Дэлхийн боловсролын хяналт-шинжилгээний тайлангийн баг нийтэд нээлттэй микро өгөгдлийн багцуудыг ашиглан үүнийг хийдэг.

Суурь боловсролын төгсөлтийн хувийг жишээ болгон авч үзвэл, өгөгдлийн бэлэн байдал 2000-аад оны эхэн үеэс сүүл үе хүртэл сайжирсан боловч түүнээс хойш өөрчлөгдөөгүй байна. Сүүлийн үеийн байршлын ялгаатай байдлын өгөгдөл улс орнуудын гуравны хоёр орчмыг, хөрөнгө чинээгээр ялгаатай байдлын өгөгдөл улс орнуудын тал орчмыг хамарч байна. Улс орнууд өгөгдлийн багцаа хуваалцах тогтолцоотой үйл явц байхгүйгээс өгөгдлийн хамралтын цоорхой (coverage gap) гарсаар байна. Хамгийн сүүлд шинжилгээнд ашигласан судалгаа нь 2020 оноос өмнөх байсан 59 улсын 42 нь түүнээс хойш холбогдох судалгаа хийсэн боловч микро өгөгдөлд нэвтрэх боломжийг хязгаарлаж байна. АНУ-ын Засгийн газар 2025 онд Хүн ам зүй, эрүүл мэндийн судалгааны хөтөлбөрийг хаасан нь дэлхийн хэмжээнд өгөгдлийн бэлэн байдал ямар эмзэг болохыг, мөн улс орнууд судалгаагаа өөрсдөө тууштай хариуцан хэрэгжүүлэх шаардлагатайг тод харуулсан.

Олон шинжийг дэлхийн хэмжээнд харьцуулах боломж хязгаарлагдмал. Хот, хөдөөгийн нутаг дэвсгэрийн үндэсний тодорхойлолт улс орон бүрд ихээхэн ялгаатай бөгөөд хангалттай бодитой шалгуурт (тухайлбал, барилга байгууламж болон хүн амын нягтралд) үндэслэдэггүй. Хөрөнгө чинээний индекс нь тухайн цаг хугацаанд улс орны доторх өрхүүдийг хөрөнгө чинээгээр нь эрэмбэлдэг боловч улс орнуудын хооронд болон цаг хугацааны явцад харьцуулахад төдийлөн тохиромжтой биш. Үндэс угсаа, хэл, арьс өнгө, шашин шүтлэг зэрэг шинжийг ангилах категори нь тухайн нөхцөл байдлаас хамааран ялгаатай, нийгмийн хувьд бүрэлдэн тогтсон, улс төрийн хувьд эмзэг байдаг тул эдгээр шинжийн хувьд хязгаарлалт бүр ч их байдаг. Бүтцийн хувьд боломж таарүү байдалтай хамгийн нягт холбоотой шинжүүд нь дэлхийн хэмжээнд тогтвортой, харьцуулсан хяналт-шинжилгээ хийхэд хамгийн тохиромжгүй байдаг нь парадокс юм. Хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох, хяналт-шинжилгээ хийхэд ахиц гарч байгаа хэдий ч энэ чиглэлийн ахиц харьцангуй саяхных тул чиг хандлагыг тодорхойлоход хангалттай өгөгдөл хараахан бүрдээгүй байна.

Өнгөрсөн 25 жилд боловсролын ялгаа хэрхэн өөрчлөгдсөн бэ? 2000–2024 онд хамран сургалтаар хүйсийн тэгш байдалд хүрсэн улсын эзлэх хувь суурь боловсролын түвшинд 42%-аас 57%, бүрэн дунд боловсролын түвшинд 17%-аас 31% болж өссөн байна. Охидод боломж тааруу, өндөр түвшний ялгаатай улсын эзлэх хувь суурь боловсролын түвшинд 20%-аас 4%, бүрэн дунд боловсролын түвшинд 18%-аас 5% болж буурчээ. Байршлын ялгаа мөн багассан байна. Хамран сургалтаар хот, хөдөөгийн хооронд тэгш байдалд хүрсэн улсын эзлэх хувь бага боловсролын түвшинд 47%-аас 67%, суурь боловсролын түвшинд 24%-аас 45%, бүрэн дунд боловсролын түвшинд 5%-аас 19% болж өсжээ. Гэсэн хэдий ч 2020-иод оны эхээр улс орнуудын 43%-д бүрэн дунд боловсролын түвшинд туйлын их ялгаа байсаар байсан бөгөөд хотод хамрагдсан 10 залуу тутамд хөдөөд 8 хүрэхгүй залуу хамрагдаж байв. Хөрөнгө чинээний ялгаа хамгийн их хэвээр байна. 2020-иод оны эхээр улс орнуудын 83%-д сургуулийн өмнөх боловсролын түвшинд хөрөнгө чинээний туйлын их ялгаа байсан бол бага боловсролын түвшинд 21%, суурь боловсролын түвшинд 29%, бүрэн дунд боловсролын түвшинд 55% байжээ.

УЛС ОРНЫ КЕЙС СУДАЛГАА

Улс орны кейс судалгаа нь 2000 оноос хойших дэлхий дахины олон янзын туршлагыг харуулж байна. **Армени** түсгай сургуульд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эзлэх хувь 2015 онд 38% байсныг 2023 онд ердөө 7% болгон бууруулжээ. 2019 онд бодлогын чиглэл өөрчлөгдөж, түсгай сургуулиудын ихэнхийг дэмжлэгийн төв болгон өөрчилсөн боловч ердийн сургуулиудын бэлтгэл хангалтгүй хэвээр, барилга байгууламжийн хүртээмжгүй байдал, нийгмийн сөрөг хандлага зэрэг саад бэрхшээлийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй олон хүүхэд бүртгэлээр сургуульд хамрагдсан боловч бодит байдал дээр жинхэнэ утгаараа тэгш хамрагдаж чадахгүй байна. **Боливийн Олон Үндэстний Улс** хөрөнгө чинээний ялгааг эрс бууруулжээ. Хамгийн ядуу тавны нэгд багтах өрхийн өсвөр үеийнхний суурь боловсролын төгсөлтийн хувь 2000 онд 31% байсан бол 2021 онд 94% болж өссөн байна. Өрийг хөнгөлж, байгалийн нөөцийн монопол салбаруудыг төрийн мэдэлд шилжүүлснээр боловсролын санхүүжилтийн төсвийн боломж нэмэгджээ. Сургуулийн хоол, тэтгэлэг, нөхцөлт мөнгөн шилжүүлэг зэрэг нийгмийн тэгш оролцоог хангах бодлогоор нөөцийг дахин хуваарилсан байна.

Этиоп бага боловсролын хүртээмжийг өргөжүүлж, 2000 оноос хойш хот, хөдөөгийн төгсөлтийн хувийн зөрүүг 24 хувийн пунктээр бууруулсан боловч 2022 онд уг зөрүү 34 хувийн пункт буюу ихээхэн өндөр хэвээр байв. 1990-ээд онд эхлүүлж, 2000-аад оны эхээр эрчимжүүлсэн төвлөрлийг сааруулах шинэчлэлийн хүрээнд дүүргүүдэд илүү их нөөц, шийдвэр гаргах эрх мэдэл шилжүүлснээр орон нутгийн хэрэгцээнд илүү нийцсэн засаглалыг хэрэгжүүлэх боломж бүрджээ. Дүүргүүд сургууль барих ажлыг эрчимжүүлж, багшийг ажилд авахыг нэмэгдүүлэн, багшийн хуваарилалтыг сайжруулснаар шударга тэгш байдлын хувьд ахиц гарсан байна. Гэвч сүүлийн зургаан жилд гарсан зөрчил мөргөлдөөн, хямралын улмаас энэхүү ахиц эрсдэлд ороод байна. **Монгол Улсад** 1990-ээд оны эдийн засгийн шилжилтээс үүдэлтэй санхүүгийн агшилт дууссаны дараа төгсөлтийн хувь эргэн сэргэсэн байна. Түүнчлэн суурь болон бүрэн дунд боловсролын түвшинд хөвгүүдийн төгсөлтийн хувь охидынхтой бараг тэнцжээ. Хөдөөгөөс хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн хөвгүүдийн боловсролд ялангуяа эерэг нөлөө үзүүлсэн бөгөөд шилжин суурьшсан олон өрх боловсролыг шилжих болсон нэг шалтгаан гэж дурдсан байна. Мөн 9 дүгээр ангиас хойш мөнгөн тэтгэмж олгодог техникийн болон мэргэжлийн боловсролын чиглэлүүд хөвгүүдийг татжээ.

Балбад тууштай хэрэгжүүлсэн шинэчлэлийн үр дүнд охид хөвгүүдтэй хурдацтай зэрэгцэж, зарим үзүүлэлтээр тэднийг давсан байна. 1990-ээд оноос 2010-аад оны хооронд улсын дунд сургуулиудад чиглэсэн хөрөнгө оруулалт, зардлыг бууруулах арга хэмжээ, тэтгэлэг нь олон жилийн туршид байсан ялгааг арилгаж, суурь болон бүрэн дунд боловсролын төгсөлтөөр тэгш байдалд хүрэхэд нөлөөлжээ. **Филиппинд** Муслим Минданао дахь Бангсаморогийн Өөртөө Засах Бүс нутаг зөрчил мөргөлдөөн, ядуурлын улмаас олон жилийн турш улсын бусад хэсгээс хоцорч ирсэн байна. Эдийн засгийн өсөлт, ядуурлыг бууруулах зорилтот бодлого, 2013 онд заавал эзэмших боловсролын хугацааг сунгасан явдал, хөдөлмөрийн зах зээлд шилжих замналтай үялдуулсан дунд боловсролын шинэ чиглэлүүд нь уг ялгааг бууруулахад хувь нэмэр оруулжээ. **Бүгд Найрамдах Молдова Улс** тусгай боловсролын тогтолцоогоо өөрчлөн шинэчилж, ердийн сургуульд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эзлэх хувь 2010/11 онд ердөө 29% байснаас 2023/24 онд 95% болж өссөн байна. Европын Холбоонд элсэх эрмэлзэл нь үүнд тодорхой хэмжээгээр түлхэц болж, түс улс тэгш хамруулах боловсролыг дэмжсэн хууль тогтоомж, нэгдсэн дэмжлэгийн үйлчилгээ, дүүргүүдэд тусгайлан зориулсан санхүүжилтийг нэвтрүүлсний зэрэгцээ тэгш хамруулах боловсролыг хэрэгжүүлэхэд багш нарт үзүүлэх дэмжлэг мөн нэмэгджээ.

БОДЛОГЫН ШИНЖИЛГЭЭ

Санхүүжилтийн бодлого нь боловсролын шударга тэгш байдлыг дэмжих боломжтой. Боловсролын шударга тэгш байдлыг сайжруулахын тулд улс орнууд ялгарал, давхраажилтыг хязгаарлах, нийтлэг стандартыг дэмжих, зорилтот сурган хүмүүжүүлэх дэмжлэг үзүүлэх, бага насны хүүхдийн үйлчилгээг өргөжүүлэх, санхүүжилтийн механизмыг ашиглах боломжтой. Боловсролд зарцуулах төрийн зардлын хэмжээ их байх нь илүү боломж тааруу хүн амын бүлгүүдэд ашигтайгаар нөөцийг дахин хуваарилах хандлагатай байдаг. Гэхдээ төрийн нөөцийг хэрхэн зарцуулж байгаа, тэр дундаа боломж тааруу сургууль, хүн амын бүлгүүдэд ядуурал, газар зүйн байршил, гадуурхалд хүргэдэг бусад хүчин зүйлтэй холбоотой бэрхшээлийг даван туулахад нь туслах зорилгоор улс орнууд нөөцийг хэр хэмжээнд зориудаар дахин хуваарилж байгаа нь чухал юм. ТХЗ-ын 4.5.3 дугаар үзүүлэлтэд хяналт-шинжилгээ хийх өмнөх оролдлогод тулгуурлан энэхүү тайланд улс орнууд орон нутгийн засаг захиргаанд; сургуульд; суралцагчид болон гэр бүлд (боловсролын төсвөөс санхүүжүүлдэг); суралцагчид болон гэр бүлд (нийгмийн хамгааллын төсвөөс санхүүжүүлдэг); мөн суралцагчдад сургуулийн хоол хэлбэрээр олгох шилжүүлэг гэсэн таван төрлийн шилжүүлгийг хэрхэн ашиглаж байгааг тоймлон харуулжээ.

Орон нутгийн засаг захиргаанд олгох шилжүүлэг. Нийт улс орны 58% нь боловсролын санхүүжилтийг орон нутгийн засаг захиргаанд шилжүүлдэг боловч тэдгээрийн ердөө 47% нь санхүүжилт хуваарилах томьёондоо шударга тэгш байдлыг тодорхой тусгадаг. Ийм шилжүүлгийн үндсэн таван загвар байна. Нэгдүгээрт, төв засгийн газар тэгш бус байдлыг харгалзан тохируулга хийлгүйгээр санхүүжилт шилжүүлдэг (жишээлбэл, Бангладеш, Йордан, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс). Хоёрдугаарт, төв засгийн газар нэг сувгаар цалин олгож, нөгөө сувгаар хөтөлбөрүүдийг санхүүжүүлдэг хос сувгийн тогтолцоо нь тэгш бус байдлыг бууруулах зорилгыг заавал агуулдаггүй (жишээлбэл, Алжир, Монгол). Гуравдугаарт, боломж тааруу бүс нутагт нэмэлт жин тооцдоггүй, нэг суралцагчид ногдох санхүүжилтийг ашигладаг (жишээлбэл, Кени). Дөрөвдүгээрт, шударга тэгш байдлыг харгалзсан тохируулга бүхий нэг суралцагчид ногдох санхүүжилтийг ашигладаг (жишээлбэл, Бразил, Колумб). Тавдугаарт, үндэсний эсвэл холбооны түвшний эрх бүхий байгууллагууд ялгааг бууруулах зорилгоор нөөцийг дахин хуваарилдаг (жишээлбэл, Хятад). Шударга тэгш байдлыг хангахад чиглэсэн шилжүүлэг Төв болон Өмнөд Ази, Европ, Хойд Америкт хамгийн түгээмэл, харин Хойд Африк, Баруун Азид хамгийн бага түгээмэл байна.

Гэвч иймшилжүүлэг нь бүс нутгийн тэгш бус байдалд төдийлөн нөлөө үзүүлдэггүй. Аргентинд мужуудын өөрийн орлого, холбооны төсвийн тэгшитгэх шилжүүлэг, бага хэмжээний хөтөлбөрийн зориулалттай санхүүжилт нь нэг суралцагчид ногдох зардлын зөрүүг бууруулдаг боловч бүрэн арилгадаггүй. Этиопт хүн ам, ядуурал, гүйцэтгэлээр жигнэсэн, орон нутгийн түвшинд шилжүүлсэн багц санхүүжилтийн тогтолцоо нь боловсрол, эрүүл мэндийн үр дүнг сайжруулахад хувь нэмэр оруулсан боловч нэгэн үнэлгээгээр эерэг үр нөлөө нь нөөц нэмэгдсэнээс илүүтэй орон нутгийн түвшний эрх мэдэл нэмэгдсэнтэй холбоотой байх магадлалтай гэж үзжээ. Герман, Япон, Бүгд Найрамдах Солонгос Улс зэрэг өндөр орлоготой оронд олон жилийн турш хэрэгжиж ирсэн төсвийн тэгшитгэлийн тогтолцоо нь хэрэгцээ болон төсвийн чадавхад үндэслэн нөөцийг орон нутгийн засаг захиргаанд дахин хуваарилж, боловсролын үйлчилгээг илүү жигд хүргэхэд дэмжлэг үзүүлдэг боловч нутаг дэвсгэрийн ялгааг бүрэн арилгадаггүй.

Сургуульд олгох шилжүүлэг. Дэлхийн хэмжээнд улс орнуудын 76% нь боломж тааруу сургуулиудад илүү нөөц ногдохоор дахин хуваарилдаг. Сургуульд олгох санхүүжилт нь нэг суралцагчид ногдох тогтсон хэмжээний санхүүжилт, өдөр тутмын зардлын санхүүжилт, эсвэл тодорхой төсөл, суралцагчдад зориулсан тусгай сангийн хэлбэртэй байж болно. Шилжүүлгийн механизм тогтвортой, энгийн, тодорхой байхын зэрэгцээ чадавхтай удирдлага, сургалт, хариуцлагын тогтолцоогоор дэмжигдэх нь амжилтын урьдчилсан нөхцөл боловч иймшилжүүлэг нь ихэвчлэн богино хугацаанд хэрэгждэг бөгөөд санхүүжилтийн хэмжээ бага байдаг. Тухайлбал, иймбодлого, хөтөлбөртэй улс орнуудын дор хаяж тал хувь нь боловсролын нийт зардлынхаа 0.5%-аас бага хувийг тэдгээрт хуваарилжээ.

Олон жилийн турш хэрэгжиж ирсэн зарим тогтолцооны жишээ болох Бенин, Болгар, Фижи, Индонез, Папуа Шинэ Гвинейд сургуульд санхүүжилт хуваарилах томьёог дахин хуваарилалтын үндсэн хэрэгсэл болгон ашигладаг. Индонезийн боловсролын зардлын ихээхэн хувийг эзэлдэг BOS санхүүжилтээр сургуулиудад суралцагчийн тоонд үндэслэн тооцсон санхүүжилт олгодог боловч орон нутгийн засаг захиргааны дэмжлэг жигд бус, зэрэгцээ санхүүжилтийн механизмуудын уялдаа хангалтгүй, сургуулийн хороодод ойлгомжтой байдал хангалтгүй байгаа нь уг санхүүжилтийн үр нөлөөг хязгаарлаж байна.

Бага, дунд орлоготой олон оронд донорын санхүүжилттэй, сургуульд санхүүжилт олгох тогтолцоо богино хугацаанд ахиц авчирсан боловч гадаад санхүүжилтийг улсын төсөвт тусгаагүй тохиолдолд уг санхүүжилт дуусмагц энэхүү ахиц ихэвчлэн саарч байв. Камбожид хөтөлбөрүүд дууссаны дараа эдгээр санхүүжилт зогссон байна. Гамби болон Зимбабве доноруудын санаачилсан санхүүжилтийг өөрсдөө хариуцан хэрэгжүүлэх болсон ч санхүүжилт олголт удаашрах, сургуулийн түвшний оролцоо сул байх, санхүүжилтийн хэмжээ хангалтгүй байх зэрэг асуудал хоёр улсад тулгарсаар байна. Зимбабвед боломж тааруу суралцагчдад зориулсан тусдаа санхүүжилтээс ялгаатай нь сургуулийг сайжруулах үндсэн санхүүжилт одоо ч дотоодын эх үүсвэрээс санхүүждэггүй.

Суралцагчид болон өрхөд олгох шилжүүлэг (боловсролын яамны төсвөөс). Боловсролын яамдын 62 орчим хувь нь суралцагчдад мөнгөн болон мөнгөн бус дэмжлэгийн аль нэг хэлбэрийг үзүүлдэг. Суралцагчид боловсролын нэг түвшнээс нөгөөд шилжих үед сургууль завсардах эрсдэл хамгийн өндөр байдаг тул энэ үед тэтгэлэг, зорилтот санхүүжилт хамгийн чухал ач холбогдолтой. Үр нөлөө үзүүлэхийн тулд эдгээр дэмжлэг нь мөн хангалттай хэмжээтэй, үр дүнтэй хэрэгждэг, зорилтот бүлэгтээ оновчтой чиглэсэн байх шаардлагатай. Балбад далит суралцагчид, охид, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад олгодог маш бага хэмжээний тэтгэмж олон суралцагчийг хамардаг боловч сургуульд суралцах үндсэн зардлыг нөхөхөд хүрэлцдэггүй тул үр нөлөө нь гол төлөв бэлгэдлийн шинжтэй байна. Мексикт хот суурин газарт дунд боловсролд суралцаж буй ядуу суралцагчдад зориулсан PROBEMS тэтгэлэг нь нийт суралцагчдын бараг дөрөвний нэгийг хамарсан боловч сарын тэтгэлгийн хэмжээ нэн ядуурлын шугамаас ялимгүй доогуур байсан бөгөөд анх зорьсон түвшний ядуу суралцагчдыг хамруулж чадаагүй тул төгсөгчдийн эзлэх хувийг нэмэгдүүлээгүй байна.

Суралцагчдад дэмжлэг үзүүлэх олон хөтөлбөрийг боломж тааруу суралцагчдыг хамруулахаар боловсруулсан байдаг боловч бодит байдал дээр зорилтот суралцагчдад хэр сайн хүрч байгааг тогтоохоод хүндрэлтэй. НҮБ-ын Хүүхдийн сангийн Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны (MICS) нийгмийн хамгааллын модульд сургуульд суралцаж буй хүүхдүүдийн гэр бүлээс сургалтын төлбөрийн дэмжлэг эсвэл сургуультай холбоотой бусад тусламж авч байгаа эсэхийг асуух замаар энэ талаар тодорхой хэмжээнд мэдээлэл өгдөг. 44 улсад хамрагдалтын медиан бага (сургуулийн насны хүн амын 5 орчим хувь) байна. Хамрагдалт багатай зарим хөтөлбөр, тухайлбал, Мадагаскарын хичээлийн хэрэгслийн багц олгох хөтөлбөр хамгийн ядуу өрхүүдэд ихээхэн түлхүү чиглэдэг бол Төв Африкийн Бүгд Найрамдах Улс, Чад зэрэг орны бусад хөтөлбөр баян, ядуу өрхүүдэд бараг жигд хуваарилагддаг. Хамрагдалт өндөртэй тогтолцоонуудаас Алжир, Бенин дэмжлэгээ хамгийн ядуу өрхүүдэд түлхүү чиглүүлдэг бол Ямайка, Тайландад өргөн хүрээтэй эсвэл бараг бүх нийтийг хамарсан тогтолцооны үр шимийг чинээлэг өрхүүд үлэмж хэмжээгээр хүртдэг.

Сургуулийн хоолны хөтөлбөр. Сургуулийн хоол нь боловсрол, хоол тэжээл, нийгмийн хамгааллыг уялдуулсан,

хамгийн өргөн тархсан, улс төрийн хувьд тогтвортой шударга тэгш байдлыг хангах механизмуудын нэг юм. 25 улсад хийсэн судалгаагаар сургуулийн хоолны хөтөлбөр хамран сургалтыг 3 орчим хувиар нэмэгдүүлдэг болохыг тогтоожээ. Бага, дунд орлоготой орнуудыг хамарсан тойм судалгаагаар сургуулийн хоолонд хөрөнгө оруулсан 100 ам.доллар тутамд боловсрол эзэмшсэн хугацаа хагас жил хүртэл нэмэгдсэн байна. 2025 оны байдлаар улс орнуудын 84 орчим хувь нь сургуулийн хоолны ямар нэг хэлбэрийн хөтөлбөртэй бөгөөд хамрагдалт Латин Америк ба Карибын тэнгисийн бүс нутагт (100%), Зүүн болон Зүүн Өмнөд Ази, Сахарын цөлөөс өмнөх Африкт (хоёр бүс нутагт хоёуланд нь 90%-аас дээш) хамгийн өндөр байна. Дунджаар бага боловсролын суралцагчдын 29% нь үнэ төлбөргүй эсвэл хөнгөлөлттэй хоолоор хангагддаг.

2020 оноос хойш Ангол, Мавритан, Нидерланд, Шинэ Зеланд, Сьерра-Леоне, Узбекистан зэрэг улс орнууд үндэсний хөтөлбөрүүдийг шинээр хэрэгжүүлж эсвэл өргөжүүлсэн бөгөөд эдгээр нь ихэвчлэн бага боловсролын ангиудыг бүх нийтээр хамруулах, эсвэл шударга тэгш байдлыг хангах зорилгоор дэмжлэг шаардлагатай бүс нутаг, сургуулиудыг зорилтот байдлаар хамруулах хэлбэртэй байна. БНХАУ-ын хөдөөгийн хоол тэжээлийн хөтөлбөр, АНУ-ын Сургуулийн өдрийн болон өглөөний хоолны үндэсний хөтөлбөрүүд зэрэг олон жилийн турш хэрэгжиж ирсэн хөтөлбөрүүд хамрах хүрээгээ өргөжүүлсээр байгаа бөгөөд ядуурал өндөртэй бүс нутагт бүх нийтийг хамарсан, үнэ төлбөргүй загварыг нэвтрүүлж байна. Гэвч бага болон дундаас доогуур орлоготой олон улс орон донорын дэмжлэг буурахын хэрээр хөтөлбөрүүдээ тогтвортой үргэлжлүүлэхэд хүндрэлтэй тулгарч байгааг Мали, Нигери, Йеменд саяхан үүссэн санхүүжилтийн хямрал тодорхой харуулж байна. Энэхүү санхүүжилтийн дутагдлыг нөхөх зорилгоор тодорхой зориулалтад оноосон татвар (Боливи, Гватемал) эсвэл санхүүжилтийн хосолсон хэрэгсэл (Бүгд Найрамдах Нэгдсэн Танзани Улс) ашигласан санхүүжилтийн зарим шинэлэг арга хэлбэр бий болж байна.

Суралцагчид болон өрхөд олгох шилжүүлэг (нийгмийн хамгааллын яамдаас). Улс орнуудын 73 орчим хувь нь хүүхдийн тэтгэмжээс зорилтот мөнгөн шилжүүлэг хүртэлх хэлбэрээр суралцагчид болон гэр бүлд дэмжлэг үзүүлэх нийгмийн бодлого хэрэгжүүлдэг бөгөөд ийм бодлого бага орлоготой орнуудын гуравны нэгээс ялимгүй илүүд нь хэрэгждэг бол Европ, Хойд Америкт бараг бүх улс хэрэгжүүлдэг. Нөхцөлт мөнгөн шилжүүлгийн үнэлгээнүүдээс баттай нотолгоо бүрдсэн бөгөөд мета-шинжилгээнүүдээс үзэхэд уг шилжүүлгийг хүртдэг хүүхдүүд хүртдэггүй хүүхдүүдтэй харьцуулахад боловсролд хамрагдах магадлал гуравны нэгээр илүү, харин охид болон боловсролын гол шилжилтийн үе дэх хүүхдүүдэд үзүүлэх нөлөө нь илүү их байна. Латин Америк энэ чиглэлийн хөтөлбөрүүд эрчимтэй хөгжсөн бүс нутаг бөгөөд ялангуяа Бразил (Bolsa Família), Колумб (Familias en Acción), Мексикт (Progresa, Oportunidades, Prospera) өргөн хэрэгжиж ирсэн боловч сүүлийн хоёр хөтөлбөрийг саяхан зогсоосон байна. Өмнөд Азид, жишээлбэл Бангладеш болон Пакистаны Пунжаб мужийн хөтөлбөрүүд охидын боловсролд түлхүү чиглэж ирсэн. Индонезийн мөнгөн шилжүүлэг, Хойд Македоны дунд боловсролын сургуулийн тэтгэлэг, Филиппиний Pantawid хөтөлбөр нь өсвөр үеийнхний хамран сургалт эсвэл төгсөлтийг түс түс 7, 12, 8 хувийн пунктээр нэмэгдүүлжээ. Алжирын хичээлийн хэрэгслийн тэтгэмж, Мароккогийн Tayssir хөтөлбөрөөс харахад боловсролтой уялдсан тэтгэмж харьцангуй бага хэмжээтэй байсан ч үндэсний хэмжээнд өргөжүүлэн хэрэгжүүлснээр сая сая хүнийг хамруулж, төгсөлтийг нэмэгдүүлэх боломжтой боловч үүний зэрэгцээ ангийн дүүргэлт хэт өндөр болж, анги улиран суралцах явдлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй.

Нөхцөлгүй мөнгөн шилжүүлэг нь бага болон дунд орлоготой орнуудад илүү түгээмэл бөгөөд өндөр орлоготой орнуудын хүүхдийн бүх нийтийн тэтгэмжийн нэгэн адил хамран сургалтыг нэмэгдүүлэх хандлагатай байдаг ч үзүүлэх нөлөө нь ерөнхийдөө нөхцөлт хөтөлбөрүүдийнхээс бага байдаг. Буркина Фасо, Эквадор, Малавид мөнгөн шилжүүлэг боловсролын оролцоог нэмэгдүүлсэн байна. Туркт Сирийн дүрвэгсдэд зориулсан Онцгой байдлын үеийн нийгмийн хамгааллын сүлжээ хөтөлбөр сургуульд хамрагдаагүй хүүхдийн эзлэх хувь болон хүүхдийн хөдөлмөрийг эрс бууруулжээ. Ерөнхийд нь авч үзвэл, мөнгөн шилжүүлгийн хэмжээ, тогтмол олгох байдал, зорилтот бүлгийг тодорхойлох арга, дэмжлэг авахад тавих нөхцөл зэрэг хөтөлбөрийн загварын шинжүүд нь боловсролд үзүүлэх үр өгөөжийг хамгийн их байлгах, хүсээгүй сөрөг үр дагавраас зайлсхийхэд шийдвэрлэх ач холбогдолтойг баримт нотолгоо харуулж байна.


Шударга тэгш байдлын асуудлыг харгалзан үзэх байдал нэмэгдэж байгаа ч нийтлэг болоогүй байна. Санхүүжилтийг шударга тэгш байдлыг хангахад чиглүүлэх хандлага 2000 оноос хойш хурдацтай түгсэн боловч таван механизмд харилцан адилгүй хэлбэрээр хэрэгжиж байна. Орон нутгийн засаг захиргаанд олгох тэгшитгэх шилжүүлэг харьцангуй бага түгээмэл хэвээр байгаа боловч хэрэглээ нь нэмэгдсэн нь 2000-аад оны сүүлээр хэрэгжсэн төвлөрлийг сааруулах шинэчлэлтэй холбоотой. Сургуульд олгох шилжүүлэг нь хамгийн хурдацтай өргөжиж буй хэрэгсэл бөгөөд Өмнөд Африкийн квинтилд суурилсан санхүүжилт, Нидерландын нэг суралцагчид ногдох жинлэсэн санхүүжилтийн томьёо зэрэг олон жилийн турш хэрэгжиж ирсэн дахин хуваарилалтын үндсэн тогтолцооноос эхлээд Бахрейн, Бенин, Кюрасао, Жибути зэрэг оронд хөдөөгийн сургууль эсвэл хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад чиглэсэн сүүлийн үеийн, илүү хязгаарлагдмал хүрээтэй

хөтөлбөр хүртэлх харилцан адилгүй олон төрлийн санхүүжилтийг хамардаг. Суралцагчид болон гэр бүлд олгох шилжүүлэг мөн 2000-аад оноос хойш эрчимтэй өргөжсөн бөгөөд Ирландын Сургуулийн тээврийн хөтөлбөр, Кенийн Elimu тэтгэлэг зэрэг зарим нь олон жилийн турш өргөн хүрээнд хэрэгжиж байна. Сургуулийн хоолны хөтөлбөр нь энэ бүх хугацаанд хамгийн өргөн тархсан механизм байсаар ирсэн бөгөөд аль хэдийн өндөр байсан хамрагдалтын түвшнээс цааш өргөжихийн зэрэгцээ донорын санхүүжилттэй төслийн хэлбэрээс үндэсний төсвөөр тогтвортой санхүүжүүлэх хэлбэрт улам бүр шилжиж байна. Боловсролтой уялдсан нийгмийн хамгааллын шилжүүлэг мөн өргөжсөн байна.

ЗУРАГ 8:

Боловсролын шударга тэгш байдлыг хангахад чиглэсэн санхүүжилтийн механизмууд дэлхий даяар түгээмэл болсон

Боловсролын шударга тэгш байдлыг хангахад чиглэсэн хөтөлбөртэй улс орны тоо, санхүүжилтийн механизмаар, 2000–2025 он



БХШ-ний статистик: https://bit.ly/GEM2026_Summary_fig8

Эх сурвалж: PEER цахим хуудсанд зориулсан Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайлангийн багийн хийсэн бодлого, хөтөлбөрийн шинжилгээ.


Шинэ индекс нь боловсролын тогтолцоо шударга тэгш байдлыг хангахад хэр зэрэг чиглэж байгааг харуулж байна. Энэхүү тайланд таван механизмын хамрагдалт (тухайн хөтөлбөрт хамаарах хүн амын хамрагдсан хувь), зарцуулалтын хэмжээ (хөтөлбөрийн зардлын боловсролын зардал эсвэл төрийн нийт зардалд эзлэх хувь)-ний мэдээллийг ашиглан үндэсний санхүүжилтийн тогтолцоо шударга тэгш байдлыг хангахад хэр зэрэг чиглэж байгааг илэрхийлэх шинэ индекс боловсруулсан. Механизм тус бүрийн хүрээнд улс орнуудын гол бодлого, хөтөлбөрийг эмпирик өгөгдөлд үндэслэн тогтоосон босго утгаар бага, дунд, өндөр гэж ангилан гурван түвшнээр үнэлжээ. Механизм тус бүрийг 0 (холбогдох хөтөлбөргүй эсвэл шударга тэгш байдлыг хангахад чиглээгүй хөтөлбөртэй)-ээс 6 (хамрагдалт болон зарцуулалтын хэмжээний аль алиных нь хувьд шударга тэгш байдлыг хангахад өндөр түвшинд чиглэсэн) хүртэл оноо өгч, өөр өөр хэрэгслийн харьцангуй ач холбогдлын талаар хэт хүчтэй таамаглал дэвшүүлэхээс зайлсхийхийн тулд механизм бүрд ижил жин өгч, бүх механизмыг нийлүүлсэн нийт боломжит оноог 0-30 байхаар тогтоосон.

Улс орнуудын 20 орчим хувь нь шударга тэгш байдлыг хангахад чиглэсэн байдлаараа “эхлэлийн”, 33% нь “хөгжиж буй”, 39% нь “төлөвшсөн”, ердөө 8% нь шударга тэгш байдлыг харгалзан үзэх зарчмыг санхүүжилтийн механизмуудад системтэйгээр тусгасан “дэвшилтэт” түвшинд ангилагдсан (Зураг 9). Шударга тэгш байдлыг хангахад чиглэсэн байдал нь төлөвшсөн эсвэл дэвшилтэт түвшинд байгаа улс орнуудын эзлэх хувь бага орлоготой орнуудад 12% байдаг бол өндөр орлоготой орнуудад 58% байна. Медиан оноо бага орлоготой орнуудад 6, Европ болон Хойд Америкт 14 байгаа бол Латин Америк мөн өндөр оноотой байна. Энэхүү индекс нь бодлогын болон зорилтот бүлэгт чиглүүлэх үр нөлөөг хэмжихгүй, харин төрийн санхүүжилтийн тогтолцооны хүрээнд бодлогоор зорьж буй чиглэл, санхүүгийн хүчин чармайлтыг илэрхийлнэ.

ЗУРАГ 9:

Арван улс тутмын нэг хүрэхгүйд нь санхүүжилтийн механизмууд шударга тэгш байдлыг хангахад хүчтэй чиглэсэн байна

Үндэсний санхүүжилтийн механизмын шударга тэгш байдлыг хангахад чиглэсэн байдлын индексийн утгын тархалт, улс орнуудын орлогын бүлгээр, 2025 он



БХШ-ний статистик: https://bit.ly/GEM2026_Summary_fig9

Эх сурвалж. Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайлангийн багийн тооцоо

ЗӨВЛӨМЖ

Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр болон ТХЗ-уудыг бүх нийтэд хамааралтай, харилцан хамааралтай, хэнийг ч орхигдуулахгүй байх зарчимд төвлөрсөн байхаар боловсруулсан. Энэхүү хандлага нь дэлхий дахины боловсролын сорилт бэрхшээлийг авч үзэх нийтлэг өнцгийг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулсан. Мөн хөгжлийн бусад үр дүнд нөлөөлөхөд боловсролын гүйцэтгэх үүргийг тодотгож, шударга тэгш байдлыг бодлогын хэлэлцүүлгийн төвд авчирсан.

Дэлхий нийт 2030 оны зорилтот хугацаанд улам ойртож, ТХЗ-уудын үндэс суурь болсон дэлхий нийтийн сорилт бэрхшээлийг шийдвэрлэх олон талт хамтын ажиллагааны арга барил ноцтой шалгуурт орж буй энэ үед Боловсролын дэлхийн хяналт-шинжилгээний тайлан нь боловсролын ТХЗ 4-ийг хэрэгжүүлэхэд гаргасан амжилт болон түүнээс авах сургамжийг үнэлэх зорилгоор 2030 он хүртэлх тоолол цувралыг гаргаж байна. Тус тайланд ТХЗ 4-ийн хамрах хүрээг боловсролын хүртээмж ба шударга тэгш байдал, чанар ба суралцахуй, боловсролын нийцэл гэсэн гурван хэсэгт хуваан авч үзжээ. Тус тайлан гурван асуулт тавьж байна. Нэгдүгээрт, ижил төстэй түвшнээс эхэлсэн улс орнуудаас эдгээр өргөн хүрээний чиглэлээр аль нь бусдаасаа хавьгүй хурдацтай ахиц гаргасан бэ? Хоёрдугаарт, ахиц дэвшил эсвэл зогсонги байдлаар нь онцлон сонгосон улс орнуудын хувьд ажиглагдсан чиг хандлагыг тайлбарлах гол шалтгаанууд юу вэ, мөн эдгээр тайлбар нь голлох үүрэг гүйцэтгэсэн гэж судалгаагаар тодорхойлсон хүчин зүйлстэй хэр нийцэж байна вэ? Гуравдугаарт, статистикийн шинжилгээ, улс орны кейс судалгаа, бодлогын шинжилгээнээс боловсролын ирээдүйн олон улсын хөтөлбөрийн талаар ямар дүгнэлт хийж болох вэ?

Энэхүү цувралын эхний тайланд эдгээр асуултыг боловсролын хүртээмж ба шударга тэгш байдалтай холбон авч үзсэн. Хүртээмжийн тухайд, 2030 он гэхэд бага боловсролыг бүх нийтээр төгсөх зорилт ч биелэхгүйг харгалзан үзвэл дунд боловсролыг бүх нийтээр төгсөх зорилго бодит байдлаас хэт тасархай байсан нь тодорхой байна. Шударга тэгш байдлын тухайд, хүйсийн ялгаатай байдлыг арилгах, боловсролын бүх түвшинд тэгш хүртээмжийг хангах зорилтууд мөн адил хэт өндөр байсан. Гэхдээ эдгээр бэлгэдлийн шинжтэй зорилтыг биелүүлэхэд дэлхий нийт хэр ойртсоноор нь л хөтөлбөрийн амжилтыг дүгнэх нь буруу гэж энэхүү тайланд үзэж байна. Харин улс орнууд боловсролын хөгжлийнхөө түвшин болон нөхцөл байдалд тохирсон арга зам, тухайлбал зорилтууд тогтоох, тэдгээрт хяналт-шинжилгээ хийх, олж авсан мэдээллийг ашиглан бодлогын оновчтой хослолыг сонгон хэрэгжүүлэх, тохируулан өөрчлөх зэргийг ашиглан саад бэрхшээлийг шийдвэрлэхийг хичээсэн эсэх нь гол асуудал юм. Улс орнууд ийнхүү ажиллаж ирснийг харуулах нотолгоо бий.

Дараах зөвлөмжүүд нь ахицад хяналт-шинжилгээ хийх болон боловсролын хүртээмж, шударга тэгш байдлыг сайжруулах бодлого боловсруулахтай холбоотой, дэлхийн болон үндэсний түвшний бодлогын хэлэлцүүлгийн үйл явцад хангалттай анхаарал хандуулагдахгүй байж болзошгүй сонгон авсан зарим асуудалд төвлөрч байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭГ ХЭРХЭН САЙЖРУУЛАХ ВЭ?

а. Улс орнууд дэлхийн хяналт-шинжилгээний хүрээнд үндэсний зорилт тогтоох шаардлагатай.

Дэлхийн хөтөлбөрүүд нь нэн ядуурлыг арилгах, дэлхийн температурын өсөлтийг 1.5°-аас доош барих зэрэг нийтлэг зорилгод хүрэхийн тулд нийтлэг ойлголт, хэллэг ашиглан олон улсын хамтын нийгэмлэгийг хэр үр дүнтэй дайчлан оролцуулж чадсанаараа тодорхойлогдох хандлагатай байдаг. Гэвч бодит ахиц улс орны түвшинд гардаг бөгөөд үндэсний түвшний шийдвэр гаргагчид ямар зорилт дэвшүүлснээ олон нийтэд мэдэгдэж байгаа, тэдгээрт хүрэхийн тулд ямар нөөц хуваарилж байгаа, мөн эдгээр зорилт биелж байгаа эсэхийг хэрхэн нягталж байгаа нь чухал юм. Гэсэн хэдий ч 2030 хөтөлбөрийн суурь баримт бичгүүдэд “засгийн газар бүр өөрийн үндэсний зорилтыг тогтоох” гэсэн хүлээлтийг тодорхой тусгасан боловч энэ хүлээлт орхигдсон бололтой.

Олон улсын оролцогчдын гүйцэтгэх үүрэг тодорхой байна. Тэд хяналт-шинжилгээний нийтлэг хүрээ болон улс орнууд зорилтоо мэдээлэх боломжтой үйл явцыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх боломжтой төдийгүй үзүүлэх ёстой. Боловсролын салбарт чухам ийм үйл явц өрнөсөн. ЮНЕСКО-ийн Статистикийн хүрээлэн болон Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайлангийн дэмжлэгтэйгээр ТХЗ 4-ийн үндэсний жишиг үзүүлэлт тогтоох үйл явц нь улс орнуудад зорилтоо албан ёсоор мэдэгдэх боломж олгосон.

Цаашид хоёр зүйлийг хийх шаардлагатай. Нэгдүгээрт, улс орнууд жишиг үзүүлэлт тогтоох үйл явцад илүү идэвхтэй оролцох шаардлагатай. Улс орнуудын 80% нь ТХЗ 4-ийн найман үзүүлэлтийн дор хаяж заримд нь 2030 он гэхэд хүрэх үндэсний зорилтоо тодорхойлж, тогтоох боломжтой зорилтот утгуудын 56%-ийг тогтоогоод байгаа боловч цаашид илүү олон зорилтот утгыг тогтоох боломжтой байна. Зорилт тогтоох үйл явцыг өнгөрсөн хугацаанд гарсан ахицын хурдац болон бусад улсын туршлагад тулгуурлан үндэсний төлөвлөлт, төсөвлөлтийн үйл явцтай илүү нягт уялдуулж болно. Мөн эдгээр зорилтыг улс орныхоо хэмжээнд илүү сайн мэдээлэх боломжтой. Хоёрдугаарт, улс орнууд жишиг үзүүлэлт тогтоох үйл явцыг зөвхөн боловсролоор хязгаарлахгүйгээр олон улсын түвшинд ч идэвхтэй хэрэгжүүлж, 2030 оноос хойших ирээдүйн хөгжлийн аливаа өргөн хүрээний хөтөлбөрийн үндэс болгох шаардлагатай. Улс орнууд өөрсдийн эхлэлийн түвшин, онцлог нөхцөл байдлыг харгалзан хэр өндөр зорилт тавихад бэлэн байгаагаа өөрсдөө шийдэх ёстой. Эдгээр үндэсний амлалтыг нэгтгэн дэлхийн зорилтыг тодорхойлох ёстой.

б. Боловсролын хамрагдалт, шударга тэгш байдалд хяналт-шинжилгээ хийхэд өгөгдлийг илүү үр ашигтай ашиглах шаардлагатай.

2030 хөтөлбөрийн үр дүнд хөгжлийн төрөл бүрийн салбарт гарсан сайжруулалтын нэг нь ахиц дэвшлийг ойлгоход өгөгдлийн олон эх үүсвэрийг ашиглах болсон явдал юм. Энэ чиг хандлага 2000-аад оноос эхэлсэн бөгөөд мэдээлэл бий болгох хэмжээ нэмэгдэж, ийм эх үүсвэрүүдийг хооронд нь холбох арга зүй хөгжсөн нь үүнд түлхэц болсон. Сүүлийн жилүүдэд боловсролын салбарт олон улсын түвшинд мөн чухал алхмууд хийсэн. ЮНЕСКО-ийн Статистикийн хүрээлэн болон Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайлан сургуульд хамрагдаагүй хүн амын хувийг тооцоолох загвар боловсруулсан нь захиргааны болон судалгааны өгөгдлийн эх үүсвэрүүдийн хоорондох хиймэл заагийг арилгаж, ингэснээр эх үүсвэр тус бүрийн боломжийг аль болох бүрэн ашиглахын зэрэгцээ тус бүрийн сул талаас үүдэх асуудлыг зохицуулахад тусалсан. Үүнээс өмнө Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайлан төгсөлтийн хувийг тооцоолох загвар боловсруулсан нь судалгаа болон хүн амын тооллогод байгаа өгөгдлийг хавьгүй илүү үр дүнтэй ашиглах боломж бүрдүүлсэн. Ийм тооцоолол нь эдгээр хоёр гол үзүүлэлтийн чиг хандлагыг нэг мөр хянах боломж олгодог бол зөвхөн жил тус бүрийн тооцоололд тулгуурлах нь үр дүнгийн шуурхай байдал болон харьцуулах боломжийг хязгаарлах байв.

Гэвч боловсролын олон яам ахицад хяналт-шинжилгээ хийхдээ өгөгдлийн олон эх үүсвэрийг хараахан ашигладаг болоогүй, уламжлал ёсоор тулгуурлаж ирсэн захиргааны өгөгдлийн эх үүсвэр нь нөхцөл байдлыг бүрэн харуулж чаддаггүй тохиолдол олон байдаг ч тэдгээрийг сонгосоор байна. Боловсрол дахь шударга тэгш байдалд хяналт-шинжилгээ хийхэд өгөгдлийн олон эх үүсвэр ашиглах нь нэн чухал боловч боловсролын хамрагдалт, боловсрол эзэмшилтийн үзүүлэлтүүдийг улс орон бүрийн нөхцөл байдалд хамааралтай хувь хүний шинжээр задлан гаргахад ашиглаж болох олон төрлийн өгөгдлийн эх үүсвэрийн талаарх мэдлэг, ойлголт хангалтгүй байна. Боловсролын яамд болон үндэсний статистикийн байгууллагуудын хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх шаардлагатай.

в. Боловсролын хамрагдалт, боловсрол эзэмшилтийн статистикийг илүү нарийвчлалтай гаргахын тулд боловсролын хяналт-шинжилгээний хүрээг боловсронгуй болгох шаардлагатай.

Олон улсын хөтөлбөр бүр боловсролын ахицад хийх хяналт-шинжилгээг сайжруулахад хувь нэмэр оруулж, өгөгдөл цуглуулах үйл ажиллагаа сайжирснаар хийх боломжтой болсон өөрчлөлтүүдийг тусгаж ирсэн. Тухайлбал, хамран сургалтын бохир жин болон төгсөх ангид шинээр элсэгчдийн бохир жин нь сургуульд хамрагдаагүй хүн амын хувь болон төгсөлтийн хувиар аажмаар солигдож ирсэн бөгөөд эдгээр үзүүлэлт нь ахицыг илүү бодитой үнэлэхэд хувь нэмэр оруулсан. Гэвч бодлого боловсруулагчдыг зөв мэдээллээр хангахын тулд энэ мэтээр цаашид боловсронгуй болгох шаардлагатай.

Энэхүү тайланд жишээнүүдийг дурдсан. Сургуулийн өмнөх боловсролын хувьд бага боловсролд наснаасаа эрт хамрагдсан байж болзошгүй суралцагчдыг хамруулдаг үчраас дэлхийн түвшний үзүүлэлт нь сургуулийн өмнөх боловсролд хэзээ нэгэн цагт хамрагдаж байсан хүүхдийн эзлэх хувийг хэтрүүлэн тооцдог. Бага болон дунд боловсролын хувьд зөрчил мөргөлдөөнд өртсөн улс орнуудын сургуульд хамрагдаагүй хүүхдүүдэд хяналт-шинжилгээ хийх механизм шаардлагатай байна. Дүнд боловсролын дараах боловсролын хувьд сургууль завсардалтын түвшин өндөр, мөн боловсролд хамрагдах байдал наснаас хамааран улс орнуудын хооронд ихээхэн ялгаатай байдгийг харгалзан ахицыг хэтрүүлэн тооцдог хамран сургалтын бохир жингээс өөр хэмжүүрт шилжиж, оронд нь боловсрол эзэмшилтийг хэмжих үзүүлэлт хэрэглэх цаг болсон. Одоо боловсролын салбарын хамтын нийгэмлэг 2024 онд анх хуралдаж, дараагийнхыг 2027 онд зохион байгуулахаар товлосон Боловсролын өгөгдөл, статистикийн бага хурлын үйл явцаар дамжуулан засаглалын механизмтай болсон бөгөөд улс орнууд ирээдүйн олон улсын боловсролын хөтөлбөрийн хяналт-шинжилгээний хүрээг өргөн оролцоотойгоор боловсруулах хүчин чармайлтаа энэхүү механизмд төвлөрүүлэх шаардлагатай.

Олон улсын хөтөлбөр бүр боловсролын ахицад хийх хяналт-шинжилгээг сайжруулахад хувь нэмэр оруулж, өгөгдөл цуглуулах үйл ажиллагаа сайжирснаар хийх боломжтой болсон өөрчлөлтүүдийг тусгаж ирсэн. Тухайлбал, хамран сургалтын бохир жин болон төгсөх ангид шинээр элсэгчдийн бохир жин нь сургуульд хамрагдаагүй хүн амын хувь болон төгсөлтийн хувиар аажмаар солигдож ирсэн бөгөөд эдгээр үзүүлэлт нь ахицыг илүү бодитой үнэлэхэд хувь нэмэр оруулсан. Гэвч бодлого боловсруулагчдыг зөв мэдээллээр хангахын тулд энэ мэтээр цаашид боловсронгуй болгох шаардлагатай.

Энэхүү тайланд жишээнүүдийг дурдсан. Сургуулийн өмнөх боловсролын хувьд бага боловсролд наснаасаа эрт хамрагдсан байж болзошгүй суралцагчдыг хамруулдаг үчраас дэлхийн түвшний үзүүлэлт нь сургуулийн өмнөх боловсролд хэзээ нэгэн цагт хамрагдаж байсан хүүхдийн эзлэх хувийг хэтрүүлэн тооцдог. Бага болон дунд боловсролын хувьд зөрчил мөргөлдөөнд өртсөн улс орнуудын сургуульд хамрагдаагүй хүүхдүүдэд хяналт-шинжилгээ хийх механизм шаардлагатай байна. Дүнд боловсролын дараах боловсролын хувьд сургууль завсардалтын түвшин өндөр, мөн боловсролд хамрагдах байдал наснаас хамааран улс орнуудын хооронд ихээхэн ялгаатай байдгийг харгалзан ахицыг хэтрүүлэн тооцдог хамран сургалтын бохир жингээс өөр хэмжүүрт шилжиж, оронд нь боловсрол эзэмшилтийг хэмжих үзүүлэлт хэрэглэх цаг болсон. Одоо боловсролын салбарын хамтын нийгэмлэг 2024 онд анх хуралдаж, дараагийнхыг 2027 онд зохион байгуулахаар товлосон Боловсролын өгөгдөл, статистикийн бага хурлын үйл явцаар дамжуулан засаглалын механизмтай болсон бөгөөд улс орнууд ирээдүйн олон улсын боловсролын хөтөлбөрийн хяналт-шинжилгээний хүрээг өргөн оролцоотойгоор боловсруулах хүчин чармайлтаа энэхүү механизмд төвлөрүүлэх шаардлагатай.

г. Зөвхөн гарц, үр дүнд бус, бодлогод мөн хяналт-шинжилгээ хийх шаардлагатай.

2020 оноос хойш Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайлан PEER цахим хуудсаараа дамжуулан боловсролын үр дүнг сайжруулах зорилгоор улс орнуудын баталсан хууль тогтоомж, бодлогыг системтэйгээр судлан үзэж ирсэн. Энэ жил уг ажлыг хоёр чиглэлээр өргөжүүлсэн. Нэгдүгээрт, санхүүжилтийн таван механизмаар дамжуулан шударга тэгш байдлыг сайжруулах бодлогын талаарх улс орнуудын дэлгэрэнгүй танилцуулгуудыг нэмж, тэдгээрийг бодлого нь шударга тэгш байдлыг хангахад хэр чиглэснийг илэрхийлэх индексээр нэгтгэн харуулсан. Хоёрдугаарт, тэгш хамруулалтын асуудлыг авч үзсэн 2020 оны тайланд анх мэдээлсэн бодлогын зарим үзүүлэлтийг энэ жил шинэчилж, 2000 оноос хойших тэдгээрийн хувьслыг харуулснаар урт хугацааны өөрчлөлтийг ойлгоход дөхөм болгосон. PEER-ийн улс орны танилцуулгуудыг анх бодлогын тодорхой чиглэл дэх нөхцөл байдлыг тухайн цаг үеийн байдлаар баримтжуулах зорилгоор боловсруулсан. Энэхүү арга барилыг сонирхох сонирхол нэмэгдсэнээр тодорхой бодлогын ахицыг цаг хугацааны явцад хянах шаардлага Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайлангийн багийн өмнө тавигдах болсон.

Олон улсын бодлогын хэлэлцүүлэгт улс орнуудын бодлогын сонголтын талаар илүү бүтэцчилсэн мэдээлэл

шаардлагатай. Энэхүү тайланд тодорхой дүрдсанчлан энэ нь бодлогуудыг эрэмбэлэх эсвэл ямар бодлого хэрэгжүүлэхийг зааж өгөх ёстой гэсэн үг биш юм. Ижил үр дүнд хүрэх олон арга зам бий. Түүнчлэн бодлого олон тохиолдолд хэрэгждэггүйг өргөн хүрээнд баримтжуулсан байдаг. Гэсэн хэдий ч бодлогын зорилгыг илүү сайн баримтжуулж, системтэй зураглан харуулах нь улс орнууд цаг хугацааны явцад хэрхэн ахиц гаргаж байгааг ойлгох баттай үндэс болж, нөлөөллийн үйл ажиллагааг мэдээллээр хангах, техникийн дэмжлэгийг чиглүүлэхэд тусална. Иймээс гол бодлогууд цаг хугацааны явцад хэрхэн өөрчлөгдөж байгаа болон засгийн газрууд нийтлэг сорилтод хэрхэн хариу арга хэмжээ авч байгаад хяналт-шинжилгээ хийхэд илүү анхаарахыг зөвлөж байна.

БОДЛОГО БОЛОВСРУУЛАХДАА ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ НОТОЛГООНД ХЭРХЭН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ЁСТОЙ ВЭ?

Энэхүү тайланд зарим улс орон боловсролын хүртээмжийг өргөжүүлж, шударга тэгш байдлыг сайжруулахад ижил төстэй бусад орноосоо яагаад хавьгүй хурдан ахиц гаргасны шалтгааныг тодорхойлохыг зорьсон. Эдгээр улс орны туршлагаас олон чухал санаа, сургамж гарч байна. Зарим тохиолдолд, ялангуяа өөрчлөлт нь улс төрийн тодорхой шийдвэр гаргаж, түүнийг үр дүнтэй хэрэгжүүлснээс бий болсон үед учир шалтгаан нь ойлгомжтой байна. Харин зарим тохиолдолд, ялангуяа өөрчлөлт нь олон хүчин зүйл, тэр дундаа боловсролын салбараас гадуурх хүчин зүйлсийн үр дүн байсан үед учир шалтгаан нь төдийлөн тодорхой биш байна.

Тодорхой шийдлүүд эрс сайжрал авчрах боломжид хэт их ач холбогдол өгч ирснийг энэхүү тайлан голлон онцолж байна. Эдгээр шийдлийг ихэвчлэн улс орон даяар хэрэгжүүлэх бодлого болгон ашиглаагүй. Харин сайтар сонгож, зохион байгуулсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж, дараа нь чанартай үнэлгээ хийсэн байдаг. Эдгээр бодлогын туршилт нь ямар чиглэлд өөрчлөлт хийх шаардлагатайг харуулдаг боловч ихэнхдээ тогтолцооны хэмжээнд хэрэгжүүлээгүй. Тэдгээрийг хэрэгжүүлснээс хойш нэг жилийн дотор, бага хүрээнд үнэлсэн байдаг. Үүний эсрэгээр, энэхүү тайланд бариmтжуулсан өөрчлөлт нь илүү урт хугацаанд, ихэвчлэн арав ба түүнээс дээш жилийг хамарч, тогтолцооны түвшинд гарсан байна. Өөрчлөлтийг хөдөлгөгч хүчин зүйлс нь институцийн болон тогтолцооны чадавхыг хөгжүүлэхтэй холбоотой, төдийлөн онцгой бус хүчин зүйлс байсан байж болох юм. Гэсэн хэдий ч бодлого боловсруулагчид үр дүн нь “нотлогдсон” хэмээн өргөн таниулсан энгийн жор мэт шийдлүүдийг дагах сонирхолд автаж болзошгүй. Боловсролын бүх түвшнийг хамарсан дараах дөрвөн зөвлөмж нь үндсэн зарчмуудыг онцолж, болгоомжтой хандахыг зөвлөж байна.

а. Улс орны нөхцөл байдалд тохирсон бодлогын оновчтой сонголт хийх.

Харилцантуршлагасолилцоойройрхонявагдаж,харилцаа холбооны зардал бага болсон өнөө үед ижил төстэй бусад орноос суралцах нь асар үнэ цэнтэй атлаа зардал багатай боломж юм. Бусад улсын туршлага нь санаа авах баялаг эх сурвалж болдог. Гэхдээ эдгээр санааг бусад улс оронд хуулбарлан хэрэгжүүлэх шийдэл гэж үзэх шаардлагагүй. Харин институцийн ямар бүтэц, бодлогын ямар хослол үр дүнтэй байсан (эсвэл байгаагүй), яагаад гэдгийг ойлгохын тулд тэдгээрийг сайтар судлах шаардлагатай. Ингэхдээ бусад улсын бодлогын сонголтын аль бүрэлдэхүүн хэсэг нь өөрийн орны нөхцөлд тохирох, мөн тэдгээр сонголтоор ямар асуудлыг шийдвэрлэхийг зорьсныг эргэцүүлэн авч үзэх шаардлагатай. Энэ нь ойлгомжтой зүйл мэт санагдаж болох ч улс орнууд өөр газар “үр дүнтэй” байсан зүйлийг өөрийн тогтолцоонд шилжүүлэн хэрэглэхэд анхаарах хандлага байдаг, мөн заримдаа олон улсын оролцогчид шууд авч хэрэгжүүлэх бэлэн шийдэл байдаг гэх ойлголтыг улам бататгадаг. Гэвч аливаа бодлогыг тухайн нөхцөлд тохирох эсэхийг нягтлан үзэлгүйгээр тэр чигээр нь авч хэрэгжүүлэх боломжгүй. Бодлого нь тухайн улсын давуу тал, саад бэрхшээлийн өвөрмөц хослолд нийцсэн байх шаардлагатай.

б. Боловсролын бодлогыг шударга тэгш байдлыг хангахад чиглүүлэн боловсруулж, үр дүнг үнэлэх.

Боловсрол дахь шударга тэгш байдлыг хангахад тэгш бус нөхцөлд хүргэж буй хүчин зүйлсийг урьдчилан тооцоолох, илрүүлэх, тэдгээрийн сөрөг нөлөөг нөхөхөд чиглэсэн олон төрлийн бодлогын арга хэрэгсэл шаардлагатай. Үүний тулд хамран сургалт, анги, түвшин дэвшилт, төгсөлтөд дэмжлэг үзүүлэх шударга, хүн бүрийг тэгш хамруулах институц шаардлагатай. Суралцахад бэрхшээлтэй байгаа суралцагчдыг шийтгэх бус, дэмжих шаардлагатай. Түүнчлэн тэгш бус нөхцөлийг төвлөрүүлдэг сонгомол шийдлээс илүү боломжийг нээж өгдөг цогц шийдлийг, хатуу тогтсон байдлаас илүү уян хатан байдлыг эрхэмлэх шаардлагатай. Эдгээр арга барилын заримыг хэрэгжүүлэхэд нөөцийг хамгийн их хэрэгцээтэй хүмүүст дахин хуваарилах зорилгоор орон нутгийн засаг захиргаа, сургууль, суралцагч болон тэдний гэр бүлд мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр санхүүжилт олгох шаардлагатай. Гэхдээ нөөцийг дахин хуваарилах санхүүгийн боломжгүй ядуу орнууд ч тэгш хамруулалтыг тууштай баримталснаар үр дүнд хүрч чадна. Боловсролын олон яаманд зарим чухал зүйл дутмаг хэвээр байна. Тэд өөрсдийн хүчин чармайлтыг нөхөхөд нийгмийн хамгааллын механизм ямар ач холбогдолтойг хүлээн зөвшөөрөх; бусад салбартай уялдаа холбоотой ажиллах; зорилтот бүлэгт чиглүүлэх механизмынхаа чанарыг сайжруулах; шударга тэгш байдлыг хангахад чиглүүлэн боловсруулсан бодлого энэ зорилгодоо бодитоор хүрч байгаа эсэхийг үнэлэх шаардлагатай. Боловсролын бодлогод шударга тэгш байдлыг хангах зарчмыг хэрэгжүүлэх чиглэлээр харилцан суралцах сүлжээ бий болгох нь нэн ач холбогдолтой бөгөөд улс орнуудад бодлогын сонголтоо үнэлэхэд нь тусална.

в. Урт хугацааг харгалзан үзэх: өөрчлөлтөд цаг хугацаа шаардлагатай.

Боловсролын бодлого боловсруулахад тулгардаг бэрхшээлийн нэг нь хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнд хүрэх явц удаан байдаг явдал юм. Өнөөдөр сургуулийн өмнөх боловсролд хамрагдах насанд хүрч буй хүүхэд дүнд боловсролын сүүлийн ангид хүртэл суралцах боломж олдвол тэр хүртэл дунджаар боловсролын зургаан өөр сайд солигдсон байх болно. Гэвч бүх зүйл улам хурдсаж, хүмүүсийн анхаарлаа төвлөрүүлэх хугацаа богиносож байгаа мэт энэ үед хурдан шийдэлд тэмүүлэх хандлага улам нэмэгдэж байгаа мэт байна. Боловсролын хүртээмжийг өргөжүүлж, шударга тэгш байдлыг сайжруулах нь ихэвчлэн улс төрийн нэг мөчлөгт багтах богино хугацааны төслөөс бус, тууштай хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд бий болдог. Үүний тулд институцийг өөрчлөхөд шаардагдах чадавхыг олон жилийн турш тэвчээртэйгээр хөгжүүлэх шаардлагатай. Хамгийн хурдан ахиц гаргасан улс орнууд тогтвортой хөрөнгө оруулалт хийж, үндсэн бодлогоо тууштай хэрэгжүүлж, шинээр бий болж буй нотолгоо, хуримтлагдсан туршлагыг харгалзан тэдгээрийг аажмаар тохируулж ирсэн бөгөөд сургуулийн боловсролтой холбоотой институц, зан үйл, хүлээлт аажмаар өөрчлөгддөгийг хүлээн зөвшөөрсөн байна. Боловсролын гадаад санхүүжилт буурч буй нөхцөлд энэ санаа мөн ач холбогдолтой. Бүр ч хурдан үр дүн эрэлхийлэхийн оронд өнгөрсөн алдаагаа засаж, анхнаасаа тогтвортой үргэлжлэх боломжгүй байсан зардлаар сургуульд хамруулсан хүүхдийн тоогоор үр нөлөөг хэмжихээ зогсоох цаг одоо болжээ.

г. Тэнцвэртэй, уялдаатай бодлогын хослолыг сонгох: ганц шинэчлэлээр хүртээмжийг нэмэгдүүлж, шударга тэгш байдлыг тогтвортой сайжруулах боломжгүй

Энэхүү тайланд багтсан сургуулийн өмнөх, бага ба дунд, дунд боловсролын дараах түвшний, түүнчлэн санхүүжилтээр дамжуулан шударга тэгш байдлыг хангах асуудлаарх бодлогын дөрвөн тойм нь урт хугацааны үр дүнд хүрэхийн тулд бодлогын арга хэрэгслүүдийг хослуулах шаардлагатайг бүгд санууллж байна. Тогтолцооны түвшний арга хэмжээ (хууль тогтоомж, засаглал, ерөнхий санхүүжилттэй холбоотой)-г эрэлтийг дэмжих бодлого (харьцангуй боломж тааруу хүн амын зардлыг бууруулахад чиглэсэн зорилтот санхүүжилт) болон нийлүүлэлтийг дэмжих бодлого (жишээлбэл, дэд бүтэц, зохицуулалт, сургалтын орчин)-той уялдуулан хэрэгжүүлэх шаардлагатай. Бүрэлдэхүүн хэсгүүд нь хоорондоо сайтар уялдсан үр дүнтэй бодлогын багц нь боловсролыг нэгдмэл тогтолцоо гэж авч үздэг. Энэ нь хүртээмжийг шударга тэгш байдал, чанартай хамтад нь авч үзсэнээр суралцагчид сургуулийн боловсролын тогтолцоонд орсны дараа суралцах явцдаа ахиж, төгсөхөд нь дэмжлэг үзүүлдэг.

ТХЗ-ЫН ХҮРЭЭН ДЭХ БОЛОВСРОЛЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ

2030 оны эцсийн хугацаа хүртэл таван жил үлдээд байгаа энэ үед өгөгдлийн хомсдол ахицад хяналт-шинжилгээ хийхэд томоохон бэрхшээл учруулсан хэвээр байна. Өгөгдлийн бэлэн байдал үзүүлэлт бүрээр ихээхэн ялгаатай байна. Сургуульд хамрагдаагүй хүн амын хувь (үзүүлэлт 4.1.4)-ийн өгөгдөл улс орнуудыг хамгийн өргөн хамардаг бөгөөд улс орнуудын бараг 95% нь сүүлийн үеийн өгөгдөлтэй байгаа бол бага насны хүүхдийн хөгжил (үзүүлэлт 4.2.1) нь гол төлөв нэг эх үүсвэр (HYTC/MICS)-т тулгуурладаг учраас өгөгдөлтэй улс орны хамрах хүрээ хязгаарлагдмал байна. Өгөгдлийн бэлэн байдал бусад шинжээр (жишээлбэл, хүйсээр задалсан өгөгдөл нь байршил болон хөрөнгө чинээгээр задалсан өгөгдлөөс хавьгүй түгээмэл), мөн улс орны орлогын түвшнээр ялгаатай байна.

ЗОРИЛТ 4.1. БАГА, ДУНД БОЛОВСРОЛ

Энэхүү тайланд сургуульд хамрагдалт болон төгсөлтийн үндсэн чиг хандлагыг авч үзсэн. Эргэн сануулахад, 2024 онд сургуульд хамрагдаагүй хүн ам 273 сая байсны 140 сая нь эрэгтэй, 133 сая нь эмэгтэй байв. Насны бүлгээр авч үзвэл бага боловсролын насны 79 сая, суурь боловсролын насны 64 сая, бүрэн дунд боловсролын насны 130 сая хүүхэд, өсвөр үеийнхэн сургуульд хамрагдаагүй байна. Сургуульд хамрагдаагүй хүн амын тоо 2017 оноос хойш нэмэгдэж байгаа боловч эзлэх хувь нь 2015 оноос хойш 17 орчим хувьд тогтвортой байгаа бөгөөд өндөр орлоготой орнуудад 3%, бага орлоготой орнуудад 36% байна. Дэлхийн хэмжээнд 2024 онд тухайн насны бүлгээс боловсролын түвшин бүрийг хугацаандаа төгссөн хүмүүсийн эзлэх хувь бага боловсролд 88%, суурь боловсролд 78%, бүрэн дунд боловсролд 61% байв. Бага орлоготой орнуудад эдгээр үзүүлэлт харгалзан ердөө 60%, 37%, 20% байсан боловч сургуульд хожуу хамран суралцах, анги улиран суралцах зэргээс шалтгаалан олон суралцагч төгсөх ангидаа хэдэн жилээр хоцорч хүрдгийг харгалзан үзвэл эцэстээ төгсөх хувь 71%, 46%, 25% байна гэж тооцоолжээ.

Суралцахуйн үр дүнгийн өгөгдлийг харьцангуй цөөн давтамжтай шинэчилдэг. Тухайлбал, дэлхийн хэмжээнд бага боловсролын төгсгөлд суралцагчдын 58% нь унших чадварын, 44% нь математикийн чадамжийн наад захын түвшинд хүрсэн гэж тооцоолж байгаа бөгөөд эдгээр үзүүлэлтийг КОВИД-19 цар тахлаас хойш шинэчлээгүй байна. Суурь боловсролын төгсгөлд эдгээр үзүүлэлт харгалзан 64%, 51% болж нэмэгддэг. Энэ нь уг тооцоололд нийт хүн амыг бус, суралцагчдыг хамруулдагтай холбоотой бөгөөд бага болон дундаас доогуур орлоготой орнуудад


суурь боловсролын төгсгөл хүртэл суралцаж чаддаггүй хүн амын дөрөвний нэгийг ийнхүү тооцооллоос хасдаг. Тэдний хувьд чадамжийн наад захын түвшинд хүрэх магадлал мөн бага байх байсан.

Дундаас дээгүүр болон өндөр орлоготой орнуудын олон улсын үнэлгээгээр сүүлийн жилүүдэд бууралт ажиглагдаж байна. 2024/5 оны *Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайланд* авч үзсэн 2022 оны Сурлагын амжилтын олон улсын үнэлгээний (PISA) үр дүнгээс харахад унших чадварын хувьд энэхүү бууралт КОВИД-19 цар тахлаас өмнө эхэлсэн бол математикийн хувьд КОВИД-19 цар тахлаас шалтгаалсан бололтой. 2023 оны Математик, байгалийн ухааны олон улсын чиг хандлагын судалгааны (TIMSS) өгөгдөл PISA-гаас цөөн тооны улсыг хамарсан хэдий ч математикийн хувьд энэ дүгнэлтийг баталж байна. TIMSS-ийн дүнгээр математикийн чадамжийн наад захын түвшинд хүрсэн суралцагчдын эзлэх хувь 2011 онд 51% байснаа 2019 онд 56% болж өссөн боловч 2023 онд эргэн 52% болж буурсан байна. Энэ гурван оны өгөгдөл нь байгаа улс орнуудын түүвэрт энэ үзүүлэлт гол төлөв дундаас дээгүүр орлоготой цөөн тооны орнуудад 26% байсан бол өндөр орлоготой орнуудад 60% хүрч хэлбэлзэж байв.

ЗУРАГ 10:

Чинээлэг орнуудад суурь боловсролын төгсгөлд математикийн чадамжийн наад захын түвшинд хүрсэн суралцагчдын эзлэх хувь 2019 онд өссөн ч дараа нь 2011 оны түвшинд эргэн буурчээ

Сонгосон дунд болон өндөр орлоготой орнуудын 8 дугаар ангийн суралцагчдаас математикийн чадамжийн наад захын түвшинд хүрсэн суралцагчдын эзлэх хувь, 2011, 2019, 2023 он



БХШ-ний статистик: https://bit.ly/GEM2026_Summary_fig10

Эх сурвалж: TIMMS-ийн өгөгдөлд Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайлангийн багшийн хийсэн шинжилгээ.

ЗОРИЛТ 4.2. БАГА НАСНЫ ХҮҮХЭД

“Бага насны хүүхдийн хөгжлийн индекс 2030”-аар хэмжсэнээр эрүүл мэнд, суралцахуй, сэтгэлзүй-нийгмийн сайн сайхан байдлын хөгжлийн зохих түвшинд байгаа 5 хүртэлх насны хүүхдийн тоог мэдээлсэн цөөн тооны улсын дүн ихээхэн ялгаатай байна. Кот-д’Ивуар, Мозамбикт 40%-аас бага байгаа бол Ямайка, Тринидад ба Тобагод 90%-аас дээш байна. Хүйсээрх ялгаа ихэвчлэн бага байдаг бол хөрөнгө чинээгээр ялгаа их байна. Нигерид хамгийн чинээлэг квинтилд багтах хүүхдүүдийн 77% нь хөгжлийн зохих түвшинд байгаа бол хамгийн ядуу квинтилд энэ үзүүлэлт 30% байна.

Энэхүү тайланд өмнө дурдсанчлан, бага боловсролд элсэхээс нэг жилийн өмнөх зохион байгуулалттай сургалтад хамрагдалт бага орлоготой орнуудад 2008-2023 онд 29%-аас 48% болж мэдэгдэхүйц нэмэгдсэн хэдий ч дэлхийн хэмжээнд 2015 оноос хойш 75 орчим хувьд өсөлтгүй хэвээр байна. Бага боловсролд наснаасаа эрт элссэнийг тооцож залруулбал хүүхдүүдийн ердөө 60 орчим хувь нь сургуулийн өмнөх боловсролд дор хаяж нэг жил хамрагдаж байна. Сургуулийн өмнөх боловсролыг үнэ төлбөргүй эсвэл заавал эзэмшихээр баталгаажуулсан орнуудад хамрагдалт мэдэгдэхүйц өндөр байгаа нь хамрагдалтыг дэмжсэн бодлогын зохицуулалт чухал болохыг санууллж байна.

ЗОРИЛТ 4.3. ТЕХНИКИЙН, МЭРГЭЖЛИЙН, ДЭЭД, НАСАНД ХҮРЭГЧДИЙН БОЛОВСРОЛ

Энэхүү тайланд өмнө дурдсанчлан, дээд боловсролын хамран сургалт 2000 оноос хойш орлогын бүх бүлэгт нэмэгдэж, 2024 онд 44%-д хүрсэн бөгөөд бага орлоготой орнуудад 15%-аас бага, өндөр орлоготой орнуудад 80%-аас дээш байна. Хамгийн хурдацтай өсөлт дундаас дээгүүр орлоготой орнуудад ажиглагдсан бөгөөд үүний дотор Хятад Улс зэрэг олон улс оронд дээд боловсролын өргөн хүрээний хамрагдалтын түвшинд ойртож байна.

Дэлхийн хэмжээнд 15–24 насны залуучуудын техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтад хамрагдалт 2000-2024 онд 2.7%-аас 4.2% болж өсжээ. Харин 25–64 насны насанд хүрэгчдийн боловсрол, сургалтад хамрагдалт дэлхийн хэмжээнд 2000-2024 онд 2%-аас 2.4% болж нэмэгдсэн байна. Өндөр орлоготой улс орнуудад хамрагдалтын түвшин хамгийн өндөр төдийгүй өсөлт нь ч хамгийн их байсан бөгөөд 4.6%-аас 6.7% болж өсжээ. Үүний эсрэгээр, дундаас доогуур орлоготой улс орнуудад хамрагдалтын түвшин ердөө 1.2% буюу бага түвшинд хэвээр, өөрчлөлтгүй байна.

ЗОРИЛТ 4.4. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ УР ЧАДВАР

Залуучууд болон насанд хүрэгчдийн тоон технологийн хэрэглээ хурдацтай өөрчлөгдөж байгаатай уялдуулан мэдээлэл, харилцаа холбооны технологийн ур чадварын дэлхийн үзүүлэлтийн тодорхойлолтыг шинэчлэн боловсронгуй болгож ирсэн. Дэлхийн түвшинд тайлагнахад тулгардаг нэг томоохон сул тал нь өгөгдлөө тайлагнадаг улс орнуудын 85 хувь нь дундаас дээгүүр эсвэл өндөр орлоготой орны ангиллынх учраас эдгээр тооцоолол нь дэлхийн нийт улс орны нөхцөл байдлыг төлөөлөх чадваргүй байна. 2022–2024 оныг хамарсан хамгийн сүүлийн үеийн өгөгдлөөс үзэхэд тоон технологитой холбоотой зарим үйлдлийг хүмүүс өргөн хүрээнд гүйцэтгэж чаддаг боловч харьцангуй ахисан түвшний үйлдлийг гүйцэтгэх чадвар хязгаарлагдмал хэвээр байна. Улс орнуудын медиан үзүүлэлтээр насанд хүрэгчдийн 68% нь нийгмийн сүлжээ ашигладаг, 54% нь файл хуулж, зөөж чаддаг, 33% нь цахим танилцуулга бэлтгэж чаддаг, 24% нь цахим орчин дахь мэдээллийн үнэн зөвийг нягталдаг байна. Харин ердөө 6% нь программчлалын ур чадвартай байв.

ЗОРИЛТ 4.5. ШУДАРГА ТЭГШ БАЙДАЛ

Хүйсийн ялгаа дунджаар бага боловч орлогын түвшнээс хамааран ихээхэн ялгаатай байна. Бага орлоготой орнуудад бүрэн дунд боловсрол төгссөн 100 залуу эрэгтэй тутамд 79 залуу эмэгтэй ногдож байгаа бол өндөр орлоготой орнуудад 100 залуу эрэгтэй тутамд 106 залуу эмэгтэй бүрэн дунд боловсрол төгсөж байна. Байршлын ялгаа үүнээс илүү их байна. Бага орлоготой орнуудад хот суурин газрын бүрэн дунд боловсрол төгссөн 100 залуу тутамд хөдөө орон нутгийн 30 залуу бүрэн дунд боловсрол төгсөж байна. Хөрөнгө чинээ нь тэгш бус байдалд нөлөөлж буй хамгийн хүчтэй хүчин зүйл хэвээр байна. Бага орлоготой орнуудад хамгийн чинээлэг квинтилээс боловсролын түвшин бүрийг төгссөн 100 хүн тутамд хамгийн ядуу квинтилээс тухайн түвшнийг төгссөн хүний тоо бага боловсролд 40, суурь боловсролд 20, бүрэн дунд боловсролд 13 байна. Өндөр орлоготой орнуудад ч хамгийн чинээлэг квинтилийн бүрэн дунд боловсрол төгссөн 100 залуу тутамд хамгийн ядуу квинтилийн 66 залуу бүрэн дунд боловсрол төгсөж байна.

ЗОРИЛТ 4.6. ЗАЛУУЧУУД БОЛОН НАСАНД ХҮРЭГЧДИЙН БИЧИГ ҮСЭГ ТАЙЛАГДАЛТ

Дэлхийн хэмжээнд залуучуудын бичиг үсэг тайлагдалтын түвшин 2000-2024 онд 90%-аас 92%, насанд хүрэгчдийнх 81%-аас 88% болж өссөн бөгөөд үүнд дундаас доогуур орлоготой орнуудад гарсан ихээхэн ахиц голлон нөлөөлжээ. Гэвч бага орлоготой орнуудын үзүүлэлт хоцорсон хэвээр байгаа бөгөөд 2024 онд дөрвөн залуу тутмын нэг нь бичиг үсэг тайлагдаагүй гэсэн тооцоо байна.

Дэлхийн хэмжээнд бичиг үсэг тайлагдаагүй залуучуудын тоо 2000-2024 онд 143 сая байснаас 86 сая болж буурсан гэж тооцоолж байгаа боловч бага орлоготой орнуудад хүн амын өсөлтийн хурд бичиг үсэг тайлагдалтын ахицын хурднаас давснаас энэ тоо 30 саяас 37 сая болж өсжээ.


ЗОРИЛТ 4.7. ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ БА ДЭЛХИЙН ИРГЭНШИЛ

2025 онд ТХЗ-ын үзүүлэлтүүдэд хийсэн хоёр дахь бөгөөд эцсийн Иж бүрэн үнэлгээний хүрээнд зорилт 4.7-ийн дэлхийн түвшний үзүүлэлтийг өргөжүүлж, ТХБ-ын сургалтын хөтөлбөрийг хамарсан шууд хэмжүүрийг шинээр нэвтрүүлсэн. Уг хэмжүүрээр үндэсний сургалтын хөтөлбөрийн хүрээ болон 3, 6, 9 дүгээр ангийн байгалийн ухаан, нийгмийн ухааны хичээлийн хөтөлбөрт байгаль орчин ба тогтвортой байдал, уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдал гэсэн гурван чиглэлийн түлхүүр үг туссан эсэхийг хэмждэг. 110 улсын үр дүнгээс харахад эдгээр чиглэлийн нийт хамрах хүрээ болон хоорондын тэнцвэр улс орнуудаар ихээхэн ялгаатай байна. Улс орнуудын хоорондын ялгаа нь тухайн чиглэлийг тусгасан орнуудын хувьд хэр хэмжээнд тусгасны томоохон ялгаанаас бус, харин тухайн чиглэлийг огт дурдсан эсэхээс голлон шалтгаалж байна. Уур амьсгалын өөрчлөлт нь сургалтын хөтөлбөрт хамгийн бага тусгагдсан чиглэл бөгөөд 3 дугаар ангийн хичээлийн хөтөлбөрт 78 улсад, 6 дугаар ангид 50 улсад, 9 дүгээр ангид 28 улсад огт тусгагдаагүй байна. Үндэсний сургалтын хөтөлбөрийн хүрээнд ч 50 гаруй улс биологийн олон янз байдал болон/эсвэл уур амьсгалын өөрчлөлтийг тусгаагүй байна. Хамрах хүрээ ангийн түвшин ахих тусам ерөнхийдөө нэмэгддэг боловч жигд бус тусгасан байдал нь эдгээр чиглэлийг сургалтын хөтөлбөрт системтэйгээр нэвтрүүлэхээс илүүтэй заримыг нь сонгон тэргүүлэх ач холбогдол өгч байгааг харуулж байна.

ЗУРАГ 11:

Улс орнуудын тал хувь нь бага боловсролын төгсөх үеийн сургалтын хөтөлбөртөө уур амьсгалын өөрчлөлтийн талаар огт дурдаагүй байна

Үндэсний сургалтын хөтөлбөрийн хүрээ болон 3, 6, 9-р ангийн хичээлийн хөтөлбөрт сонгосон түлхүүр үгсийг тусгасан улс орны тоо, чиглэлээр, 2024 он



БХШ-ний статистик: https://bit.ly/GEM2026_Summary_fig11

Эх сурвалж: Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайлан, МЕССЕ төсөл, ЮНЕСКО-ийн мэдээллийн санд Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайлангийн багийн хийсэн шинжилгээ.

ЗОРИЛТ 4.А. БОЛОВСРОЛЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ БА СУРГАЛТЫН ОРЧИН

Бага орлоготой орнуудын сургуулийн дэд бүтэц, байгууламж хангалтгүй хэвээр байна. 2024 онд бага сургуулиудын ердөө 40% нь гар угаах газартай (2015 оноос хойш 4 хувийн пунктээр өссөн), 52% нь ундны усны хүртээмжтэй (2015 оноос хойш 11 хувийн пунктээр өссөн) байв. Цахилгааны хүртээмж 2015 оноос хойш ерөнхийдөө өөрчлөгдөөгүй, 28% хэвээр байгаа бол дунд орлоготой орнуудад 66%-аас 82% болж мэдэгдэхүйц нэмэгджээ. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ өргөжиж, 2024 онд дэлхийн хэмжээнд 466 сая хүүхдийг хамарсан нь 2020 оноос хойш 20%-аар өссөн үзүүлэлт юм. Хамгийн их өсөлт бага орлоготой орнуудад гарч, сургуулийн хоолны үйлчилгээнд хамрагдалт ердөө хоёр жилийн дотор 60%-аар нэмэгджээ.

Сургалтын орчинд гарч буй хүчирхийлэлд мөн дэлхийн хэмжээнд хяналт-шинжилгээ хийдэг. Өгөгдөл нь байгаа 83 улсын 70-д нь сүүрь боловсролын суралцагчдын 50 гаруй хувь нь дээрэлхэлтэд өртөж байсан гэж мэдээлжээ. 2024 онд 69 улсад боловсролд чиглэсэн 3,909 халдлага бүртгэгдсэн нь Боловсролыг халдлагаас хамгаалах дэлхийн эвсэл 2013 онд энэ талаарх мэдээллийг гаргаж эхэлснээс хойш бүртгэгдсэн хамгийн олон тохиолдол юм.

ЗОРИЛТ 4.В. ТЭТГЭЛЭГ ЗОРИЛТ

2023 онд дэлхийн хэмжээнд дээд боловсролын суралцагчдын 2.8% нь гадаад улсад суралцаж байсан бөгөөд энэ үзүүлэлт Жижиг арлын хөгжиж буй орнуудад (7.2%), Сахарын цөлөөс урагших Африкт (4.9%) илүү өндөр байв. Тэтгэлэг хүртэгч нэг бүрийн талаарх иж бүрэн өгөгдөл байхгүй тул дэлхийн түвшний үзүүлэлтээр зөвхөн тэтгэлэгт зориулсан хөгжлийн албан ёсны тусламжийг хянадаг. 2024 онд боловсролын салбарын тэтгэлэгт 1.7 тэрбум ам.доллар олгосон бол бүх салбарын тэтгэлгийг хамруулан тооцоход энэ дүн 1.9 тэрбум ам.долларт хүрчээ. Санхүүжилт 2015–2019 онд өссөний дараа КОВИД-19 цар тахлын үед буурч, 2023 он гэхэд сэргэж, улмаар 2024 онд дахин буурсан байна.

4.С. БАГШ НАР

Дэлхийн хэмжээнд бага боловсролын багш нарын 90 орчим хувь нь тухайн улсад тавигддаг боловсролын зэрэгт тавих наад захын шаардлагыг, 82% нь мэргэжлийн мэргэшлийн шаардлагыг хангаж байна. Бага орлоготой орнуудад боловсролын зэрэгт тавих шаардлага хангасан бага боловсролын багш нарын эзлэх хувь 2013-2024 онд 89%-аас 78% болж буурчээ. Өндөр орлоготой орнуудад мэргэжлийн мэргэшлийн шаардлага хангасан бага боловсролын багш нарын эзлэх хувь 97%-аас 92% болж буурсан байна. Багшид тавих үндэсний стандарт улс орон бүрд ихээхэн ялгаатай бөгөөд бага боловсролын багш нараас бакалаврын зэрэгтэй байхыг шаарддаг бага орлоготой орнууд ердөө 11% байхад өндөр орлоготой орнуудын 79% нь ийм шаардлага тавьдаг.

САНХҮҮЖИЛТ

2024 онд боловсролд зарцуулсан улсын төсвийн зардлын медиан ДНБ-ий 4.2% байсан нь 2010 оны 4.3%-аас буурсан, улсын төсвийн нийт зардалд эзлэх хувь 12.6% болж, 2010 оны 14.4%-аас буурчээ. 2015 оны харьцуулах боломжтой өгөгдөл бүхий 159 улсын 54% нь 2023 он гэхэд боловсролын зардлын ДНБ-д эзлэх хувийг, 64% нь улсын төсвийн нийт зардалд эзлэх хувийг бууруулсан байна. Өгөгдөл нь байгаа 183 улсаас ердөө 41 улс (22%) нь ДНБ-ий 4-өөс доошгүй хувь, улсын төсвийн нийт зардлын 15-аас доошгүй хувийг боловсролд зарцуулж, олон улсын хоёр жишиг түвшнийг хоёулыг хангасан байна.

Хөгжлийн албан ёсны тусламж бууралтын үед ороод байна. Тусламжийг салбарт хуваарилах боломжтой тусламжаар (2024 онд 12.2 тэрбум ам.доллар, өөрөөр хэлбэл суралцагчид ногдуулан тооцсон зардлыг хасаж, бага, дунд болон дунд боловсролын дараах боловсролд зориулсныг тодорхой заасан тусламж) эсвэл улс орны түвшинд хөтөлбөрчлөх боломжтой тусламжаар (2024 онд 10.5 тэрбум ам.доллар, өөрөөр хэлбэл урьдчилан тооцоолох боломжтой бөгөөд улс орны түвшний төлөвлөлтөд ашиглах боломжтой гэж үзсэн санхүүжилт тул суралцагчид ногдуулан тооцсон зардал болон тэтгэлгийг хассан) тодорхойлсон аль ч тохиолдолд 2023–2024 онд тусламж 8%-аар буурсан байна. Суурь (basic) боловсролд үзүүлсэн тусламж 16%-аар буурчээ. Салбарт хуваарилах боломжтой тусламжид боловсролын эзлэх хувь 7.5% болж буурсан нь сүүлийн хорин жилийн хамгийн доод түвшин юм.

Дэлхийн хэмжээнд өрхөөс гаргаж буй зардал боловсролын нийт зардлын дөрөвний нэг орчим хувийг эзэлдэг боловч энэ зардлын ачаалал харилцан адилгүй байна. Бага орлоготой орнуудад өрхүүд нийт хэрэглээний зардлынхаа 0.5%, дундаас доогуур орлоготой орнуудад 2.5%, дундаас дээгүүр орлоготой орнуудад 1.4%, өндөр орлоготой орнуудад 1.3%-ийг боловсролд зарцуулж байна.

Хүртээмж ба шударга тэгш байдал

2030 ОН ХҮРТЭЛХ УРВУУ ТООЛОЛ

2030 оны эцсийн хугацаа ойртож, олон талт хамтын ажиллагаа дарамтад орж буй энэ үед улс орнууд ТХЗ 4-ийг хэрэгжүүлэхдээ туулж ирсэн олон янзын замналыг ойлгохын тулд өгөгдөл болон өгүүлэмжийг ашиглах шаардлагатай байна. Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайлангийн энэ удаагийн хэвлэл нь боловсролын хүртээмж ба шударга тэгш байдал (2026), чанар ба суралцахуй (2027), нийцэл (2028/9)-ийн ахицыг дүгнэх зорилготой, гурван хэсгээс бүрдэх 2030 он хүртэлх урвуу тоолол цувралын эхнийх юм. Эдгээр гурван тайлан нийлээд боловсролын тогтолцоо хэрхэн суралцах боломжийг нээж, мэдлэгийг хөгжүүлэн, тодорхой бус байдал ихтэй дэлхий ертөнцөд суралцагчдыг бэлтгэж байгааг үнэлэх бөгөөд ингэснээр 2030 оноос хойших боловсролын хөтөлбөрийн талаарх хэлэлцүүлгийн хүрээг тодорхойлоход хувь нэмэр оруулна.

Үүний дагуу 2026 оны Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайлан нь өнгөрсөн 25 жилийн хугацаанд сургуулийн өмнөх, бага, дунд боловсрол, мөн дунд боловсролын дараах боловсролын хамрагдалтын хувьд, тэр дундаа хүйс, байршил, эдийн засгийн боломж, хөгжлийн бэрхшээлээр ялгаварлах байдлыг бууруулахад ижил төстэй бусад орноос илүү хурдацтай ахиц гаргасан улс орнуудыг, мөн харьцангуй бага ахиц гаргасан бололтой улс орнуудыг тодорхойлжээ.

Үүний дараа газар зүйн болон улс орны орлогын түвшний ялгаатай нөхцөлийг хамарсан улс орны кейс судалгааны төлөөлөхүйц түүвэрт тулгуурлан ийм үр дүнтэй холбоотой боловсролын болон боловсролын бус хүчин зүйлсийг шинжилсэн. Нарийвчлан авч үзэхэд албан ёсны статистикийн дүр зураг ерөнхийдөө бататгагдаж байгаа боловч өөрөөр тайлбарлах боломжууд ч илэрч байгаа нь ирэх жилүүдэд хяналт-шинжилгээг хэрхэн сайжруулах талаар санал дэвшүүлэх эхлэл болж байна.

Эцэст нь тайланд кейс судалгааны үр дүнг өргөн хүрээний судалгаанаас гарсан дүгнэлттэй нэгтгэн авч үзсэн. Тусгаар бөгөөд зөвхөн тухайн нөхцөлд тохирох шинжтэй байж болох шилдэг туршлагыг эрэлхийлэхийн оронд өөрчлөлтийг өргөн хүрээнд урт хугацаанд тогтвортой үргэлжлүүлэхэд юу нөлөөлдгийг ойлгох шаардлагатай гэж энэхүү тайланд үзэж байна. Ийм ахиц нь дотоодын бодлогын уялдаа холбоо, гадаад нөхцөл байдалд нийцүүлэн хариу арга хэмжээ авах чадвар, шударга тэгш байдлын төлөө урт хугацаанд тууштай ажиллах явдлаас бий болдог.

PEER вэбсайтад зориулсан улс орон тус бүрээр гүнзгийрүүлэн авч үзсэн хоёр тоймд сүүлийн 25 жилийн хугацаанд хууль тогтоомж, бодлого хэрхэн өөрчлөгдөж ирснийг авч үзжээ. Нэгдүгээрт, улс орнууд шударга тэгш үр дүнг дэмжихийн тулд боловсрол, нийгмийн хамгааллын нөөцийг орон нутгийн засаг захиргаа, сургууль, суралцагчид болон тэдний өрхөд хэрхэн зориудаар дахин хуваарилж ирснийг судалж, бодлогын зорилгыг илэрхийлэх индексийг санал болгосон; хоёрдугаарт, улс орнууд тэгш хамруулах боловсролын талаарх хууль тогтоомж, бодлогыг хэрхэн баталж, тохируулан өөрчилж ирснийг авч үзсэн байна.

unesco
Global Education Monitoring Report

4 QUALITY EDUCATION

Sustainable Development Goals

www.unesco.org/publications • www.unesco.org/gem-report